**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**
**Баагаагийн БАТТӨМӨР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-75-22, Факс: 32-70-16
E-mail: battumur@parliament.mn
http://www.parliament.mn

2019.07.02 № 7504

танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан бүрэн эрхийнхээ дагуу Актив удирдлагын компанийн тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Б.БАТТӨМӨР
Ж.БАТ-ЭРДЭНЭ
Л.МӨНХБААТАР
З.НАРАНТУЯА
М.ОЮУНЧИМЭГ
Я.СОДБААТАР

000247

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**
**Баагаагийн БАТТӨМӨР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-75-22, Факс: 32-70-16
E-mail: battumur@parliament.mn
http://www.parliament.mn

2019.06.21 № 7037

танай ________ -ны № ________ -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тов тогтоолгох тухай

Актив удирдлагын компанийн тухай хуулийн төсөл болон бусад баримт бичгийг хүргүүлж байна. Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт ..109....... хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.БАТТӨМӨР

УХА0317

МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2019 он 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар ХЭГ/1697

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТТӨМӨР ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0006921

# МОНГОЛ УЛСЫН
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
# ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэлд:

"XI.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал дүгнэлтийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төслийг хэлэлцээд дараахь саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1. Хуулийн төслийн үзэл баримтлалын "Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага" хэсэгт "Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийн 2 дугаар хавсралтын 4-т "арилжааны банкуудын оролцоотойгоор активын удирдлагын институци байгуулж, банкны системийн чанаргүй зээлийн хэмжээг бууруулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах..." гэж заасан байна.

Гэтэл банкуудад үүссэн чанаргүй зээлийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд шилжүүлэхээр зохицуулсан нь улсын төсөв, татвар төлөгчдийн хөрөнгөөр чанаргүй зээлийг хариуцах, банкууд чанаргүй зээлийн эрсдэлээ төрийн өмчийн оролцоотой институцид үүрүүлэх сонирхлыг бий болгох, банкуудын зээлийн үйл ажиллагааны зөрчил дутагдал цаашид хэвээр үргэлжлэх сөрөг үр дагавар дагуулж болзошгүй байна.

Иймд Засгийн газрын зээл, дамжуулсан зээл, санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн чанаргүй актив, дампуурсан банк, хадгаламж зээлийн хоршоодын чанаргүй активыг зах зээлийн зарчмаар зохицуулах нь зүйтэй.

2. Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь хэсэгт чанаргүй активыг шилжүүлэн авах нөхцөл, шаардлагыг хэт өндөр тогтоосон нь цаашид банкууд зээлийн барьцаа хөрөнгийг зах зээлийн үнээс доогуур үнэлэх нөхцөлийг бүрдүүлж, зээлдэгч нарт дарамт учруулахаар байна.

Түүнчлэн хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт Актив удирдлагын компанийн үйл ажиллагааг дан ганц банкны чанаргүй активыг шилжүүлэн авсан хүрээгээр хязгаарлан зохицуулсан, банк бус санхүүгийн байгууллага, зээлийн үйлчилгээ үзүүлдэг бусад хуулийн этгээдийн чанаргүй активыг хэрхэн зохицуулах талаар зохицуулалт байхгүй байна.

3. Хуулийн төсөл болон түүний үзэл баримтлалд банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгыг тодорхойлсон боловч зөвхөн нэг компанийн үйл ажиллагааг зохицуулсан, хуулийн төслийн зорилгод хамаарах асуудлыг бүрэн зохицуулаагүйгээс гадна хуулийн нэр болон үзэл баримтлалд нийцээгүй асуудлыг тусгасан байх тул хуулийн төслийг бүхэлд нь дахин нягтлах шаардлагатай байна." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.БАТТӨМӨР

УХА0317

# АКТИВ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

## Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Актив удирдлагын тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаагаар Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангаж эдийн засгийг сэргээн иргэд, айл өрх, аж ахуйн нэгжийг санхүүгийн гүн хямралд орохоос урьдчилан сэргийлэх үүднээс Банкны салбарын тогтвортой байдлыг бүрдүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсэж байгаа тул Актив удирдлагын тухай хуулийн төсөл шинээр боловсруулах нь зүйтэй гэж үзсэн билээ.

Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийн 2 дугаар хавсралт болох тэргүүн ээлжинд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн жагсаалтын 4-т "арилжааны банкуудын оролцоотойгоор активын удирдлагын институц байгуулж, банкны системийн чанаргүй зээлийн хэмжээг бууруулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах Актив удирдлагын компанийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж өргөн мэдүүлэх", Улсын Их Хурлын 2016 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл"-ийн 3.3-т "санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчинг бүрдүүлэх" гэж тус тус заасан.

Дээр дурьдсан шийдвэрүүд нь Актив удирдлагын тухай шинэ хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болсон.

*Хуулийн төсөл боловсруулах нийгэм эдийн засгийн хэрэгцээ шаардлага*

Монгол Улсын эдийн засаг бүхэлдээ банк санхүүгийн системийн тогтвортой үйл ажиллагаанаас шууд хамааралтай байгаа нь банкны системийн чанаргүй зээлийг олон улсын сайн жишиг бүхий эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар шийдвэрлэж хүндрэлийг богино хугацаанд даван туулах нийгэм эдийн засгийн дараах шаардлагыг үүсгээд байна:

1.Банкны системд хуримтлагдсан чанаргүй зээлийн үлдэгдэл 2016 оны 12 сарын байдлаар эргэн төлөлтийн доголдолтой зээл нийт зээлийн 14.2% буюу 1.7 их наяд төгрөг гэсэн тоон мэдээлэл байгаа боловч энэ нь чанаргүй зээлийн бодит хэмжээг дутуу илэрхийлж байна гэж урьдчилан тандан судалгаагаар үзсэн байна. Учир нь банкууд бүтцийн өөрчлөлт хийсэн зээлээ энгийн зээл гэж бүртгэх боломжтой байсан бөгөөд чанаргүй зээлийг хойшлуулсан сууриар бүртгэхийг зөвшөөрдөг. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2016 оны эцэст өнгөрсөн 6 жилийн хугацааны хамгийн өндөр түвшинд хүрч, харгалзан 7.1 хувь, 7.2 хувь болсон байна. 2018 оны 4 дугаар сард системийн нийт зээлийн 7.4 хувь нь чанаргүй буюу 1.06 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь банкуудын төлбөрийн чадвар, улмаар нийт эдийн засагт сөрөг нөлөөтэй болно.

2.Чанаргүй зээл хэт өссөнөөр эдийн засагт дараах нөлөөллийг үзүүлнэ:

*- банкны зээл олгох боломжийг бууруулах*

Банкны зээл олгох чадвар буурах нь аж ахуйн нэгж болон иргэд банкнаас мөнгө зээлж авахад хүндрэл учрах хэлбэрээр хэрэглээ болон хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж, эдийн засгийн уналт хямралаас гарах боломж нөхцөлийг удаашруулдаг. Мөн экспортлогчид банкнаас худалдааны зээлийн санхүүжилт авахад хүндээр тусах улмаар экспортод сөргөөр нөлөөлдөг.

*- банкийг хямралд оруулж болзошгүй*

Банкны санхүүгийн тайлан муудаж, банк чанаргүй зээлээс алдагдал хүлээхэд хадгаламж эзэмшигч нар банкны төлбөрийн чадварт эргэлзэж, банкнаас хадгаламжаа татаж эхэлдэг. Эдийн засгийн үйл ажиллагаа болон (ЖДҮ-ийн санхүүжилт, худалдааны санхүүжилт, дэд бүтцийн санхүүжилт болон өрх гэрийн санхүүжилт) хүртээмжтэй өсөлтийг дэмжих оролдлогод сөргөөр нөлөөлдөг зээлийн хязгаарлалтыг бий болгосны улмаас банкны хямрал бий болдог.

*- банкны үйл ажиллагааны тогтвортой бус байдал үүсгэх болзошгүй*

Банкны үйл ажиллагааны тогтвортой бус байдал нь өөр бусад хөрөнгийн зах зээлийн сегмент, тухайлбал бонд, хувьцаа, өмч болон өргөн хэрэглээний бараанд хүчтэй нөлөөлж, санхүүгийн зах зээлийн өсөлт, хөгжлийг зогсоодог.

*- ард иргэд айл өрх, байгууллагын банкнаас хэт хамааралтай байдлын эрсдэл*

Байгууллага болон айл өрхүүдэд зээл олгохын тулд Монгол Улсын эдийн засаг банкнаас хамааралтай болсоноос үзэхэд эдийн засаг дахь чанаргүй зээлийн сөрөг нөлөө нь Монгол Улсад нэлээд чухал болоод байна гэж үзэж болохоор байна. Хөрөнгийн зах зээл болон банк бус санхүүгийн байгууллагууд сайн хөгжөөгүй учраас Монгол Улсын зээлийн хэрэгцээтэй бараг бүхий л салбар банкнаас хамааралтай байсаар байна.

Банкууд нийгэм-эдийн засгийн чухал давхаргууд болох том компаниуд, жижиг дунд үйлдвэрүүд, нөхөрлөл, хоршоо, айл өрхүүд болон хувь хүмүүс гээд бүхий л давхаргатай холбогдож ажилладаг тул банкны хямрал нь энэ хэмжээгээрээ эдгээр бүх давхаргад хүнд ачаа эрсдэл болон буухаар байна.

3.Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хямрал бий болсноор банкуудын барьцаа хөрөнгийн дийлэнхийг эзлэх үл хөдлөх хөрөнгийн үнэ буурсан төдийгүй банкууд барьцаа хөрөнгийг шууд захиран зарцуулах эрхгүй, чанаргүй зээлийг төлүүлэхэд нилээд хүндрэл үүсэж байна. Барьцаа хөрөнгөөр зээлийн үүргийг гүйцэтгүүлэхэд шүүхийн болон шийдвэр гүйцэтгэлийн шатанд 3-5 жилийг зарцуулдаг. Энэ нь санхүүгийн хямралыг гүнзгийрүүлж эдийн засгийг сэргээх боломжийг улам хязгаарлаж байна.

Иймээс эдийн засгийн хүндрэлээс хурдан гарах эдийн засгийг сэргээхэд чухал нөлөө үзүүлэх актив удирдлагын тогтолцоог бүрдүүлэх тусгай эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

**Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Энэхүү хуулийн төслөөр банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив удирдлагын компанийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож зохицуулна.

Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна:

*Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл*

Энэ бүлэгт банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий хуульд тодорхойлсон чанаргүй активыг шилжүүлэн авах, түүнтэй холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий хувийн хөрөнгө оруулалт давамгайлсан төрийн өмчийн оролцоотой Актив удирдлагын компанийн тухай хуулийн үйлчлэх хүрээ, хуульд хэрэглэх нэр томьёоны тайлбарыг тусгана.

*Хоёрдугаар бүлэг:Актив удирдлагын компани*

Актив удирдлагын компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагаанд баримтлах зарчим, бие даасан байдалд холбогдох харилцааг зохицуулна.

*Гуравдугаар бүлэг:Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагаа*

Энэ бүлэгт Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагаа, Актив удирдлагын компани, түүний ажилтан, албан тушаалтанд хориглох үйл ажиллагаанд холбогдсон харилцааг зохицуулна.

*Дөрөвдүгээр бүлэг:Актив удирдлагын компанийн удирдлага, зохион байгуулалт*

Тус бүлгээр төлөөлөн удирдах зөвлөл, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, гүйцэтгэх удирдлага, дотоод аудитын үйл ажиллагаа, тэдгээрийн гишүүдийг томилох чөлөөлөх үндэслэл, чиг үүргийг зохицуулна.

*Тавдугаар бүлэг:Актив удирдлагын компанийн хөрөнгө, санхүүжилт, хөрөнгө оруулалт*

Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, санхүүжилт, өрийн хэрэгсэл гаргах, зээл авах, хөрөнгө оруулалт хийх харилцааг зохицуулна.

*Зургаадугаар бүлэг: Актив удирдлагын сан*

Тус бүлэгт чанаргүй активыг барагдуулах зорилго бүхий сан, түүнийг бүрдүүлэх эх үүсвэр, авлага барагдуулах зорилгоор өрийн хэрэгсэл гаргах талаарх эрх зүйн зохицуулалтыг тусгана.

*Долдугаар зүйл:Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан*

Актив удирдлагын компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, аудиттай холбогдох зохицуулалтыг тусгана.

*Наймдугаар бүлэг:Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд хяналт тавих*

Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, тус компанийн үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам батлах эрх зүйн үндэслэлийг тусгана.

*Есдүгээр бүлэг:Бусад*

Хариуцлага болон хууль хүчин төгөлдөр болох хугацаатай холбогдох бусад зохицуулалтыг тусгана.

**Гурав.Хуулийн төсол батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал**

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн дараах үр дагавар бий болно:

1. Зах зээл дэх зээлийн нийлүүлэлт нэмэгдэж том, жижиг, дунд бизнес эрхлэлтэд бодитой дэмжлэг үзүүлнэ;
2. санхүүгийн систем дэх зээлийн эргэн төлөлтийн явц хурдсах, банкны зохистой харьцаа голлох үзүүлэлтүүд муудаж төлбөрийн чадварын хүндрэлд орохоос сэргийлэх хөрвөх чадвартай хоёрдогч захын үйл ажиллагааг хөгжүүлэх, чадавхийг нэмэгдүүлнэ;
3. улсын төсөвт ирээдүйд учирч болзошгүй их хэмжээний зардлыг бууруулж, тодорхой хэмжээнд хэмнэлтийг бий болгохын зэрэгцээ төрийн үйлчилгээнд инноваци болон түүнтэй холбогдох судалгаа шинжилгээний ажлыг нэвтрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ;
4. төрөөс тодорхой зардал гарах боловч хариуцсан төрийн байгууллагын чиг үүрэгт нэмэлт, өөрчлөлт бий болгохгүй, харин үйл явц илүү тодорхой, ил тод болно.

**Дөров.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи санал**

Хуулийн төсөлтэй холбогдуулан Иргэний хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн алба татварын хууль, Нэмэгдсэн өртөгийн албан татварын хууль, Зээлийн мэдээллийн тухай, Зөрчлийн тухай, Төв банк/Монголбанк/-ны тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна.

__________oOo__________

# ТАНИЛЦУУЛГА

Актив удирдлагын тухай
хуулийн төслийн талаар

Манай орны банк, санхүүгийн салбарт хуримтлагдсан чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж, цаашид өсөх хандлагатай болсон нь банкнаас олгох зээлийн хэмжээг бууруулах, санхүүгийн зуучлалыг зогсонги байдал оруулах, эдийн засгийн идэвхжилтийг сулруулан, бодит секторын өсөлтийг хязгаарлах, ажилгүйдлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг удаашруулах, халамжийн зардлыг өсгөх, татварын орлогыг бууруулах, өрийн тэнцвэрт байдалд хүрэх зорилтыг хэрэгжүүлэхэд саад учруулахаар байна.

Иймд банк, санхүүгийн салбарт хуримтлагдсан чанаргүй активыг бууруулах, тус салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор Актив удирдлагын мэргэшсэн институци байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг 2015 оноос эхлүүлсэн. Тодруулбал:

1.Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”[1]-ийн 2.2 дахь заалтад “Банкны салбарт эрсдэл хуримтлагдах, зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх арга хэмжээ авах”-аар тусгасан.

2.Улсын Их Хурлын 2015 оны 93 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл"-ийн 3.1-д “санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийг хөгжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх”-ийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан.

3.Улсын Их Хурлын 2016 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл"-ийн 3.2-д “санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцын эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх”-ийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан.

4.Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” батлах тухай 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Тэргүүн ээлжинд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн жагсаалтын 4-д “арилжааны банкуудын оролцоотойгоор активын удирдлагын институц байгуулж, банкны системийн чанаргүй зээлийн хэмжээг бууруулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Активын удирдлагын институцийн тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх”-ээр тусгасан.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагын хүрээнд хийгдсэн ажил, судалгаа, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийгдсэн судалгаа, үнэлгээ, олон улсын сайн туршлага,

---

[1] Энэ тогтоолыг Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.

судалгаанд үндэслэн чанаргүй зээл, активыг шийдвэрлэх замаар банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах хувийн хөрөнгө оруулалт давамгайлсан төрийн өмчийн оролцоотой Актив удирдлагын компанийг байгуулах, үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэхээр Актив удирдлагын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив Удирдлагын Компанийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож, зохицуулах бөгөөд бүтцийн хувьд нийт 9 бүлэг, 43 зүйлтэй.

Хуулийн төслөөр актив удирлагад холбогдох нэр томьёог холбогдох олон улсын стандарт, Монгол Улсын бусад хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлсоноос гадна Актив удирдлагын компанийг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа явуулах, бие даасан хараат бус байдлыг хангах, түүний үйл ажиллагаанд хяналт тавих, чанаргүй зээл, активыг шийдвэрлэх, Актив удирдлагын сангийн талаарх зохицуулалт болон Актив удирдлагын компанийн үйл ажиллагааг зогсоох талаарх зохицуулалтыг тусгасан болно.

Хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төсөлд чанаргүй зээл, активыг шийдвэрлэх ажиллагаанд холбогдох нэмэмжлэлийг шийдвэрлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахтай холбогдох зохицуулалтыг тусгасан бөгөөд энэ нь чанаргүй зээл, активыг түргэн хугацаанд шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ. Актив удирдлагын компани 10 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулахаар хуулийн төсөлд тусгагдсан бөгөөд түүний үйл ажиллагааны гол зорилго нь чанаргүй активыг түргэн хугацаанд шийдвэрлэх явдал юм.

Актив удирдлагын тухай хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн дараах үр дагавар бий болно:

1. Зах зээл дэх зээлийн нийлүүлэлт нэмэгдэж, бизнес эрхлэгчдэд эдийн засгийн бодит дэмжлэг хүрнэ;
2. Зээлийн эргэн төлөлтийн явц хурдасч, чанаргүй активыг удирдах, хөрвөх чадвартай хоёрдогч захын үйл ажиллагаа хөгжинө;
3. Улсын төсөвт ирээдүйд учирч болзошгүй их хэмжээний зардлыг бууруулж, тодорхой хэмжээнд хэмнэлт бий болох зэрэг болно.

____________oOo____________

ТӨСӨЛ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын ...-ны өдөр | Улаанбаатар хот

## АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив Удирдлагын Компани /цаашид "Актив удирдлагын компани" гэх/-ийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, хяналтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож, зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн хууль тогтоомж**

2.1.Актив удирдлагын компанийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Иргэний хууль[2], Төв банк /Монголбанк/-ны тухай хууль[3], Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль[4], Компанийн тухай хууль[5], Банкны тухай хууль[6], Өрийн удирдлагын тухай хууль[7] энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар, энэ хуульд өөрөөр заагаагүй бол бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

**4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."банк" гэж Банкны тухай хуулийн 3.1.1-д заасан хуулийн этгээдийг;

---

[1]Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.
[2]Иргэний хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
[3]Төв банк /Монголбанк/-ны тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.
[4]Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2005 оны 46 дугаарт нийтлэгдсэн
[5]Компанийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.
[6]Банкны тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
[7]Өрийн удирдлагын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 9 дүгээрт нийтлэгдсэн.

4.1.2."тохиромжтой этгээд" гэж итгэл даах, мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, шударга ёсыг эрхэмлэдэг, бусдын нөлөөнд автахгүй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид шийдвэр гаргах чадвар бүхий этгээдийг;

4.1.3."чанаргүй зээл" гэж Монголбанк, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан журмаар тодорхойлсныг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИ

### 5 дугаар зүйл.Актив удирдлагын компани

5.1.Актив удирдлагын компани нь банкны тогтвортой байдлыг хангах зорилгоор энэ хуульд тодорхойлсон чанаргүй зээлийг банкнаас шилжүүлэн авах, энэ хуулийн 10.1-т заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

5.2.Актив удирдлагын компанийг үүсгэн байгуулах хурлыг Монголбанк зарлан хуралдуулна.

5.3.Үүсгэн байгуулагчдын хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

5.3.1.Актив удирдлагын компани байгуулах тухай;
5.3.2.Актив удирдлагын компанийн дүрэм;
5.3.3.Зарласан болон гаргах хувьцаа, тэдгээрээс үүсгэн байгуулагчдын худалдан авах үнэ;
5.3.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, тэдгээрийн цалин, урамшууллыг хэмжээг тогтоох;
5.3.5.Актив удирдлагын компанид хувь нийлүүлэх хөрөнгийг бүрэн оруулах хугацаа.

5.4.Энэ хуулийн 5.3.2-т заасан дүрмийг батлахад энэ хуулийн 7.1-т заасан зөвшөөрлийг авсан байна.

5.5.Бүх үүсгэн байгуулагч оролцсоноор Актив удирдлагын компани үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болох бөгөөд уг хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналаар шийдвэр гаргана.

5.6.Актив удирдлагын компани үүсгэн байгуулах хурлын даргыг үүсгэн байгуулагчдаас сонгоно.

5.7.Актив удирдлагын компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвшөөрснөөр хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана.

5.8.Актив удирдлагын компанийг өөрчлөн байгуулах, Дампуурлын тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр татан буулгах, тус компани татан буугдах үед актив удирдлагын компанийн хөрөнгийг шийдвэрлэхтэй холбогдох харилцаа

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан журмаар зохицуулна.

5.9 Энэ хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан Актив удирдлагын компани нь 10 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулна.

5.10.Актив удирдлагын компанийн төв Монгол Улсын нийслэлд байрлана.

5.11.Актив удирдлагын компани тогтоосон загвараар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

**6 дугаар зүйл. Актив удирдлагын компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх**

6.1.Энэ хуулийн 5.3-т заасан шийдвэрийн биелэлт хангагдсанаас хойш 30 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгнө.

6.2.Компанийг бүртгэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

**7 дугаар зүйл. Актив удирдлагын компанийн дүрэм**

7.1.Актив удирдлагын компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг батлах шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвшөөрснөөр хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана.

7.2.Актив удирдлагын компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана:

7.2.1.компанийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ;

7.2.2.компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;

7.2.3.компанийн бүтэц, зохион байгуулалтын хэлбэр;

7.2.4.хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх;

7.2.5.компанийн үйл ажиллагааны чиглэл;

7.2.6.төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах зарчим;

7.2.7.бусад.

**8 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн үйл ажиллагааны зарчим**

8.1.Актив удирдлагын компани үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

8.1.1.үйл ажиллагаагаа тогтвортой, тасралтгүй, шуурхай явуулах;
8.1.2.хараат бус байх;

8.1.3.ашигтай ажиллах;
8.1.4.ил тод байх;
8.1.5.хариуцлагатай байх.

**9 дүгээр зүйл.Актив удирдлагын компанийн хараат бус, бие даасан байдал**

9.1.Актив удирдлагын компани, түүний төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан энэ хуульд заасан эрх, албан үүргээ хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус, бие даасан байна.

9.2.Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан нь өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, Актив удирдлагын компанийн нэр хүндийг эрхэмлэн, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

9.3.Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аливаа улс төрийн үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөлд автахыг хориглоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**10 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагаа**

10.1.Актив удирдлагын компани дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

10.1.1.энэ хуульд заасны дагуу чанаргүй зээлийг банкнаас шилжүүлэн авах;

10.1.2.хөрөнгө, зээл, зээлийн үндсэн хүү, гэрээнд заасан бол хэтэрсэн хугацааны хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг төлүүлэх, шаардлагатай тохиолдолд барьцаа, батлан даалт, баталгаа, фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах зэргээр банкнаас шилжүүлэн авсан чанаргүй зээлийг өмчлөх, эзэмших, удирдах, захиран зарцуулах;

10.1.3.банкнаас шилжүүлэн авсан чанаргүй зээлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хамгаалах талаар дараах арга хэмжээг авах:

10.1.3.а.зээл болон зээлийн багцыг боломжит өндөр үнээр худалдан борлуулах, захиран зарцуулах;

10.1.3.б.Чанаргүй зээлийн барьцаа, батлан даалт, баталгаа, фидуцийн зүйлийг шалгах, хамгаалах;

10.1.3.в.зээлийн багцыг үнэт цаас гаргах болон бусад аргаар санхүүжүүлэх;

10.1.3.г.энэ хуулийн 40.5-д заасан журмаар тогтоосон бусад.

10.1.4.Банкны хүсэлтээр чанаргүй зээлийг шийдвэрлэх үйл ажиллагаа.

10.2.Актив удирдлагын компани хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ банкнаас шилжүүлэн авсан чанаргүй зээлийн барьцаа, батлан даалт, баталгаа, фидуцийн зүйлтэй холбогдолтой зах зээлд хэт төвлөрөл, үнэ, ханшийн огцом өөрчлөлт үүсгэхгүй байх нөхцөлийг хангаж ажиллана.

10.3.Актив удирдлагын компани энэ хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ чанаргүй зээлд холбогдох тайлан, баримт мэдээллийг холбогдох банк, иргэн, хуулийн этгээд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргуулан авах эрхтэй.

**11 дүгээр зүйл.Банкны чанаргүй зээлийг шилжүүлэн авах**

11.1.Актив удирдлагын компани банкны чанаргүй зээлийг энэ хуулийн дагуу шилжүүлэн авч болно.

11.2.Актив удирдлагын компанийн банкнаас шилжүүлэн авах чанаргүй зээлд дараах шаардлага тавигдана:

11.2.1.банкнаас шилжүүлэн авах чанаргүй зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцаа, батлан даалт, баталгаа, фидуцийн зүйлээр хангуулах боломжтой байх;

11.2.2.чанаргүй зээлийн барьцаа, батлан даалт, фидуцийн зүйлийг зах зээлд худалдан борлуулах боломжтой байх;

11.2.3.шилжүүлэх чанаргүй зээлийн талаар банкнаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт бичиг нь бүрэн гүйцэд, үнэн зөв байх;

11.2.4.шилжүүлэх чанаргүй зээлтэй холбоотой эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн баримт бичиг үнэн зөв, бүрэн байх;

11.2.5.барьцаа, батлан даалт, фидуцийн зүйлд үнэлгээ хийгдсэн байх;

11.2.6. зээлийн хувийн хэргийн бүрдэл, эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүрэн, үнэн зөв байх;

11.2.7.Энэ хуулийн дагуу Монголбанк шаардлагатай гэж үзсэн бусад.

11.3.Актив удирдлагын компани банкнаас чанаргүй зээлийг аливаа дарамт шахалтгүйгээр бие даан хийсэн хэлцэлд үндэслэн хямдруулсан дүнгээр шилжүүлэн авна.

11.4.Энэ хуулийн 11.3-т заасан дүнг тодорхойлохдоо төлөөлөн удирдах зөвлөлийн сонгосон үнэлгээчин дараах асуудлыг харгалзан үзнэ:

11.4.1.тухайн барьцаа, батлан даалт, фидуцийн зүйлийг шилжүүлэгч банкнаас үнэлсэн үнэлгээ, үнэлгээ гаргасан аргачлал;

11.4.2.шилжүүлэх зээлийн үнэлгээ гаргахад ашиглах боломжтой Актив удирдлагын компанийн бусад мэдээ, тайлан, үнэлгээ, дүгнэлт;

11.4.3.зээлдэгч, үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадвар, тухайн чанаргүй зээлд холбогдох үүргийн гүйцэтгэлийн түүх;

11.4.4.тухайн чанаргүй зээлийн барьцаа, батлан даалт, фидуцийн зүйлтэй ижил төстэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг Актив удирдлагын компанийн томилсон үнэлгээчнээс үнэлж тогтоосон дүн.

11.5.Актив удирдлагын компани нь банкнаас чанаргүй зээлийг шилжүүлэхэд, эсхүл тус компани чанаргүй зээлийг бусад этгээдэд шилжүүлэхэд зээлдэгч болон барьцаа, батлан даалт, фидуцийн зүйлийн өмчлөгч, эзэмшигчээс зөвшөөрөл авахгүй.

11.6.Актив удирдлагын компани чанаргүй зээлийн үнийг хямдруулах бодлого, журам тогтоон мөрдөж болно.

11.7.Актив удирдлагын компани нь шилжүүлэн авсан чанаргүй зээл, түүний барьцаа, батлан даалт, фидуцийн зүйлийг худалдан борлуулах боломжийг сайжруулах, тэдгээрийн үнэлгээг хадгалах, нэмэгдүүлэх зорилгоор чанаргүй зээл, түүний барьцаа, батлан даалт, фидуцийн зүйлийн хөрш залгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, дагалдах зүйлийг худалдан авч болно.

11.8.Актив удирдлагын компанийн банкнаас шилжүүлэн авсан зээл нь буцаан үл дуудагдах нөхцөлтэй байна.

11.9.Энэ хуулийн 11.7-д заасан арга хэмжээ авах үйл ажиллагаа явуулах үндэслэл, журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

11.10.Монголбанк энэ хуулийн 11.2-т заасныг үндэслэн Актив удирдлагын компанид шилжүүлэх чанаргүй зээл, шилжүүлэх банкыг тодорхойлохтой холбоотой журмыг батална.

11.11. Актив удирдлагын компани нь энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр банкны чанаргүй зээлийг шилжүүлэн авахыг хориглоно.

## 12 дугаар зүйл.Банкны хүсэлтээр чанаргүй зээлийг шийдвэрлэх үйл ажиллагаа

12.1. Актив удирдлагын компани нь чанаргүй зээлийн төлбөрийг төлүүлэхтэй холбоотой банкны шийдвэр гаргах эрхийг түүний хүсэлтээр шилжүүлэн авч болно.

12.2.Актив удирдлагын компани нь чанаргүй зээлийг төлүүлэхтэй холбоотой арга хэмжээг энэ хуулийн 12.1-д заасны дагуу банкны шилжүүлсэн эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ.

12.3.Банкны хүсэлтээр чанаргүй зээлийн шийдвэрлэх ажиллагааны журмыг Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

**13 дугаар зүйл.Гэрээний үндсэн дээр хамтран ажиллах**

13.1.Актив удирдлагын компани нь гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага, тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн мэргэжилтэн, хувь хүнтэй хамтран ажиллаж болно.

13.2.Гэрээгээр хамтран ажиллах байгууллага, мэргэжилтэн, хувь хүн нь гэрээнд заасан үүргийг хэрэгжүүлэх нөхцөл, шаардлагыг хангасан, ашиг сонирхлын зөрчилгүй байна.

13.3.Гэрээгээр хамтран ажиллах этгээдэд тавигдах шаардлагыг холбогдох хууль тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гэрээгээр тогтооно.

**14 дүгээр зүйл.Актив удирдлагын компани, түүний ажилтан, албан тушаалтанд хориглох үйл ажиллагаа**

14.1.Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтан нь албан үүргийнхээ дагуу олж авсан аливаа мэдээллийг бусдад задруулах, хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.

14.2.Актив удирдлагын компани нь дараах тохиолдолд хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг гуравдагч этгээдэд гарган өгч болно:

14.2.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

14.2.2.шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авилгатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар, тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар тэдгээрийн удирдлагын хүсэлтийг прокурор зөвшөөрсөн;

14.2.3.энэ хуульд заасны дагуу Актив удирдлагын компанид хийх хөндлөнгийн аудиттай холбогдуулан аудитын байгууллагаас хүсэлт гаргасан;

14.2.4.Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкнаас өөрийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд шаардсан болон Санхүүгийн зохицуулах хорооны байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу гадаад улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасан;

14.2.5. Татварын байгууллага татварын хяналт, шалгалт хийх зорилгоор, эсхүл Монгол Улсын Засгийн газар гадаад улс орнуудтай татварын зорилгоор мэдээлэл харилцан солилцох зорилгоор мэдээлэл авах хүсэлт гаргасан.

14.3.Актив удирдлагын компани нь Засгийн газрын баталгаа гаргасан эх үүсвэрийг бүрэн төлж барагдуулахаас өмнө аливаа хэлбэрээр ногдол ашиг, урамшуулал хуваарилахыг хориглоно.

14.4.Актив удирдлагын компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан тус компанийн эзэмшиж, өмчилж байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдан

авах, шилжүүлэн авах зэрэг аливаа хэлбэрээр өмчлөл, эзэмшилдээ шилжүүлэн авахыг хориглоно.

14.5.Актив удирдлагын компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь хуулиар хариуцуулсан үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаалыг хавсран эрхэлж болохгүй.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

## УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 15 дугаар зүйл.Актив удирдлагын удирдлага

15.1.Актив удирдлагын компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний чөлөөт цагт төлөөлөн удирдах зөвлөл байна.

15.2.Хувьцаа эзэмшигчдийн хурал нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгож, чөлөөлнө.

### 16 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурал

16.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

### 17 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл

17.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь долоон гишүүнтэй байх ба гурван гишүүн нь хараат бус гишүүн байна.

17.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг Монголбанк, Олон улсын санхүүгийн байгууллагаас тус тус нэр дэвшүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурал сонгоно.

17.3.Гүйцэтгэх захирал төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болохгүй.

17.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн дараах шалгуурыг хангасан байна:

17.4.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өрийн үлдэгдэлгүй байх;

17.4.2 эдийн засагч, эрх зүйч мэргэжилтэй;

17.4.3.банк, санхүү, эрх зүй, эдийн засгийн чиглэлээр тав буюу түүнээс дээш жил, удирдах албан тушаалтнаар хоёр буюу түүнээс дээш жил ажилласан байх;

17.4.4. гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй байх;

17.4.5.тохиромжтой этгээд байх.

17.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гурваас доошгүй гишүүн доор дурдсан салбарт наймаас доошгүй жил ажилласан байна:

17.5.1.банк, санхүү, эдийн засаг, эрх зүй;

17.5.2.нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн тайлагнал;

17.5.3. хөрөнгийн үнэлгээ, удирдлага, худалдаа.

17.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг таван жилийн хугацаагаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно. Актив удирдлагын компанийн бодлогын залгамж халааг хадгалах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг дахин сонгохдоо хараат бус гурван гишүүнийг гурван жилийн хугацаагаар, бусад гишүүнийг дөрвөн жилийн хугацаагаар тус тус сонгоно.

17.7.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүдийн дийлэнх олонхын саналаар сонгоно.

**18 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх**

18.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль, Актив удирдлагын компанийн дүрэм, журмын хүрээнд Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах бөгөөд Компанийн тухай хуулийн 76.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1.Энэ хуулийн 40.5-т зааснаас бусад Актив удирдлагын компанийн журам, заавар батлах;

18.1.2.Актив удирдлагын компанийн стратегийг тодорхойлох, жилийн төсөв, төлөвлөгөөг батлах;

18.1.3.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл холбогдох арга хэмжээг авах;

18.1.4.Актив удирдлагын компанийн хөрөнгийг эзэмших, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан журам баталж, тус асуудлаарх гүйцэтгэх удирдлагын холбогдох эрх хэмжээг тогтоох;

18.1.5.дотоод аудитын нэгжийн удирдлагыг томилох, чөлөөлөх;

18.1.6.төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд аудитын хороо, эрсдэлийн удирдлагын хороо болон бусад хороог байгуулж, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлох;

18.1.7.Актив удирдлагын компанийн хөрөнгө оруулалтын бодлогыг батлах;

18.1.8.баталгаа гаргах дээд хэмжээг тогтоох;

18.1.9.барьцаа, батлан даалт, фидуцийн зүйлд үнэлгээ хийх үнэлгээчин, хөндлөнгийн аудитыг сонгох, томилох;

18.1.10.Актив удирдлагын компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүү, үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж, холбогдох стандартын хэрэгжилтийг хангуулах;

18.1.11.Энэ хууль болон Актив удирдлагын компанийн дүрэмд заасан бусад бүрэн эрх.

18.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлан ажиллана:

18.2.1.Актив удирдлагын компанийн эрх ашгийг тэргүүн ээлжид тавьж, албан үүргээ үнэнч, шударгаар биелүүлэх;

18.2.2.мэргэжил, ур чадварын өндөр түвшинд ажиллах;

18.2.3.хараат бус байж, бусдын нөлөөнд үл автан, аливаа ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх.

**19 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг түр чөлөөлөх**

19.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын ээлжит бус хурлын шийдвэрээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно:

19.1.1.энэ хуулийн 17.4-д заасан шаардлагын аль нэгийг хангахгүй болсон;

19.1.2.биеийн эрүүл мэндийн болон хүндэтгэх үзэх шалтгаанаар албан үүргээ зургаан сараас дээш хугацаагаар гүйцэтгэх боломжгүй болсон;

19.1.3.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сүүлийн гурван удаагийн хуралд дараалан оролцоогүй;

19.1.4.үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлж, Актив удирдлагын компанийн эрх ашигт харш үйлдэл, эс үйлдэхүй гаргаж, ёс суртахууны хэм хэмжээг зөрчсөн.

19.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн албан тушаалаасаа түр чөлөөлөгдөх хүсэлтийг төлөөлөн удирдах зөвлөлд гаргаж болох бөгөөд уг хүсэлтэд түр чөлөөлөгдөх хугацааг тодорхой тусгана. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг албан тушаалаас түр чөлөөлнө.

**20 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгох, орлон ажиллах**

20.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх энэ хуулийн 19.1-д заасны дагуу дуусгавар болсон бол тухайн гишүүнийг нэр дэвшүүлсэн этгээд түүний оронд ажиллах гишүүнийг нөхөн нэр дэвшүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгоно.

20.2.Нөхөн сонгогдож байгаа төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ хуулийн 17.4-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд чөлөөлөгдсөн гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаагаар ажиллана.

20.3.Энэ хуулийн 19.1-д заасны дагуу түр чөлөөлөгдсөн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлон ажиллах энэ хуулийн 17.4-т заасан шаардлагыг хангасан этгээдийг төлөөлөн удирдах зөвлөл түр хугацаагаар томилно.

20.4.Энэ хуулийн 20.3-т заасан түр хугацаагаар ажиллах этгээдийн ажиллах хугацааг нэр дэвшүүлсэн этгээд тогтооно.

**21 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал**

21.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга удирдах бөгөөд түүний эзгүйд түүний үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн даргын томилсон этгээд удирдана.

21.2.Актив удирдлагын компанийн дүрэмд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл нь улиралд нэг буюу түүнээс дээш удаа хуралдах бөгөөд үүнээс хоёр хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд биечлэн оролцохоор зохион байгуулна. Мэдээллийн технологийн техникийн хэрэгсэл, программ хангамж ашиглан хуралд оролцож саналаа өгч болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд жилд хоёр буюу түүнээс дээш удаа хуралд биечлэн оролцоно.

21.3.Актив удирдлагын компанийн гүйцэтгэх удирдлагын санал болгосны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хэлэлцэх асуудлыг баталж, тус зөвлөлийн бүх гишүүдэд мэдэгдэж, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулна.

21.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр гишүүнээс бичгээр санал гаргасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулж болно.

21.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулахаас 10 хоногийн өмнө хурлын тов, хурлаар хэлэлцэх асуудлыг зөвлөлийн бүх гишүүдэд хүргүүлж мэдээлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд мэдэгдэж болно.

21.6.Төлөөлөн удирдах зөвлөлийг бүх гишүүдийн дийлэнх олонхын ирцтэйгээр хуралдуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

21.7.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна. Санал хураалтын дүн тэнцсэн нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

21.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, хуралд оролцогчдын саналын баримт бичгийн баталгаажуулсан хувийг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд хүргүүлнэ.

**22 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо**

22.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хороо ба эрсдэлийн удирдлагын хороог байгуулна.

22.2.Төлөөлөн удирдах зөвлөл Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагааны хүрээнд байнга болон түр хугацаанд үйл ажиллагаа эрхлэх бусад хороог байгуулж болно.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасан хороо нь төлөөлөн удирдах зөвлөлийн гурван гишүүнээс бүрдэх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, зөвлөмж, дүрэмд нийцүүлж үйл ажиллагаа явуулна.

22.4.Аудитын хороо нь Компанийн тухай хуулийн 81.4-т заасан болон Актив удирдлагын компанийн дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын асуудал болон эдгээртэй холбоотойгоор төлөөлөн удирдах зөвлөлөөс тодорхойлсон бусад ажил үүргийг гүйцэтгэж, төлөөлөн удирдах зөвлөлд дүгнэлт гаргана.

22.5.Эрсдэлийн удирдлагын хороо нь Актив удирдлагын компанийн эрсдэлийн удирдлагын бодлогыг батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих, цаашид хөгжүүлэх, сайжруулах чиглэлээр зөвлөмж, эсхүл дүгнэлт гаргана.

**23 дугаар зүйл.Дотоод аудитын үйл ажиллагаа**

23.1.Төлөөлөн удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлэх дотоод аудитын нэгжийг байгуулна:

23.1.1.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж, үнэлгээ өгөх;

23.1.2.Актив удирдлагын компани, түүний албан тушаалтан хууль тогтоомж, тус компанийн дүрэм, журам, захиргааны актыг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах;

23.1.3.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, үйл ажиллагааг сайжруулах талаар санал, зөвлөмж өгөх;

23.1.4.энэ хуулийн 23.1.3-т заасан асуудлаар төлөөлөн удирдах зөвлөл, аудитын хороо болон гүйцэтгэх удирдлагатай уулзалт хийх;

23.1.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан журмын дагуу тус зөвлөл, гүйцэтгэх удирдлагад Актив удирдлагын компанийн дотоод аудитын үйл ажиллагааны талаар дүгнэлт бэлтгэж хүргүүлэх;

23.1.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан журамд заасан бусад чиг үүрэг.

**24 дүгээр зүйл. Актив удирдлагын компанийн гүйцэтгэх удирдлага**

24.1.Актив удирдлагын компанийн гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

24.2.Гүйцэтгэх захирал нь дараах шаардлагыг хангасан байна:

24.2.1.тохиромжтой этгээд байх;

24.2.2.эдийн засаг, санхүү эсхүл хууль зүйн чиглэлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй байх;

24.2.3.энэ хуулийн 17.5-д заасан салбарт таваас дээш жил удирдах албан тушаалд ажилласан байх.

24.3.Гүйцэтгэх удирдлагыг таван жилийн хугацаанд орон тооны ажилтнаар ажиллах, улиран сонгогдох боломжтой нөхцөлөөр төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгоно.

24.4.Гүйцэтгэх удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлэх зарчим, ажлын гүйцэтгэлийг хэрхэн үнэлж, дүгнэх тухай Актив удирдлагын компанийн дүрэм, журамд заах бөгөөд гүйцэтгэх удирдлага төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрч баталсан дотоод бодлого, зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

24.5.Гүйцэтгэх удирдлага Актив удирдлагын компанийн өдөр тутмын үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтыг хариуцах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.5.1.Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж, Актив удирдлагын компанийг төлөөлөх, удирдах;

24.5.2.Актив удирдлагын компанийн үйл ажиллагааг сайжруулах, энэ хууль болон бусад холбогдох журам, шаардлагын хэрэгжилтийг хангах талаар төлөөлөн удирдах зөвлөлд санал оруулах;

24.5.3.Актив удирдлагын компанийн жилийн санхүүгийн төлөвлөгөөг бэлтгэж танилцуулах, компанийн санхүүгийн тайланг танилцуулж батлуулах;

24.5.4.Актив удирдлагын компанийн хөрөнгө оруулалтын бодлогыг бэлтгэж, төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах;

24.5.5.үйл ажиллагааны төлөвлөгөө, дүрэм, журам, тушаал болон заавар, удирдамжийн төсөл бэлтгэж төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах;

24.5.6.Актив удирдлагын компанийн шилжүүлэн авах чанаргүй зээлд үнэлгээ хийх, активын удирдлагыг хэрэгжүүлэх хөндлөнгийн мэргэжлийн этгээдийг санал болгох;

24.5.7.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд аудит хийх хөндлөнгийн аудитыг санал болгох;

24.5.8.энэ хууль болон төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан Актив удирдлагын компанийн дүрэм, журам, бодлогын дагуу тус компанийн ажилтан, албан тушаалтанг ажилд авах, ажлаас чөлөөлөх;

24.5.9.Актив удирдлагын компанийн эрсдэлийн үнэлгээний төлөв байдлыг дүгнэж, хүлээн зөвшөөрч болохуйц эрсдэл, эрсдэлийг бууруулах чиглэлд авах арга хэмжээг тодорхойлох;

24.5.10.Дүрэмд заасан бусад.

24.6.Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын хэмжээг төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтооно.

**25 дугаар зүйл.Актив удирдлагын компани, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтны баталгаа**

25.1.Актив удирдлагын компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь энэ хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл түүнийг биелүүлснээс банк, гуравдагч этгээдэд учирсан хохирлыг Актив удирдлагын компани, түүний ажилтан, албан тушаалтан хариуцахгүй.

25.2.Актив удирдлагын компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтныг ажил, албан үүрэгтэй нь холбогдуулан заналхийлэх, сүрдүүлэх, амь бие, эрүүл мэндэд нь халдах аливаа хууль бус үйлдлээс тэдгээрийг болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг хамгаалах үүргийг Актив удирдлагын компани хүлээнэ.

25.3.Актив удирдлагын компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд түүнд эсхүл түүний гэр бүлд Актив удирдлагын компаниас тэтгэвэр, тэтгэмж, зардлыг бүрэн олгоно.

25.4. Энэ хуулийн 25.3-т заасан тэтгэвэр, тэтгэмж, зардал олгох журмыг Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөл батална.

25.5. Актив удирдлагын компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгалд даатгуулсан байна.

**26 дугаар зүйл. Актив удирдлагын компанид гаргасан гомдлыг шийдвэрлэх**

26.1. Актив удирдлагын компани, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл тухайн этгээд гомдлоо Актив удирдлагын компанид гаргаж болно.

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөхтэй холбогдсон журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**27 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө**

27.1.Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

27.1.1.Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын иргэн, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө,

27.1.2.олон улсын санхүүгийн байгууллага, гадаад улсын актив удирдлагын компанийн оруулсан хөрөнгө;

27.1.3.хуульд заасан бусад эх үүсвэр.

27.2.Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 23.2.2-т заасны дагуу Монголбанк Актив удирдлагын компанийн хувьцааг эзэмшиж болно.

27.3.Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь энэ хуулийн 27.1-д заасан эх үүсвэрээс оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээг эдийн засгийн байдал, мөнгөний ханшны өөрчлөлт, Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

**28 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн санхүүжилт**

28.1.Актив удирдлагын компани үйл ажиллагааны эрсдэлээ бууруулах зорилгоор энэ хууль тогтоомжийн хүрээнд өрийн хэрэгсэл гаргаж, хөрөнгө оруулалт хийж, бусад эх үүсвэрээс санхүүжилт авч болно.

28.2.Энэ хуулийн 28.1-д заасан санхүүжилтийн бусад эх үүсвэрт тавих шаардлага, санхүүжилт авах журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

**29 дүгээр зүйл.Өрийн хэрэгсэл гаргах**

29.1.Актив удирдлагын компани Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу өрийн хэрэгсэл гаргаж болно.

29.2.Актив удирдлагын компанийн гаргах өрийн хэрэгсэл нь нийт дүнгээрээ өөрийн хөрөнгийг 10 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.

29.3.Энэ хуулийн 29.1-д заасан өрийн хэрэгсэлд Засгийн газар баталгаа гаргаж болно.

29.4.Энэ хуулийн 29.3-т заасны дагуу Актив удирдлагын компанийн өрийн хэрэгсэлд Засгийн газар баталгаа гаргахад энэ хуулийн 29.2-д заасан хязгаарлалт хамаарахгүй.

**30 дугаар зүйл.Зээл авах**

30.1.Актив удирдлагын компани энэ хуульд заасан үйл ажиллагааг эрхлэх зорилгоор санхүүгийн байгууллагаас зээл авч болно.

30.2. Актив удирдлагын компанийн зээл авах журмын төлөөлөн удирдах зөвлөлийн батална.

30.3.Энэ хуулийн 30.1-д заасан зээлийн хэмжээ нь өөрийн хөрөнгийн 20 хувь, нэг этгээдээс авах зээлийн хэмжээ нь өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй.

**31 дүгээр зүйл.Актив удирдлагын компанийн хөрөнгө оруулалт**

31.1.Актив удирдлагын компани өөрийн актив хөрөнгийг аюулгүй, хөрвөх чадвартай, ашигтай байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд байршуулж болно:

31.1.1.Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл авсан, зээлжих зэрэглэл тогтоодог олон улсын байгууллагаар үнэлгээ хийлгэсэн банк, хөрөнгө оруулалтын санд;

31.1.2.Засгийн газрын үнэт цаас болон Засгийн газрын өрийн баталгаа гаргасан бусад үнэт цаас;

31.1.3. Монголбанкны үнэт цаас;

31.1.4.Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журам, тус журамд нийцүүлэн баталсан Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бодлогод заасан санхүүгийн бусад хэрэгсэл.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### 32 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн санхүүгийн тайлан

32.1.Актив удирдлагын компани өөрийн үйл ажиллагааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Актив удирдлагын компанийн нягтлан бодох бүртгэлийн тусгай журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана.

32.2.Актив удирдлагын компанийн нягтлан бодох бүртгэлийн тусгай журам, тус компанийн санхүүгийн тайланд тавих шаардлагыг Монголбанк, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.

32.3.Актив удирдлагын компанийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу гарган аудит хийлгэж, үр дүнг өөрийн цахим хуудсанд байршуулж, нийтэд ил тод мэдээлнэ.

32.4.Актив удирдлагын компани тухайн жилийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний дотор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнана.

32.5.Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг Актив удирдлагын компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.

### 33 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн үйл ажиллагааны тайлан

33.1.Актив удирдлагын компани жил бүр энэ хуулийн 32.3-т заасан хугацаанд тухайн жилийн үйл ажиллагааны тайланг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнана.

33.2.Тайланд Актив удирдлагын компанийн үйл ажиллагааны үр дүн, компанийн засаглалын байдал, төлөөлөн удирдах зөвлөлөөс тайланг хэлэлцсэн дүгнэлтийг болон бусад асуудлыг тусгасан байна.

33.3.Актив удирдлагын компани үйл ажиллагааны тайлангаа цахим хуудсандаа байршуулж, олон нийтэд ил тод мэдээлнэ.

**34 дүгээр зүйл.Санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд төрийн аудит хийх**

34.1.Активын удирдлагын компанийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны гүйцэтгэлд жил бүр төрийн аудит хийнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ
## АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН НЭХЭМЖЛЭЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ОНЦГОЙ АЖИЛЛАГАА

**35 дугаар зүйл. Нэхэмжлэлийн үнийг тодорхойлох**

35.1.Банкнаас энэ хуулийн дагуу шилжүүлэн авсан чанаргүй зээлтэй холбогдуулан Актив удирдлагын компаниас гаргаж байгаа нэхэмжлэлийн шаардлагын дүнг тодорхойлохдоо зээл, зээлийн үндсэн хүү, гэрээнд заасан бол хэтэрсэн хугацааны хүү, нэмэгдүүлсэн хүүг дор дурдсан хугацаанд тооцно:

35.1.1.зээл, зээлийн үндсэн хүү, гэрээнд заасан бол хэтэрсэн хугацааны хүү, нэмэгдүүлсэн хүү төлөгдөх хүртэл;

35.1.2.төлбөр авагчийн шаардлага, эсхүл шүүхийн шийдвэрийг бүрэн болон хэсэгчлэн хангуулах зорилгоор барьцаа хөрөнгө эсхүл үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгийг худалдан борлуулах тохиолдолд хөрөнгийн үнэлгээ хийх хугацаанд;

35.1.3.төлбөр авагчийн шаардлага, эсхүл шүүхийн шийдвэрийг бүрэн болон хэсэгчлэн хангуулах зорилгоор барьцаа хөрөнгө, үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгийг худалдан борлуулахаар нэг болон түүнээс дээш удаа дуудлага худалдаа зохион байгуулах, худалдах хугацаанд.

**36 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн нэхэмжлэлийг шүүх хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны журам**

36.1. Энэ хуулийн 10.1.2-т заасан чанаргүй зээлийг төлүүлэхтэй холбоотой Актив удирдлагын компанийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийг энэ хуульд заасан онцгой ажиллагааны журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

36.2.Актив удирдлагын компанийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийг хариуцагч гардаж авснаас хойш 10 хоногийн дотор хариу тайлбар өгнө.

36.3. Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан боловч энэ хуулийн 36.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож хурлыг товлоно.

36.4.Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байгаа үндэслэл, нотлох баримтыг шүүхэд ирүүлэх бөгөөд шүүх хариуцагчийн татгалзлын үндэслэл, түүнийг нотлох баримт хангалтгүй гэж үзвэл татгалзлыг хүлээж авахгүй.

36.5.Шүүх энэ хуулийн 36.2-т заасан хугацаа өнгөрснөөс хойш хэргийг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

36.6.Зохигчид анхан шат, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал гарснаас хойш 10 хоногийн дотор давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргаж болно.

36.7.Энэ хуулийн 35 дугаар зүйл, 36.1-36.6-д заасан Актив удирдлагын компанийн нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хамаарахгүй.

**37 дугаар зүйл. Дуудлага худалдаа явуулах**

37.1.Актив удирдлагын компани энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан онцгой ажиллагааны журмаар эцэслэн гарсан шүүхийн шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор дуудлага худалдааг зохион байгуулна.

37.2.Дуудлага худалдаа явуулах журмыг Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөл батална.

**38 дугаар зүйл.Нэг этгээд оролцсон дуудлага худалдаа**

38.1.Дор дурдсан тохиолдолд нэг этгээд оролцсон энэ хуулийн 37.1-д заасан дуудлага худалдааг хүчин төгөлдөр гэж тооцно:

38.1.1.дуудлага худалдаа явуулах тухай зарыг зохих журмын дагуу гаргасан;

38.1.2.дуудлага худалдаанд оролцогч нь зохих дэнчин тавьсан;

38.1.3.дуудлага худалдаанд оролцогч нь зах зээлийн боломжит үнэ эсхүл дуудлага худалдаагаар худалдах хөрөнгөд санал болгох доод үнэтэй тэнцүү буюу түүнээс өндөр үнэ санал болгосон;

38.1.4.дуудлага худалдаа явуулах бусад нөхцөл, шаардлагыг хангасан.

**39 дүгээр зүйл.Дуудлага худалдааны үнэ**

39.1. Актив удирдлагын компанийн тогтоосон дуудлага худалдааны үнэ эцсийн үнэ байна.

39.2. Энэ хуулийн 39.1-т заасан үнэд тухайн хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч аливаа хэлбэрээр гомдол гаргах эрхгүй.

## НАЙМДУГААР БҮЛЭГ
## АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

**40 дүгээр зүйл.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд тавих хяналт**

40.1.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.

40.2.Санхүүгийн зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд, эсхүл Монголбанкны хүсэлтийн дагуу Актив удирдлагын компанийн үйл ажиллагаа, данс бүртгэл, тайлан, тэнцэл, санхүүгийн баримтад хяналт шалгалт хийж болно.

40.3.Энэ хуульд заасан чанаргүй зээлийг тодорхойлох журмыг Монголбанк батална.

40.4.Актив удирдлагын компани, түүний үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө, санхүүжилт, хяналт шалгалт, түүний үйл ажиллагаанд холбогдох журмыг Санхүүгийн зохицуулах хороо дангаар буюу Монголбанк, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

40.5.Төлөөлөн удирдах зөвлөлөөс энэ хуульд заасны дагуу баталсан дүрэм, журам, бодлого, шийдвэр энэ хуулийн 40.4-д заасан журамд нийцсэн байна.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
## БУСАД

**41 дугаар зүйл. Татвар, хураамж**

41.1. Актив удирдлагын компани нь хуульд заасны дагуу албан татвар, хураамж, шимтгэлээс чөлөөлөгдөнө.

**42 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

42.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**43 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

43.1.Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн 2029 оны ... дугаар сарын ...-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

**1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт:**

“3.1.9.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;”

**2/6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалт:**

“6.2.8.Актив удирдлагын компанийн чиглэлээр Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан.”

**2 дугаар зүйл.**Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дахь заалтын дугаарыг “3.1.10” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

# ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Иргэний хуулийн 197.9 дэх хэсгийн "Нэг" гэсний өмнө "Хуульд өөрөөр заагаагүй бол" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

## КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Компанийн тухай хуулийн 75.3 дахь хэсгийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн" гэсний өмнө "Хуульд өөрөөр заагаагүй бол" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 14.2.11 дэх заалт нэмсүгэй.

“14.2.11.Эцсийн өмчлөгчийн мэдээлэл.”

**2 дугаар зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1.14-ийн “ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.

**1/65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсэг:**

65.4.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан Актив удирдлагын компанийн гаргасан нэхэмжлэлийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх шүүгчийн захирамж, шүүхийн гүйцэтгэх хуудас гарсанаас хойш 10 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн хөрөнгийн албадан дуудлага худалдаа явуулах тогтоол гаргана.

**2/66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэг:**

66.3.Энэ хуулийн 65.4-т заасан албадан дуудлага худалдаа явуулах ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоол гарснаас хойш дуудлага худалдааг 30 хоногийн дотор зохион байгуулна.

**3/75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэг:**

75.4.Иргэний хуулийн 177.2-д заасан анхны дуудлага худалдаанд оролцогч ирээгүй үндэслэлээр зохион байгуулах хоёр дахь дуудлага худалдаанд нэг оролцогч оролцож болно.

**2 дугаар зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсгийн дугаарыг "66.4" гэж, 66.4 дэх хэсгийн дугаарыг "66.5" гэж, 66.5 дахь хэсгийн дугаарыг "66.6" гэж, 75 дугаар зүйлийн 75.4 дахь хэсгийн дугаарыг "75.5" гэж, 75.5 дахь хэсгийн дугаарыг "75.6" гэж, 75.5 дахь хэсгийн "75.4-т" гэснийг "75.5-т" гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

# УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 41.1.16 дахь заалт нэмсүгэй.

"41.1.16.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан Актив удирдлагын компаниас гаргасан нэхэмжлэл."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар
сарын ....-ны өдөр

Улаанбаатар
хот

# ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсын Хөгжлийн банк" гэсний дараа "Монгол Улсын Актив удирдлагын компани," гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар
сарын ....-ны өдөр

Улаанбаатар
хот

## ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 7.1.6 дахь заалт нэмсүгэй.

“7.1.6.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан Актив удирдлагын компанийн банкнаас шилжүүлэн авсан чанаргүй активыг шийдвэрлэхтэй холбоотой төлбөрт тооцон шилжүүлэн авсан болон худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгө.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

# НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 12.1.8 дахь заалт нэмсүгэй.

“12.1.8.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан Актив удирдлагын компанийн банкнаас шилжүүлэн авсан чанаргүй активыг шийдвэрлэхтэй холбоотой өөрийн өмчлөлд шилжүүлэн авсан үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулсан орлого, газар өмчлөх эрх, газар эзэмших эрх, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, хуульд заасан бусад эрхийг борлуулсны орлого.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зээлийн мэдээллийн тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

**1/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалт:**

“4.1.14.“эцсийн өмчлөгч” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг.

**2/6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалт:**
“6.2.8.эцсийн өмчлөгчийн мэдээлэл;”

**2 дугаар зүйл.**Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6.2.8, 6.2.9 дахь заалтын дугаарыг “6.2.9, 6.2.10” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

# ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар бүлэг "Аж ахуйн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил"-д доор дурдсан агуулгатай 10.29 дүгээр зүйл нэмсүгэй.

**"10.29.Актив удирдлагын компанийн тухай хууль зөрчих**

1.Актив удирдлагын компанийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан хяналт шалгалтын болон бусад эрх бүхий байгууллагын хууль ёсны шийдвэр, шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

## ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмсүгэй.

"6/ энэ хуулийн 23.2.1-т заасны дагуу шилжүүлэн авсан чанаргүй зээлийг актив удирдлагын компанид шилжүүлэх."

**2 дугаар зүйл**. Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# АКТИВ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**2019 он**

**АКТИВ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛГАА**

**НЭГ**.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ ..............................................1-9

**ХОЁР**.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ ..................................9-13

**ГУРАВ**. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ ..............................................................13-16

**ДӨРӨВ**. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ.........................................................................16-24

**ТАВ**.ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ..............................................................................................24-38

**ЗУРГАА**.ЗӨВЛӨМЖ ..........................................................................38-41

## НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ

***Судалгааны зорилго***

Актив удирдлагын компани байгуулах замаар чанаргүй зээлийг шийдвэрлэх, банкны бүтцэд өөрчлөлт оруулах эрх зүйн орчинг боловсронгүй болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.

***Одоогийн нөхцөл байдал***

Олон улсын зах зээл дэх түүхий эдийн үнийн уналт нь манай улсын эдийн засагт шууд нөлөөлж гүнзгий, удаан хугацааны хямралд орсноор арилжааны банкуудын эзэмшиж байгаа чанаргүй зээлийн хэмжээ нь сүүлийн жилүүдэд хурдацтай нэмэгдэж байна. Тодруулбал, Банкны системд хуримтлагдсан чанаргүй зээлийн үлдэгдэл 2016 оны 12 сарын байдлаар эргэн төлөлтийн доголдолтой зээл нийт зээлийн 14.2% буюу 1.7 их наяд төгрөг /*Хүснэгт 1*/гэсэн албан ёсны мэдээлэл байгаа боловч энэ нь чанаргүй зээлийн бодит хэмжээг дутуу илэрхийлж байна. Учир нь банкууд бүтцийн өөрчлөлт хийсэн зээлээ энгийн зээл гэж бүртгэх боломжтой байдаг бөгөөд чанаргүй зээлийг хойшлуулсан сууриар бүртгэхийг зөвшөөрдөг.

Хүснэгт 1




Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2016 оны эцэст өнгөрсөн 6 жилийн хугацааны хамгийн өндөр түвшинд хүрч, харгалзан 7.1 хувь, 7.2 хувь болсон байна.

Банкны салбарын эргэн төлөлтийн доголдолтой зээлийн хувь

Хүснэгт 2




2018 оны 4 дүгээр сард системийн нийт зээлийн 7.4 хувь нь чанаргүй буюу 1.06 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь банкуудын төлбөрийн чадвар, улмаар нийт эдийн засагт сөрөг нөлөөтэй болно.

Мөн Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хямрал бий болсноор банкуудын барьцаа хөрөнгийн дийлэнхийг эзлэх үл хөдлөх хөрөнгийн үнэ буурсан төдийгүй банкууд барьцаа хөрөнгийг шууд захиран зарцуулах эрхгүй, чанаргүй зээлийг төлүүлэхэд нилээд хүндрэл үүсэж байна. Барьцаа хөрөнгөөр зээлийн үүргийг гүйцэтгүүлэхэд шүүхийн болон шийдвэр гүйцэтгэлийн шатанд 3-5 жилийг зарцуулдаг. Энэ нь банкинд нилээдгүй хүндрэл бэрхшээл, алдагдлыг хүлээлгэдэг байна. Чанаргүй зээл нь банкны үйл ажиллагаа хэвийн үед ч тохиолддог боловч уг зээлийн хэмжээ хэвийн хэмжээнээс өндөр, гадаад хүчин зүйлийн нөлөөлөл их улмаар энэ нь санхүүгийн хямралыг гүнзгийрүүлэх түвшинд хүрээд байгаа үед уг асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай.

**Чанаргүй зээлийн банкинд болон эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл**

***<u>Чанаргүй зээлийн банкинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:</u>***

Чанаргүй зээл нь банкны зээл олгох чадварыг багасгаж банкны ашиг орлогыг бууруулдаг (Хөрөнгө нь эргэн төлөгдөх ашиггүй ба хөрөнгийн нөөц болон хүчийг их шаарддаг учраас түүний алдагдсан боломжийн өртгийг (opportunity cost) ихэсгэдэг.)

- ***Чанаргүй зээл нь банкны зээл олгох боломжийг бууруулдаг:*** Төрийн эрх бүхий байгууллагаас банкуудын актив өөрийн хөрөнгөөр дэмжигдсэн байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл эргэн төлөлтийн доголдолтой зээлийн эрсдэлийн жин нэмэгддэг тул банкууд өөрийн зохистой харьцааг хангахын тулд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлага үүсдэг. Энэ нь банк иргэд болон нийгэмд нөлөө бүхий ашигтай ажиллах боломжтой аж ахуйн нэгжид зээл олгох боломжийг багасгадаг.

- ***Чанаргүй зээл нь ашиг орлогыг бууруулдаг.*** Банкууд нь төлөгдөөгүй хүүгийн төлбөрөөс шалтгаалан ашигаа алддаг. Тиймээс ирээдүйд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах зорилгоор одоогийн орлогынхоо тодорхой хувийг нөөц болгон зээлийн эрсдэлийн санд хадгалах шаардлагатай байдаг.

- ***Чанаргүй зээл нь банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт саад учруулдаг ба сангийн зардлыг нэмэгдүүлдэг.*** Зээлдэгчид нь үндсэн болон хүүгийн төлбөрөө төлөөгүйгээс шалтгаалан банкны бэлэн мөнгөний орох урсгал буурдаг. Тиймээс банк нь хугацаа дөхөж буй хадгаламж, шинэ зээл, болон шинэ бизнесийг санхүүжүүлэхийн тулд хөрөнгийн бусад өндөр үнэтэй эх үүсвэрийг олох шаардлагатай тулгардаг. Энэ нь эргээд зээлийн хүү улам өсөх шалтгаан болдог байна.

- ***Чанаргүй зээл нь бизнесийн түншлэлийн харилцааг алдах эрсдэлд оруулдаг.*** Банкны чанаргүй зээлийн хэмжээ өсөх тохиолдолд уг банктай хамтран ажилладаг талууд нь түншлэлээ бууруулах эсвэл зогсоох магадлалтай. Ингэснээрээ тухайн банкны авч болох хөрөнгийн эх үүсвэрийн боломж хумигдах болон шинээр хадгаламж эзэмшигчдийг татахын тулд илүү өндөр хадгаламжийн хүүг төлөх шаардлагатай болно.

- ***Чанаргүй зээл нөөц бололцоог багасгадаг.*** Банкны менежментийн баг болон ажилтан нь эргэн төлөлтийн доголдолтой зээлдэгчидтэй харилцсанаар банкны өөрсдийн үндсэн үйл ажиллагаа болох шинэ, санхүүгийн хувьд илүү хүчтэй үйлчлүүлэгчидийг татах, харилцах боломжоо алддаг. Доголдолтой зээлийг хариуцсан банкны ажилтан эрх бүхий байгууллага, хөрөнгө оруулагч, болон шинжээчдэд тухайн банк чанаргүй зээлээ хэрхэн шийдвэрлэх гэж байгаагаа цаг тухайд нь мэдээлэх шаардлагатай болдог бөгөөд ингэснээр банкны үйл ажиллагаанд илүү хүн хүч, цаг хугацаа зарцуулах хэрэгтэй болдог.

***<u>Чанаргүй зээлийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:</u>***

Чанаргүй зээл нь банкны чадавхийг сулруулж улмаар эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Тухайлбал:

- Банкны зээл олгох чадвар буурах нь аж ахуйн нэгж болон иргэд банкнаас мөнгө зээлэхэд хүндрэл учрах хэлбэрээр хэрэглээ болон хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж, эдийн засгийн уналт хямралаас гарах боломж нөхцөлийг удаашруулдаг. Мөн экспортлогчид банкнаас худалдааны зээлийн санхүүжилт авахад болон экспортод сөргөөр нөлөөлдөг.

- Чанаргүй зээл нь банкийг хямралд оруулж болзошгүй байдаг. Банкны санхүүгийн тайлан муудаж, банк чанаргүй зээлээс алдагдал хүлээхэд хадгаламж эзэмшигч нар банкны төлбөрийн чадварт эргэлзэж, банкнаас хадгаламжаа татаж эхэлдэг. Эдийн засгийн үйл ажиллагаа (ЖДҮ-ийн санхүүжилт, худалдааны санхүүжилт, дэд бүтцийн санхүүжилт болон өрх гэрийн санхүүжилт), хүртээмжтэй өсөлтийг дэмжих оролдлогод сөргөөр нөлөөлдөг зээлийн хязгаарлалтыг бий болгосны улмаас банкны хямрал бий болдог.

- Банкны үйл ажиллагааны тогтвортой бус байдал нь өөр бусад хөрөнгийн зах зээлийн сегмент, тухайлбал бонд, хувьцаа, өмч болон өргөн хэрэглээний бараанд хүчтэй нөлөөлж, санхүүгийн зах зээлийн өсөлт, хөгжлийг зогсоодог.

Монгол Улсын эдийн засаг банкны салбараас ихээхэн хамааралтай тул тус салбар дахь чанаргүй зээл нь Монгол Улсад нийт эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Хөрөнгийн зах зээл болон банк бус санхүүгийн байгууллага сайн хөгжөөгүй учир Монгол Улсын зээлийн хэрэгцээ банкнаас хамааралтай байсаар байна. Банкууд хөрөнгө, хувьцааны болон санхүүгийн зах зээлд том үүрэг гүйцэтгэж байна. Банк нийгэм-эдийн засгийн чухал давхарга болох компани, жижиг дунд үйлдвэр, нөхөрлөл, хоршоо, иргэд зэрэг бүхий л давхаргатай холбоотой ажилладаг. Иймээс иргэд, аж ахуйн нэгжийг санхүүгийн гүн хямралд орохоос сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох зорилгоор эдгээр эрсдэлээс сэргийлэх түгээмэл арга хэрэгсэл болох Актив удирдлагын мэргэшсэн тогтолцоог бүрдүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсээд байна. Активын удирдлагын тогтолцоог дараах нөхцөл байдал бүрэлдэн бий болсон нөхцөлд нэвтрүүлэх нь тохиромжтой байдаг байна:

1. Банкны чанаргүй зээлийн хувь хэмжээ эрс нэмэгдэж, санхүүгийн салбарын тогтвортой байдал алдагдах эрсдэл өндөр болсон үед,
2. Банкны өөрийн хөрөнгийн хэмжээ буурч, чанаргүй зээлээс үүдэлтэй алдагдлыг нөхөх боломж эрс хумигдсан,
3. Хууль эрх зүйн тогтолцооны онцлог байдлаас шалтгаалж их хэмжээний чанаргүй зээлийг нэг дор шийдвэрлэх боломж хязгаарлагдмал байгаа.

Монгол Улсын банкны салбарт дээрх нөхцөл байдал бүрэн бүрдсэн гэж үзэж актив удирдлагын мэргэшсэн тогтолцоог бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Актив удирдлагын мэргэшсэн тогтолцоог бий болгох замаар банкны салбарын чанаргүй активыг шийдвэрлэх нь банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэж байх тул Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг “банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах” гэж тодорхойллоо.

## ХОЁР. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “*Банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах*” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 3

| Хувилбар | | Зорилгод хүрэх байдал | Зардал, үр өгөөжийн харьцаа | Үр дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Тэг хувилбар | Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй. | Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ. | Үр дүн сөрөг |
| 2 | Хэвлэл | Зорилгыг бүрэн хангахгүй ч | Зардал тодорхой | Үр дүн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх | төрийн байгууллага болон иргэдийн идэвхи, хяналт тодорхой хэмжээнд нэмэгдэх магадлалтай. | хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй . | сөрөг |
| 3 | Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх | Тодорхой тохиолдолд татвар, хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх нь зарим талаар үйл ажиллагааг дэмжих ач холбогдолтой ч зорилгыг бүрэн хангаж чадахгүй. | Тодорхой хэмжээний зардал гарна. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй . | Дангаараа үр дүнд хүрэхгүй |
| 4 | Төрөөс санхүүгийн интервенци хийх | Банкыг чадавхижуулах чиглэлд тодорхой мөнгөн дэмжлэг үзүүлэх нь зарим талаар банкны үйл ажиллагааг дэмжих хэдий ч зорилгыг хангаж чадахгүй. | Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй. | Үр дүнд хүрэхгүй |
| 5 | Захиргааны шийдвэр гаргах | Хамрагдах хүрээ, оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, хяналт сайжрах боломж бүрдэх боловч үр дүнд төдийлөн ахиц гаргаж чадахгүй. | Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй . | **Тодорхой үр дүнд хүрнэ.** |
| 6 | Хууль тогтоомжийн төсөл боловсруулах | -Банкуудад тавих эрсдэлийн сан байгуулах шаардлага, чанаргүй зээлийг тэнцлээс гаргах бодлого, шалгуур үзүүлэлтийг оновчтой болгож зах зээлд шилжүүлэх үйл явцыг хурдасгах;<br>-Өрийн нөхцөлийг оновчтой өөрчлөхөд гарч буй татварын болон хяналт шалгалтын зохицуулалттай холбоотой үүсэх хүндрэлүүдийг арилгах;<br>-Төлбөрийн чадваргүй зээлдэгчдээс төлбөрийг барагдуулах үйл ажиллагаа болон шүүхийн бус замаар төлбөр барагдуулах үйл явцыг сайжруулах хууль зүйн зохицуулалтыг | Зардал гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой. | **Үр дүнтэй** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | сайжруулах;<br>-Чанаргүй активыг удирдах тусгай байгууллагыг үүсгэн байгуулах нь тодорхой зээлүүдийн нөхцөл, бүтцэд өөрчлөлт оруулах шинэ арга хэрэгслийг банкуудад олгож, зээлдэгчдэд өөрөө шийдвэрлэх боломжийг бий болгоно; | | |

Манай орны хувьд банкны чанаргүй зээлийг шийдвэрлэх дараах арга хэрэгсэл байна.

Нэгдүгээрт чанаргүй зээлийн барьцааг худалдан борлуулах. Банкны системийн нийт зээлийн 90 орчим хувь нь барьцаагаар баталгаажсан хэдий ч 2004-2014 оны мэдээнээс үзэхэд муу зээлийн зөвхөн 35 орчим хувь нь эргэн төлөгдсөн байна. Үүнд барьцааны зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь голлон нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл, зээлийн барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулах нэхэмжлэлийг зээлдэгч тал шүүхийн байгууллагад гаргаж, холбогдох шийдвэрийг гаргуулах шаардлагатай бөгөөд энэхүү ажиллагаа нь хугацаа шаардахаас гадна, барьцааны үнэлгээг бууруулах үр дагавартай. Үүнээс гадна шүүхийн шийдвэрийг биелүүлэх явцад хөрөнгийн үнэлгээ болон ашиг сонирхлын зөрчлөөс шалтгаалан маргаан гарч шүүхээр дахин шийдвэрлүүлэх, үүрэг гүйцэтгүүлэгч тал хариуцлагад татагдах боломжтой.

Хоёрдугаарт Монголбанк, Сангийн яамнаас баталсан журмын дагуу нэгэнт төлөгдөхгүй болсон зээлийг зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах эрсдэлийн сангаар хаах. Өнөөдрийн байдлаар тус санд хуримтлуулсан хөрөнгийн хэмжээ нийт чанаргүй зээлийн 63 хувь байгаа хэдий ч зөвхөн шүүхийн шийдвэр гарсан боловч төлөгдөхгүй болсон эсвэл тодорхой шүүхийн шийдвэр гаргах боломжгүй болсон муу активыг эрсдэлийн сангаас хааж болох зохицуулалт үйлчилж байна. Өөрөөр хэлбэл, зээл төлөгдөхгүй нь тодорхой байлаа ч заавал шүүхийн шийдвэрийг хүлээх шаардлага гарч байна. Үүнээс гадна чанаргүй зээлийг тайлан тэнцэлд байлгах хугацааны дээд хязгаарыг тогтоож өгөөгүйгээс эрсдэлийн сангаас хаах шаардлагыг бүрэн хангасан зээлийг сангаар хааж, тайлан тэнцлээ цэвэрлэхгүй байх тохиолдол түгээмэл байгаа юм.

Банкууд дээрх хоёр үйл ажиллагааг чанаргүй активыг удирдах тусгай нэгжийг байгуулах замаар тус тусдаа гүйцэтгэж байна. Харин олон улсад чанаргүй зээлийг шийдвэрлэх чиглэлд ашиглаж буй томоохон арга хэмжээ бол **чанаргүй активын эргэн төлөлтийг гүйцэтгэх** (bankruptcy and foreclosure) **чиглэлд мэргэшсэн мэргэжлийн байгууллага юм.** Энэхүү байгууллага нь банкуудын чанаргүй активыг шилжүүлэн авах эсвэл зохистой үнээр худалдан авч шийдвэрлэх замаар санхүүгийн зардлыг бууруулж, үр ашигт ажиллагааг хангах давуу талыг бүрдүүлдэг байна. Үүнээс гадна системийн хэмжээнд активын чанар алдагдах хямралын үед банкны систем чанаргүй активаасаа шуурхай салах нь санхүүгийн зуучлалыг цаашид хэвийн үргэлжлүүлэх боломжийг

бүрдүүлдэг онцгой ач холбогдолтой бөгөөд уг мэргэжлийн байгууллагын эрх зүйн байдал, чиг үүрэг болон бусад холбогдох харилцааг тусгай хуулиар зохицуулах нь үр дүнтэй юм.
Харьцуулалтын үр дүнг харгалзан үзвэл дараахь 2 хувилбар илүү эерэг нөлөөтэй байх магадлалтай байна:
- **Хувилбар-1:** Урьдчилсан байдлаар хувийн хэвшлийн оролцоотой, Монголбанкнаас чиглэл авдаг, хараат бус статустай, чанаргүй активыг худалдан борлуулах давуу эрх бүхий тусгай Актив Удирдлагын Компани байгуулж, татварын болон хяналт шалгалтын зохицуулалттай холбоотой бусад хөнгөлөлтийг тус компани болон банкуудад үзүүлэх замаар хоёрдогч захын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор ***захиргааны акт батлан хэрэгжүүлэх***;
- **Хувилбар-2:** Санхүүгийн салбарт Активын удирдлагын компанийг шуурхай байгуулж, түүнийг тусгай эрх зүйн орчноор хангах замаар чанаргүй активын удирдлагын нэгдсэн тогтолцоо бүрдүүлж, санхүүгийн салбарт активын хоёрдогч зах зээлийг бий болгох ***асуудлыг цогцоор нь зохицуулах бие даасан хуулиар зохицуулах.***

## ГУРАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон 2 хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.
Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

3.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хувилбар 1, 2-ын хүрээнд уг харилцаанд оролцогч талуудын эрх зүйн байдал тодорхойлогдож, чанаргүй активаас үүсэх тодорхой эрсдлээс хамгаалах, хариуцлагыг нэмэгдүүлэх, тодорхой санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зэргээр хүний эрхийг дэмжих, хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгоно.
Санхүүгийн систем дэх зээлийн эргэн төлөлтийн явц удаашралтай байгаагаас банкуудын зээлийн эрсдэл нэмэгдэх, зохистой харьцааны голлох үзүүлэлтүүд муудаж төлбөрийн чадварын хүндрэлд орохоос сэргийлэх хөрвөх чадвартай хоёрдогч захын үйл ажиллагаа хөгжүүлэх, чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэгдэх тул ялгаварлан гадуурхалт бий болгохгүй болно.

Мөн чанаргүй зээлийг үр дүнтэй шийдвэрлэх хүрээнд уг зээлд холбогдох нэхэмжлэлийг онцгой журмаар шийдвэрлэх шаардлагатай тул уг асуудлыг хуулиар зохицуулах нь үр нөлөөтэй байна.

3.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Сонгосон хоёр хувилбарын аль аль нь төрийн байгууллагын захиргааны зардал, хүний нөөцийг хэмнэх чиглэлд улсын төсөвт ирээдүйд учирч болзошгүй их хэмжээний зардлыг бууруулж, тодорхой хэмжээнд хэмнэлтийг бий болгохын зэрэгцээ төрийн

үйлчилгээнд инноваци[1] болон түүнтэй холбогдох судалгаа шинжилгээний ажлыг нэвтрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.
Мөн дээрх хоёр зохицуулалтын аль ч хувилбарыг хэрэгжүүлсэн тодорхой зардал гарах боловч хуулийн төслөөр уг харилцааг зохицуулсанаар эдийн засаг дахь чанаргүй зээлийн хэмжээ буурч, эдийн засаг тогтвортой өсөх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

3.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хоёр хувилбарын хувьд аль аль нь нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэгээр нөлөөлнө.
Хувилбар 2-ыг хэрэгжүүлэх нь өнөөдөр тулгамдаад байгаа олон асуудлыг шийдвэрлэх, илүү үр дүнг бий болгох магадлалтай байна. Харин хувилбар 1-ийг хэрэгжүүлэх нь тодорхой салбарын онцлогт нийцсэн зохицуулалт, хяналтыг тогтоох боломжтой байгаа нь анхаарал татаж байна.

3.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хувилбарууд бүгд байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй. Байгалийн баялаг ашиглалт, нөхөн сэргээлтийн чиглэлд иргэний нийгмийн хяналтыг нэмэгдүүлэх магадлалтай.

3.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн хуульчилсан. Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлд төрд эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах үүргийг хүлээлгэсэн бөгөөд энэ талаар хуульчлан баталгаажуулсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” батлах тухай 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Тэргүүн ээлжинд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн жагсаалтын 4 дэх хэсэгт арилжааны банкуудын оролцоотойгоор активын удирдлагын институц байгуулж, банкны системийн чанаргүй зээлийн хэмжээг бууруулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Активын удирдлагын институцийн тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгасан байна.

Иймд дээрх хувилбарууд нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын Олон улсын гэрээнд нийцэж байгаа болно.

---

[1]Инновацийн тухай хуулийн 3.1.1. “инноваци” гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл явцыг; 3.1.3.“инновацийн үйл ажиллагаа” гэж шинэ санаа, шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, технологи, ажил, үйлчилгээг бий болгож зах зээлд нийлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг;

## ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараахь дүгнэлтийг хийлээ.

Эрх зүйн орчныг сайжруулахын тулд хувилбар 1-ийг буюу захиргааны актыг нэгдсэн, эсхүл салбар бүрийн онцлогт нийцүүлэн батлан мөрдүүлж болох боловч энэ нь асуудлыг цогцоор шийдвэрлэж чадахгүй. Тухайлбал: тухайн журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульд тусгахгүйгээр хэрэгжилтийг хангахад бэрхшээл учрахаас гадна асуудлыг цогц хэлбэрээр зохицуулах буюу салбар бүрийн оролцоог бүрдүүлэх, мөн иргэд, хуулийн этгээдэд тавих шаардлага, хязгаарлалт, татвар, хураамжийн хөнгөлөлт зэрэг асуудлыг хуулиар бус журмаар зохицуулахад бэрхшээл үүснэ. Мөн энэхүү эрх зүйн акт нь хуультай харьцуулахад тогтвортой үйлчлэх баталгаа хангалтгүй юм. Түүнчлэн 1990-ээд оны үед актив удирдлагын мэргэшсэн институтыг байгуулж, ажиллуулах оролдлогыг хийж байсан туршлага байх боловч тусгайлсан зохицуулалтгүйгээс төдийлөн үр дүнд хүрээгүй байдаг. Захиргааны актын хүрээнд уг институтыг байгуулах нь чанаргүй зээлийг үр дүнтэй, түргэн шуурхай барагдуулах хоёрдогч захыг хөгжүүлэх суурь зохицуулалтыг орхигдуулах, төдийлөн үр дүнд хүрэхгүй байх сөрөг үр дагавартай гэж үзэж байна

Хувилбар 2 буюу хууль батлан хэрэгжүүлэх нь өнөөгийн тулгамдаад байгаа сөрөг үр дагаварыг бууруулах, хяналт, үр дүнг сайжруулах зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх боломж өндөр байна. Гадны туршлагаас харахад бүх шатандаа нэгдсэн ойлголттой болж, улс төрийн болон төрийн эрх бүхий байгууллагуудын зүгээс зохих туслалцаа, дэмжлэгийг авсан нөхцөлд активын удирдлагын тогтолцоо нь амжилттай хэрэгждэг байна. . Иймд тус харилцааг хуулиар зохицуулах нь банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, банкны салбарын чанаргүй зээлийг шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгод хүрэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

Актив удирдлагын компани бол банкнаас чанаргүй активыг авч уг хөрөнгийн эргэн төлөгдөх дүнг нэмэгдүүлэх зорилгоор удирдан ажилдаг хувийн, төрийн эсвэл хамтарсан хэлбэрээр байгуулагддаг байгууллага юм. Банкны балансаас чанаргүй зээлийг хассанаар, Актив удирдлагын компани нь санхүүгийн хүндрэлд орсон банкуудын төлбөрийн чадвар болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дахин сэргээхэд тусалдаг бөгөөд тэдний найдвартай байдлыг дахин бий болгож, үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг олгодог. Иймд актив удирдлагын мэргэшсэн тогтолцоог бий болгох хуулийн төслөөр банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Актив удирдлагын компани байгуулах, банкнаас хуульд тодорхойлсон чанаргүй зээлийг худалдан авах, түүнтэй холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна. Мөн уг төсөлд актив удирдлагын компанийг тодорхой хугацааны

дараа хуульд заасан үндэслэлээр татан буулгахтай холбогдсон зохицуулалтыг нарийвчлан тусгах нь зүйтэй юм.

## ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 4

| Үзүүлэх үр нөлөө: | Холбогдох асуултууд | Харнулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| | | | | |
| 1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх | **1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх** | | | |
| | 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх | Тийм | | Нийтийн ашиг сонирхлын үүднээс АУК-д тодорхой шалгуур тавьж, хязгаарлалт тогтоох боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш. |
| | 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх | | Үгүй | Нийтийн ашиг сонирхлын үүднээс АУК-д тодорхой шалгуур тавьж, хязгаарлалт тогтоох боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш. |
| | 1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх | Тийм | | Өрсөлдөөнийг шударга, хэрэглэгчдэд ээлтэй байх зарчимд тулгаарлан сөрөг үр дагаварыг бууруулахад зохицуулалтын зорилго чиглэгдэнэ. |
| | **1.2. Оролцоог хангах** | | | |
| | 1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх | Тийм | | Холбогдох төрийн болон арилжааны банкуудтай мэдээлэл хуваалцаж, оролцоог хангасан. |
| | 1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх | Тийм | | Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон. |
| | **1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал харнуцлага** | | | |
| | 1.3.1.Зохицуулалты | Тийм | | Шууд бус утгаараа нийт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | г бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх | | | иргэдийн эдийн засгийн эрхийг хангахад чиглэгдэнэ. |
| | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх | **Тийм** | | Шудрага, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн. |
| | 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх | **Тийм** | | Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг зохицуулна. |
| **2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх** | 2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх | | **Үгүй** | Шудрага ёсонд нийцсэн шаардлагын үндсэн дээр тодорхой хязгаарлалт тогтооно. |
| | 2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх | **Тийм** | | Энэхүү хязгаарлалт нь нийтийн эрх ашгийн үүднээс зайлшгүй шаардлагатай бөгөөд Үндсэн хуульд заасан зайлшгүй нөхцөлд хамаарна. |
| **3. Эрх агуулагч** | 3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх | **Тийм** | | • Банк<br>• Үйлчлүүлэгч иргэд |
| | 3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх | | **Үгүй** | Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлэг буюу банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэнэ. |
| | 3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх | **Тийм** | | Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлэг буюу банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэнэ. |
| | 3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн | | **Үгүй** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/ | | | |
| **Үүрэг хүлээгч** | 4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх | **Тийм** | | Төр, АУК, банк |
| **4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх** | 5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх | **Тийм** | | Хүйсээр ялгаварлах зохицуулалт тусгагдаагүй. |
| | 5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх | **Тийм** | | Шалгуур, сонгон шалгаруулалт, гэрээлэх үйл явц, хөдөлмөр эрхлэх, хяналтын бүх нөхцөлд жендэрийн тэгш байдлыг бүрдүүлсэн. |

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

**Хүснэгт 5**

| Үзүүлэх үр нөлөө: | Холбогдох асуултууд | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар | 1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) | **Тийм** | | Банк хөрөнгө оруулалт татах боломж нэмэгдэнэ. |
| | 1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх | **Тийм** | | Санхүүгийн тогтортой байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт сайжирснаар дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөлөл багасна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал | 2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал | 3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал | 4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 5.Өмчлөх эрх | 5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд | **Тийм** | | Хуульд заасан нөхцөл үүссэн тохиолдолд үүрэг гүйцэтгэгч |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх | | | холбогдох үүргийг албадан гүйцэтгэснээр өмчлөх эрхийг хөндөх зохицуулалт холбогдох хууль тогтоомжид орно. |
| | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх | **Тийм** | | Холбогдох хуулийн өөрчлөлтүүд хөндөх магадлалтай |
| | 5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| 6.Инноваци болон судалгаа шинжилгээ | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| | 6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| 7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв | 7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | Санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулснаар тодорхой эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх | **Тийм** | | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх | **Тийм** | | Санхүүгийн тогтвортой байдлыг хангаснаар үнийн тогтвортой байдалд нөлөөлж хэрэглэгчдийн эрх ашигт эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| 8.Тодорхой бүс нутаг, салбарууд | 8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий | **Тийм** | | Шинээр актив удирдлагын мэргэжсэн иституци байгуулагдана |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | болгох эсэх | | | |
| | 8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | Санхүүгийн тогтвортой байдлыг хангаснаар эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх боломжийг бүрдүүлж өгснөөр бизнесийн орчины таатай байдал бий болох эерэг нөлөө үзүүлнэ. |
| 9.Төрийн захиргааны байгууллага | 9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | Шинээр төрийн өмчит хуулийн этгээд үүсгэн байгуулахад тодорхой санхүүжилт шаардлагатай. |
| | 9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх | | **Үгүй** | Шинээр төрийн өмчит актив удирдлагын мэргэшсэн иституци байгуулагдана |
| | 9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх | **Тийм** | | Шинээр актив удирдлагын мэргэшсэн иституци байгуулагдах тул түүний үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг нэмэгдэнэ. |
| 10.Макро эдийн засгийн хүрээнд | 10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх | **Тийм** | | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 10.3.Инфляци нэмэгдэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 11.Олон улсын харилцаа | 11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх | **Тийм** | | Зөрчилдөөн үүсэхгүй. |

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 6

| Үзүүлэх үр нөлөө: | Холбогдох асуултууд | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл | 1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх | Тийм | | Шинээр актив удирдлагын мэргэшсэн иституци байгуулагдана |
| | 1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх | 2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| | 2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| | 2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| | 2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх | | Үгүй | Шинэ стандарт гаргахгүй |
| | 2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх | | Үгүй | Технологийн шинэчлэлтэй холбогдолтой зохицуулалт хуулийн төсөлд тусгагдаагүй. |
| 3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал | 3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх | | Үгүй | нийгмийн аливаа бүлэгт сөрөг нөлөөлөлгүй |
| | 3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт | | | |
| | 3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| 4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун | 4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| | 4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | **Тийм** | | Шинээр актив удирдлагын мэргэшсэн иституци байгуулагдах тул түүний үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг нэмэгдэнэ. |
| | 4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх | **Тийм** | | Шинээр актив удирдлагын мэргэшсэн иституци байгуулагдах тул түүний үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг нэмэгдэнэ. |
| | 4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | Шүүхийн шатанд чанаргүй активтай холбогдсон маргааныг шийдвэрлэх хугацааг богиносгож, шүүхийн үйл ажиллагааг түргэн шуурхай болгох тул оролцогч талуудад давуу талтай. |
| | 4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| 5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал | 5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх | **Тийм** | | Санхүүгийн хямралаас урьдчийан сэргийлж тогтвортой байдлыг үүсгэснээр шууд бус замаар хувь хүн, иргэний сэтгэл зүйд эерэг нөлөөллийг үзүүлнэ. |
| | 5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| 6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем | 6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх | Тийм | | Үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч эерэг нөлөө гарна. |
| | 6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| | 6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| | 6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| | 6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| 7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал | 7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх | Тийм | | Үйлчилгээний хүртээмж, чанар сайжирснаар гэмт хэргийн гаралт буурч, эерэг нөлөө гарна. |
| | 7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| | 7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| | 7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8.Соёл | 8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Соёлын өвийг хөндсөн зохицуулалт тусгагдаагүй бөгөөд ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |
| | 8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй |

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 7

| Үзүүлэх үр нөлөө: | Холбогдох асуултууд | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Агаар | 1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | | Үгүй | Нөлөөлөлгүй |
| 2.Зам тээвэр, түлш, эрчим хүч | 2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх | | Үгүй | Нөлөөлөлгүй |
| | 2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх | | Үгүй | Нөлөөлөлгүй |
| | 2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Сөрөг нөлөөлөлгүй |
| | 2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | | Үгүй | Нөлөөлөлгүй |
| 3.Ан амьтан, ургамлыг хамгаалах | 3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нөлөөлөх эсэх | | | |
| | 3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 4.Усны нөөц | 4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 5.Хөрсний бохирдол | 5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 6.Газрын ашиглалт | 6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх | | **Үгүй** | Нөлөөлөлгүй |
| | 6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх | | **Үгүй** | Нөлөөлөлгүй |
| | 6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх | | **Үгүй** | Нөлөөлөлгүй |
| 7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг | 7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх | | **Үгүй** | Нөлөөлөлгүй |
| | 7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх | | **Үгүй** | Нөлөөлөлгүй |

## ТАВ.ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Азийн санхүүгийн хямралаас хойш тус бүс нутгийн чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин буурсаар байна. Энэхүү бууралт нь нэг талаас бүс нутгийн эдийн засгийн ерөнхий төлөв байдал сайжирсантай холбоотой ч нөгөө талаас бүс нутгийн банкуудын эрсдэлийн удирдлага сайжирсантай бас холбоотой. Жишээлбэл, цөөнгүй орнуудад Активын удирдлагын компанийг байгуулсан нь чанаргүй зээлийг үр ашигтай аргаар шийдвэрлэхэд түлхэц болж өгсөн.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч, АНУ-д мөнгөний хатуу бодлого явуулж эхэлсэнтэй холбоотойгоор Азийн бүс нутгийн ихэнх орнуудын банкны системд чанаргүй зээл өсөх эрсдэлтэй тулгарч байна. Тухайлбал, БНХАУ, Энэтхэг, Монгол зэрэг орнуудад 2013 оноос хойш чанаргүй зээл хувийн жингээрээ болон абсолют дүнгээрээ өсөх хандлага ажиглагдсан.[2]

Азийн орнууд дахь чанаргүй зээлийн нийт эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн талаар хийгдсэн судалгаа хомс байдаг. Гэвч, чанаргүй зээл цаг хугацааны туршид хэрхэн өөрчлөгддөг болон түүнийг ямар хүчин зүйлс тодорхойлж байдаг талаар олон улсын банк санхүүгийн байгууллагаас дараах дүгнэлтийг хийсэн байна.

**Нэгдүгээрт** макро эдийн засгийн ерөнхий төлөв байдал нь зээлдэгчийн зээлээ төлөх чадвараар дамжин нөлөөлдөг.

**Хоёрдугаарт** тухайн банкны онцлог шинж чанарууд мөн нөлөөлдөг гэж үздэг.

Азийн хөгжлийн банкны судалгаагаар (Lee, 2016)[3] Азийн бүс нутагт ажиглагдаж байгаа чанаргүй зээлийн өсөлтөд дээр дурьдсан хоёр хүчин зүйл хоёул нөлөөлсөн гэж үзсэн. Бодит ДНБ-ний өсөлт, ажилгүйдлийн өөрчлөлт болон инфляцийн түвшин чанаргүй зээлд ихээхэн нөлөөлдөг нь тогтоогдсон. Түүнчлэн, тухайн банкны онцлогтой холбоотой хүчин зүйлс статистикийн хувьд ач холбогдолтой тогтоогдсон. Тухайлбал харьцангүй бага өөрийн хөрөнгөтэй банкууд чанаргүй зээлийн хувь өндөртэй байдаг нь тогтоогджээ. Эрсдэлд хэр өртөмтгий байдлаас хамааран зээл хадгаламжийн харьцаа чанаргүй зээлтэй эерэг хамааралтай гэдэг нь мөн тогтоогдсон байна.

***АУК-ий Үйл ажиллагааны цар хүрээ***

Чанаргүй зээлийг шийдвэрлэх үр дүнтэй тогтолцоо болох Активын удирдлагын компани нь дараах чиг үүргийг гүйцэтгэдэг байна.

1. Хүндрэлд орсон санхүүгийн байгууллагуудын чанаргүй зээлийг өөртөө авах, удирдах. Энэ нь буцаан төлөлтийг хамгийн өндөр байлгах зорилготойгоор хэрэгждэг.

2. Хүндрэлд орсон банкуудын үйл ажиллагааг сайжруулахад оролцох. Банкны удирдлагын үйл ажиллагааг нь сайжруулах, банкуудыг нэгтгэх, худалдах үйл ажиллагаанд оролцох зэрэг арга хэмжээнүүд хэрэгжүүлдэг.

---

[2] ADB mission team note "Regional experience in dealing with distressed assets in Asia" , 12 Feb 2017
[3] Asian economic integration report, Asian Development Bank, 2016

3. Компанийн бүтцийн өөрчлөлтийг хийх. Тухайн компанийн банкны зээлээ төлөх чадварыг сайжруулахад чиглэгддэг.

Эдгээр үйл ажиллагаа тус бүртээ нилээ ажиллагаа шаарддаг учраас Актив удирдлагын компани аль нэг үйл ажиллагаандаа хэт төвлөрөх эрсдэл гардаг ба улмаар тус компанийн үйл ажиллагаа доголдох талтай байдаг.

*Үйл ажиллагаа явуулах хугацаа*

Зарим Актив удирдлагын компани тодорхой хугацаатай байгуулагдсан байдаг. Тодорхой хугацаа зааж өгснөөр чанаргүй зээлийн эргэн төлөлтийг хурдасгаж улмаар уг компани тавьсан зорилтоо хугацаандаа биелүүлдэг давуу талтай.

Хөгжиж буй орнуудад Актив удирдлагын компанийг байнгын ажиллагаатай байлгах боломжтой. Тухайлбал, мөчлөгийн хэвийн үед Актив удирдлагын компани бага орон тоотойгоор ажиллах боломжтой. Учир нь нэг талаас чанаргүй зээлийг шийдвэрлэх нь хугацаа шаарддаг ажил бөгөөд нөгөө талаас банкны хямрал үе үе тохиолддог учраас байнгын ажиллагаатай байлгах тохиолдлууд гардаг.

Чанаргүй зээлээс бусад үйл ажиллагаа явуулдаг Актив удирдлагын компани байнгын ажиллагаатай байдаг. Жишээ нь: Солонгосын АУК (KAMCO) нь төрийн өмчийг удирддаг бол Туркийн АУК (SDIF) хадгаламжийн даатгалын үйл ажиллагаа явуулдаг.[4]

*Актив удирдлагын компанитай хамтрагч байгууллагууд*

Актив удирдлагын компани нь банкууд болон санхүүгийн байгууллагууд, компаниудтай хамтран ажилладаг. Тухайлбал, чанаргүй зээлийг банкуудаас худалдан авдаг ба зарим тохиолдолд банк бус санхүүгийн байгууллагуудаас эсвэл санхүүгийн бус компаниудаас худалдан авдаг. Түүнчлэн, компанийн бүтцийн өөрчлөлтийг хийх хүрээнд Актив удирдлагын компани компаниудаас актив худалдан авах эрхтэй байдаг.

*Худалдан авах активууд*

Бүх Актив удирдлагын компани чанаргүй зээлийг худалдан авдаг бол зарим Актив удирдлагын компани хэвийн зээл худалдан авах боломжтой байдаг.

Түүнчлэн, Актив удирдлагын компани хувь эзэмших эрх, үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас, автомашин болон бусад активууд худалдан авах боломжтой байдаг

Хүснэгт 8[5]

| Худалдан авах активууд | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Индонез** | **Япон** | **Ө.Солонгос** | **Малайз** | **Тайланд** |
| *Оролцогч байгууллагууд* | | | | | |
| Зөвхөн сонгогдсон банкуудаас | Тийм | Тийм | Тийм | Тийм | Тийм |
| Бүх банкуудаас | Тийм | Тийм | Тийм | Тийм | Үгүй |

[4] "Public asset management companies in East asia", Occasional paper No3, Financial stability institute, 2004

[5] Table 6 in "Public asset management companies in East asia", Occasional paper No3, Financial stability institute, 2004

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Бүх банк болоод банк бусуудаас | Үгүй | Тийм | Тийм | Тийм | Үгүй |
| | | | | | |
| ***Активуудын торол*** | | | | | |
| Хэвийн зээл | Тийм | Тийм | Үгүй | Үгүй | Үгүй |
| Чанаргүй зээл | Тийм | Тийм | Тийм | Тийм | Тийм |
| Зээлүүд | Тийм | Тийм | Тийм | Тийм | Тийм |
| Банкууд | Тийм | Тийм | Үгүй | Тийм | Үгүй |
| Бусад активууд (үл хөдлөх, автомашин гэх мэт) | Тийм | Тийм | Тийм | Тийм | Үгүй |
| | | | | | |
| Зээлийн хэмжээний хязгаарлалтууд | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм | Үгүй |
| Зээлийн хугацааны хязгаарлалтууд | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |

***Хяналт***

Олон нийтийн хөрөнгийг үр ашигтайгаар ашиглах, Чанаргүй зээлийг түргэн шуурхай шийдвэрлэхэд Актив удирдлагын компанийн засаглал сайн байх ёстой.

Төрөөс тус компанид тодорхой хэмжээний хөрөнгө оруулах тул хяналт шалгалтын байгууллага Актив удирдлагын компанийн үйл ажиллагааг хянах ёстой. Актив удирдлагын компанийн хяналтыг дараах байгууллага гүйцэтгэх нь элбэг ажиглагддаг:

- Санхүүгийн хяналт шалгалт явуулдаг байгууллага (төв банкнаас гадуур хийгддэг тохиолдолд)
- Сангийн яам
- Төв банк (түгээмэл биш)

***Актив удирдлагын компанийн засаглал***

Ихэнхи Актив удирдлагын компани дараах байгууллагын төлөөлөл бүхий удирдлагын хороотой байдаг:

- Сангийн яамны төлөөлөл
- Хадгаламжийн даатгалын төлөөлөл
- Хараат бус (төрийн бус) төлөөлөл (тодорхой шалгуууртай байх ёстой ба ашиг сонирхлын зөрчилгүй байх)
- Зөвлөхүүд
- Зарим Актив удирдлагын компани Захирлуудын зөвлөлтэй байдаг

Удирдлагын хороо нь хувь нийлүүлэгчдийн хуралтай төстэй. Жишээ нь: Солонгосын Актив удирдлагын компани болох КАМСО-ийн удирдлагын хороо Сангийн

яам, Төлөвлөлт төсвийн яам, Солонгосын даатгалын корпораци, Төв банк, банкуудын төлөөлөл болон шинжээчдийн төлөөллөөс бүрддэг.[6]

*Ил тод байдал*

Ил тод байдал болоод хариуцлагын тогтолцоог өндөржүүлэхийн тулд эрх зүйн орчныг нь бий болгож өгөх ёстой болно. Дараах арга хэмжээг авах замаар ил тод байдлыг хангадаг.

- Жил болгон аудит хийлгэх (нэр хүндтэй гадны компаниар)
- Засгийн газрын хяналтын байгууллагад жил болгон тайлагнадаг байх (Актив удирдлагын компанийн санхүүжилт болон үйл ажиллагааны тайлан)

*Хараат бус байдал*

Олон улсын туршлагыг харахад Актив удирдлагын компани эцсийн дүндээ олон нийтийн төлөөллөөр дамжин олон нийтэд тайлагнах ёстой хэдий ч улс төрийн нөлөөллөөс ангид байх нь зүйтэй.

Актив удирдлагын компани нь хараат бус үйл ажиллагаа явуулах ёстой талаар Базелийн хороо, IAIS, IOSCO зэрэг олон улсын хяналт шалгалтын стандарт тогтоодог байгууллагууд зөвлөдөг.

*Хараат бус байдлыг хэрхэн хангах вэ?*

Актив удирдлагын компанийн хуулинд хараат бус байдлыг нь баталгаажуулан ил тод байдал, тайлагналтыг шаардах замаар Актив удирдлагын компанийн хараат бус үйл ажиллагааг хангах боломжтой.

Түүнчлэн, удирдах зөвлөлийн гишүүнийг зөвхөн тодорхой шалтгааны улмаас л эргүүлэн татдаг байхаар зааж өгөх нь тус зөвлөлийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад түлхэц өгдөг.

Зөвлөлийн гишүүдийг болоод Актив удирдлагын компанийн ажилтнуудыг хуулиар хамгаалж өгөх нь (indemnification) тус компанид хараат бус сайн боловсон хүчин татах, эдгээр хүмүүсийг тогтвортой ажиллуулах нөхцлөөр хангаж өгдөг.

*Хууль, эрх зүйн хамгаалалт*

Актив удирдлагын компанийн ажилтнууд хууль, эрх зүйн хамгаалалтад байх учиртай. Тухайлбал, энгийн үйл ажиллагаа явагдаж буй үед хувийн болоод байгууллагын маргаанаас Актив удирдлагын компанийн удирдах зөвлөлийн гишүүд болоод ажилтнууд хамгаалагдах учиртай (indemnification). Жишээ нь Ирландын Актив удирдлагын компани болох NAMA-ийн тухай хуулийн 34-р заалтаар энэхүү эрх зүйн хамгаалалтыг бий болгосон байдаг.

*Санхүүгийн эх үүсвэр*

Олон улсад Актив удирдлагын компанийн санхүүжилтийг дараах хоёр гол эх үүсвэрээс бүрдүүлсэн байдаг.

- Засгийн газрын санхүүжилт
- Актив удирдлагын компанийн бонд

[6] Caroline Cerutti and Ruth Neyens "Public asset management companies: A toolkit", World Bank, 2016

Зарим орны Актив удирдлагын компани нь шууд Засгийн газрын санхүүжилттэйгээр харьцангуй бага хэмжээний Чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэсэн байдаг. Жишээ нь: Япон, Тайвань, БНХАУ. Харин, харьцангуй том хэмжээтэй (ДНБ-д эзлэх хувиар) Чанаргүй зээлтэй орнууд Актив удирдлагын компанийг бонд гаргах замаар санхүүжүүлсэн байдаг.[7]

*Хууль, эрх зүйн тусгай эрхүүд*

Аливаа Актив удирдлагын компани чанаргүй зээлийг шийдэхэд саад болж байгаа эрх зүйн болоод зохицуулалтын тодорхой заалтуудыг тойрон гарах эсвэл алгасах тусгай эрхээр хангагдсан байдаг.

Нөгөө талаас, тусгай эрх олгогдоогүй Актив удирдлагын компани ч байдаг. Ихэвчлэн чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэхэд зохих эрх зүйн орчин нь аль хэдийнэ бүрдсэн орнуудад иймэрхүү тусгай эрх олголгүйгээр байгуулсан байдаг.

Ирландын NAMA буюу Актив удирдлагын компани нь компаний хэлбэрээр байгуулагдсан хэдий ч тодорхой хэмжээний тусгай эрхээр хангагдсан байдаг. Тухайлбал, тус Актив удирдлагын компани барьцаанд буй үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах тусгай эрхтэй ч үүнийгээ ашиглалгүй үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

*Улс орнуудын туршлага*

*Бүгд Найрамдах Солонгос Улс*

Азийн санхүүгийн хямралын эхэнд буюу 1997 онд БНСУ-д чанаргүй зээлийн хувь 5.8%-тай байсан ч тус улс богино хугацаатай гадаад өрийн дарамтанд орсон байсан. Тус улсын мөнгөн тэмдэгтийн ханш 1997 оны 10-р сард огцом суларсан нь өрийн дарамтыг улам хурцатгасан ба Засгийн газраас төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн эдгээр хүндрэлүүдийг даван туулсан. Тухайлбал, чанаргүй зээлийн огцом өсөлтөөс үүдэлтэй хүндрэлүүдийг шийдвэрлэхийн тулд тусгай сан байгуулж 3.5 их наяд воны (ойролцоогоор тухайн үеийн ханшаар 3.8 тэрбум ам.доллар) хөрөнгө оруулалт хийсэн. Энэхүү санг Солонгосын Актив Удирдлагын Компани (KAMCO-Korean Asset Management Company) хянадаг бөгөөд банкны систем дэх чанаргүй зээлийг аль болох хурдан худалдаж авах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулсан. Санхүүгийн хямрал 1997 оны 11-р сараас эхлэн улам гүнзгийрэхэд тус сангийн хөрөнгийг 10 их наяд вон (ойролцоогоор тухайн үеийн ханшаар 9 тэрбум ам.доллар) болгон өсгөсөн.[8]

Санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийг KAMCO-ийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хийсэн. Тухайлбал, хянан шалгагчдад хүндрэлд орсон санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг хянах, банкуудын нэгдэх үйл явцыг эрчимжүүлэх, банкуудын үйл ажиллагааг түр буюу бүрэн зогсоох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх зүйн боломжоор хангаж өгсөн.

*Бүгд Найрамдах Хятад Ард Улс*

---

[7] Caroline Cerutti and Ruth Neyens "Public asset management companies: A toolkit", World Bank, 2016

[8] Dong He "The role of KAMCO in resolving nonperforming loans in the Republic of Korea", IMF Working paper WP/04/172, 2004

Хэдийгээр БНХАУ 1997 оны санхүүгийн хямралд төдийлөн өртөөгүй ч тухай үед чанаргүй зээл 20%-д хүрсэн байсан. Энэхүү бүтцийн шинж чанартай тогтворгүй байдлыг арилгахын тулд 1998 оноос хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Төрийн өмчийн банкуудад хөрөнгө нэмж оруулах замаар өөрийн хөрөнгийг нь нэмэгдүүлсэн
2. Чанаргүй зээлийн ангилалд олон улсын стандарт ашиглаж эхэлсэн
3. Арилжааны зээлүүдийг төлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн
4. Орон нутгийн засаг захиргаанаас зээл олголтод нөлөөлөх нөлөөллийг алга болгох бодлого хэрэгжүүлсэн.

Эдгээр үйл ажиллагаануудын хүрээнд банкуудыг дахин хөрөнгөжүүлэх зорилгоор 270 тэрбум юаний Засгийн газрын бонд гаргасан. Гэсэн хэдий ч чанаргүй зээлийн хувь 20 гаруй хувь хэвээр үлдсэн.

Төрийн өмчийн дөрвөн том банк 1999 онд тус бүртээ Актив удирдлагын компани байгуулж чанаргүй зээлээ 10 жилийн туршид шилжүүлсэн. Нийтдээ 1.4 их наяд юаний буюу нийт зээлийн 20%, ДНБ-ий 18%-тай тэнцэх зээл шилжиж очсон. Гэхдээ энэ нь нийт чанаргүй зээлийн дөнгөж 50% гэж үнэлсэн байдаг. Энэхүү худалдан авалтыг хийхдээ Хятадын ардын банк (төв банк)-наас зээл авч хийсэн бөгөөд эрх зүйн хувьд дахиад хоёр өөр төрлийн санхүүгийн эх үүсвэр эдгээр банкуудад нээлттэй байсан. Тухайлбал, Сангийн яамны хөрөнгө оруулалт ба арилжааны зээл гэсэн нэмэлт эх үүсвэрүүд нээлттэй байдаг.

Актив удирдлагын компаниуд чанаргүй зээлийг бонд гарган Хятадын ардын банкинд худалдах замаар санхүүжүүлэн худалдан авсан. Гэсэн хэдий ч чанаргүй зээлийг зарах ажил харьцангүй удаашралтай явагдсан бөгөөд эргэн төлөлт (recovery rate) 21%-тай байсан. Чанаргүй зээлийг ийнхүү зарснаар эдгээр зээлийн хувийн жин 20% болж буурсан ч бүр хожим 2008 он гэхэд л 2.4% болжээ. Хятадын Засгийн газар 2004 онд Хятадын банк (Bank of China) болон Хятадын барилгын банк (China Construction Bank)-ны хувьцааг нээлттэй гаргахаар шийдсэн. Үүнтэй холбоотойгоор Хятадын ардын банк (төв банк) 320 тэрбум юантай тэнцэх чанаргүй зээлийг эдгээр банкуудын Актив удирдлагын компаниудад нэрлэсэн үнийн 30-40 хувиар үнэлэн шилжүүлсэн. Түүнчлэн, Засгийн газар нь 45 тэрбум ам.доллартай тэнцэх хөрөнгийг эдгээр банкуудад оруулсан нь тус банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг сайжруулсан.[9]

Дээр дурьдсан чанаргүй зээлийн бууралт нь нэг талаас Актив удирдлагын компани руу шилжүүлсэнтэй холбоотой ч нөгөө талаас эдгээр арга хэмжээнүүдийг бусад төрийн өмчийн банкуудад бас авч хэрэгжүүлсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Актив удирдлагын компанuуд өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна.

***Тайланд***

Азийн санхүүгийн хямралын үеэр Тайландын банкны систем дэх чанаргүй зээл огцом өсч, зээлийн олдоц муудаж ирсэн. Тус улсын Олон улсын валютын сантай хамтарсан 17.2 тэрбум ам.долларын Стэнд-бай хөтөлбөр 1997 оны 8-р сарын 5-нд батлагдсан. Энэхүү хөтөлбөрийн цөм нь банк, санхүүгийн байгууллагуудад бүтцийн өөрчлөлтийг хийх, чанаргүй зээлийг шийдвэрлэхэд оршиж байсан бөгөөд ОУВС-аас дараах нөхцлүүдийг тавьсан:

1. Дампуурсан байгууллагуудыг олж тогтоох, хаах
2. Хадгаламжинд болон зээлдэгчдэд Засгийн газрын баталгаа гаргах

[9] ADB mission team note "Regional experience in dealing with distressed assets in Asia" , 12 Feb 2017

3. Бүтцийн болоод зохицуулалтын шинж чанартай өргөн хүрээтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Тайландын Засгийн газар 1999 оны 9-р сар хүртэл тус хөтөлбөрийн 14.1 тэрбум ам. долларыг ашиглажээ.

Банкны систем дэх чанаргүй зээлийг шийдвэрлэхийн тулд Тайландын Засгийн газар тухайн үеийн хууль тогтоомжийн хүрээнд Актив удирдлагын компанийг байгуулсан. Тус компани нь дуудлагаар худалдсан активыг худалдан авах, зарах, удирдах эрхтэй. Төрийн эзэмшлийн банкнаас төрийн Актив удирдлагын компани руу шилжиж буй чанаргүй зээлүүдэд Засгийн газрын Санхүүгийн Байгууллагуудын Хөгжлийн Сан (ЗГСБХС) баталгаа гаргаж өгсөн байдаг. ЗГСБХС нь Засгийн газрын бондоор санхүүжигддэг бөгөөд тус сан 1998 онд алдагдал хүлээсэн. Тийм ч учраас Актив удирдлагын компанид төв банк нь хяналт тавьдаг. Чанаргүй зээлийн түвшин өндөр байсантай холбоотойгоор Тайландын Төв банк хувийн Актив удирдлагын компанийн үйл ажиллагааг дэмжиж ирсэн. Тухайлбал, хувийн Актив удирдлагын компаниудыг чанаргүй зээл зарсан тохиолдолд урамшуулал олгосон байдаг.[10]

***Индонези***

Азийн санхүүгийн хямралд өртсөн орнуудын нэг нь Индонези улс юм. Индонезийн төв банк 1997 оны 10-р сарын 31-нд Банкны салбар дахь хүндрэлийг даван туулах хөтөлбөрийг ОУВС-тай хамтран баталсан. Энэхүү хөтөлбөр 50 банкны үйл ажиллагааг хамарсан боловч эдгээрээс ихэнх банкууд нь хуурмаг үйл ажиллагаа явуулж байсан нь тогтоогдсон байдаг.

***Хүндрэлд орсон активын шийдэл:***

***Хамгийн сайн шийдлийн нэг нь Малайзын активын удирдлагын компани Данахарта.***[11]

*Данахартагын тухай*

Данахарта нь Малайзын Засгийн газрын байгуулсан Активын удирдлагын компани бөгөөд тус компаний өмчлөгч нь Сангийн яам юм.

Уг компани нь 1965 онд байгуулагдсан олон нийтийн (төрийн) өмчийн компани юм. Данахартагын үйл ажиллагааг Захирлуудын зөвлөл нь хянадаг ба энэхүү зөвлөлийг Банк Негара Малайз (Төв банк) болон Данахартагын Хяналтын зөвлөлөөс томилдог. Тус Хяналтын зөвлөлд Сангийн яам, Банк Негара Малайз болон Үнэт цаасны хорооны төлөөллүүд ордог.

Данахартагын гол зорилго нь санхүүгийн сектор дахь чанаргүй зээлийг санхүүгийн байгууллагуудаас худалдан авах, эдгээр зээлийн эргэн төлөлтийн (recovery rate) хувийг хамгийн их байлгахад оршдог. Ийм замаар Данхрата нь банкуудад зээлийн багцаа удирдах, өсгөх үйл ажиллагаанд нь дэмжлэг өгч санхүүгийн зах зээлийг идэвхжилд оруулдаг.

Тус компани дараах зорилготойгоор байгуулагдсан:

---

[10] ADB mission team note "Regional experience in dealing with distressed assets in Asia" , 12 Feb 2017

[11] ADB mission team note "Regional experience in dealing with distressed assets in Asia" , 12 Feb 2017

- Хүндрэлд орсон активыг шийдэх замаар санхүүгийн байгууллагуудад тусламж үзүүлэх,
- Санхүүгийн хүндрэлд орсон бизнесийн байгууллагуудад зохицуулалт хийх замаар бизнесийн секторт тусламж үзүүлэх,
- Санхүүгийн секторт бэлэн мөнгө оруулах замаар нийт эдийн засагт дэмжлэг үзүүлэх.

Данахарта нь энэ гурван зорилгодоо актив, пассивыг авах, удирдах, санхүүжүүлэх, зарах үйл ажиллагаа явуулах замаар хүрдэг.

Тус компаний үйл ажиллагаа нь ихээхэн онцлог учраас 1998 онд тусгай хууль баталсан. Энэхүү хууль нь Данахартагийн үйл ажиллагааг түргэн, шуурхай, үр ашигтай болгоход чиглэсэн байдаг. Данахарта түргэн шуурхай, үр ашигтай ажиллах тусам эдийн засгийн идэвхжил сайжирна гэж үзсэн.

Данахартагын хуулийн гол зорилго нь актив болоод пассивыг авах, удирдах болоод зарах боломжоор хангаж өгсөнд байдаг. Цаашилбал, Данахарта нь тодорхой хууль журмын хүрээнд Засгийн газрын баталгаатай зээл авч болох учраас үйл ажиллагаа нь нилээд өргөжих боломжоор хангагдсан. Энэхүү хуулийн дагуу Данахартагын Захирлуудын зөвлөлд Сангийн яамнаас санал болгосон 9 захирал томилдог ба тэдгээрийн ихэнх нь хувийн хэвшлээс сонгогдсон байдаг. Хувь эзэмшигчийнхээ хувьд Засгийн газар хоёр төлөөлөгчөө энэхүү зөвлөлд оруулдаг. Данахартаг гүйцэтгэх захирал удирддаг бөгөөд энэхүү захирал нь саналын эрхгүй Захирлуудын зөвлөлийн гишүүн албыг давхар хашдаг.

Түүнчлэн, энэхүү хууль нь Данахартагын хараат бус байдлыг баталгаажуулж өгдөг. Тухайлбал, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ харуулах, нууцыг чандлан хадгалах зэргийг шаарддаг.

Данахартагын тусгай эрх, үйл ажиллагаа нь тус компанийн дүрмээр зохицуулагддаг.

*Данахартагийн тусгай эрх*

Данахартагийн хуулиар тус компанид хоёр тусгай эрх олгосон. Нэгдүгээрт, ***эрх шилжүүлэх (vesting)*** замаар актив худалдан авах. Данахарта нь худалдан авалт хийхдээ тухайн активыг захиран зарцуулах эрхийг давхар авах боломжоор хангагдаж өгч байгаа. Хоёрдугаарт, хүндрэлд орсон компаниудын үйл ажиллагааг чиглүүлэх зорилгоор **тусгай төлөөлөгч томилох** эрхтэй.

*Эрх шилжүүлэх (vesting)*

Данахарта худалдан авалт хийхээсээ өмнө худалдан авалт хийх нөхцөлөө худалдагч талтай тохирох ёстой. Жишээ нь: Хэрэв Данахарта чанаргүй зээл худалдан авах хүсэлтэй бол худалдан авалтын нөхцөлийг зарж буй талтай тохирох ёстой. Эдгээр нөхцөл биелэгдсэн тохиолдолд л худалдан авалтыг хийдэг.

Данахартагын хуулийн дагуу Данахарта нь худалдан авалтыг эрх шилжүүлэх замаар хийдэг. Худалдан авалт хийсний дараа Данхарта эрх шилжүүлж авсан сертификат гаргадаг бөгөөд энэхүү сертификатыг хөрөнгийн бүртгэл хийлгэхдээ ашигладаг. Эрх шилжүүлж авсан бүртгэлийг хийлгэснээр Данахарта тухайн активыг удирдах эрхтэй болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, активаа худалдаж буй банк эрхээ шилжүүлж байгаа (vesting)

Данахартад тухайн активыг бүрэн удирдах эрхийг шилжүүлж өгч байгаа гэсэн үг. Иймхүү, Данахарта нь тухайн активын хувьд банкны эдэлж байсан эрхийг эдэлнэ.

Данахарта чанаргүй зээлийг худалдан авахдаа тухайн активын бусад хувь эзэмшигчидийг ил тод бүртгэн авч эдгээр талуудыг хоёрдогч эзэмшигчээр хэвээр үлдээдэг. Тухайлбал, тухайн активын эзэмшил дээр хоёрдогч банк байх тохиолдолд тухайн банк хамтран эзэмшигч хэвээр үлдэх болно. Данахарта нь худалдан авсан активаа удирдах, зарах эрхтэй хэдий ч тус активыг хамтран эзэмшигчдийн ашиг сонирхлыг нэг тийш нь шийдэх ёстой болно. Өөрөөр хэлбэл, тухайн активаа зарахын өмнө бусад оролцогч талуудтай тодорхой шийдэлд хүрсэн байх ёстой. Ийм замаар тус хууль нь хамтран хувь эзэмшигч этгээдийн эрхийг хангаж өгч байгаа юм.

Данахартагын хууль нь тус байгуулагыг үр ашигтай ажиллах боломжоор хангаж өгдөг. Тус хууль нь Данахартаг аливаа нэг активын эрхийг авах, дамжуулах боломжоор хангаж өгдөг ба ингэхдээ бусад оролцогч талуудын эрх ашгийг хөнддөгүйгээрээ онцлог юм.

*Данахартагын засаглал*

Данахартагын захирлуудын зөвлөлийн гишүүдийг Сангийн Яам томилдог ба дараах бүтэцтэй:

- Гүйцэтгэх бус захирал
- Саналын эрхгүй гүйцэтгэх захирал
- Засгийн газрын хоёр төлөөлөл
- Хувийн секторын гурван төлөөлөл
- Олон улсын байгууллагын хоёр төлөөлөл

Данахарта байгуулагдахаас өмнөх үеийн эрх зүйн зохицуулалтанд активыг шилжүүлж авах, өгөх үйл ажиллагаанд тухайн үеийн эрх зүйн орчинтой болоод гэрээтэй холбоотой саад тотгор нилээдгүй байсан. Эдгээр саад тотгорыг арилгаагүй цагт санхүүгийн байгууллага чанаргүй зээлээсээ ангижрах боломж багатай байжээ. Данахартагын тусгай хууль нь эдгээр саадыг арилгахад чиглэдэг ба ингэхдээ гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хадгалах замаар зохицуулж өгсөн. Энэхүү хуулийн дагуу эрх шилжүүлэх сертификат гарсан өдрөөс хойш тухайн активыг эзэмших эрх Данахартад шилждэг бөгөөд тухайн активыг хамтран эзэмшигчдийн эрхийг хангадаг болно. Тухайлбал, Данахарта нь тухайн активыг өр төлбөрийнх нь хамт авдаг ба активыг зарах эрхийг тэргүүн ээлжинд эзэмшдэг. Эрх шилжүүлж авч байгаа нь Данахартаг бусад хувь эзэмшигчдийн эрх ашгаас хамгаалж өгдөг гэсэн үг юм.

Данахартагаас актив худалдан авсан тал Данахартагийн эзэмшиж байсан эрхийг бас эзэмшинэ гэдгийг Данахартагийн тухай хуулиар баталгаажуулж өгсөн байдаг.

## ЗУРГАА.ЗӨВЛӨМЖ

Дээр дурдсан туршлагаас гадна АНУ, Щведын вант улс, Турк, Ирланд, Нигери, Испани, Мексик, Филлипин зэрэг олон улс орон активын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж байсан байна. Эдгээр улс оронд нэвтрүүлсэн активын удирдлагын тогтолцоо нь харилцан адилгүй үр дүнд хүрчээ. Өөрөөр хэлбэл зарим улс оронд актив удирдлагын тогтолцоо нь чанаргүй зээлийн асуудлыг амжилттай шийдвэрлэж, банкны салбарын тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн өсөлт хөгжилд эерэг нөлөө үзүүлж

байсан бол зарим улс оронд хямралыг улам гүнзгийрүүлсэн сөрөг туршлага байгааг анхаарах нь зүйтэй. Эдгээр улс орны туршлагыг харьцуулан үзэхэд дараах нийтлэг дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Үүнд:

- Бүх шатандаа нэгдсэн ойлголттой болж, улс төрийн болон төрийн эрх бүхий байгууллагуудын зүгээс зохих туслалцаа, дэмжлэгийг авсан нөхцөлд активын удирдлагын тогтолцоо нь амжилттай хэрэгждэг байна,
- Банкнаас шилжүүлэн авч буй чанаргүй зээлийн үнэлгээг бодитойгоор тогтоох нь активын удирдлагын тогтолцооны хамгийн хүндрэлтэй асуудлуудыг нэг байдаг байна. Үнэлгээний аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэх, үнэлгээг хараат бус байдлаар хийх зэрэг асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байдаг.
- Активын удирдлагын компанид чанаргүй активыг худалдан авч барагдуулах үүргээс гадна банк болон аж ахуйн нэгж, байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх эрхийг олгосон тохиолдол хэд хэд байна. Гэсэн хэдий ч Актив удирдлагын компанид олон тооны эрх үүрэг нэгэн зэрэг олгох нь тус компанийн бүтцийг нь хэт нүсэр болгож, үйл ажиллагаа явуулах нөхцөл байдлыг туйлын хүндрэлтэй болгох магадлалтай байдаг. Иймд Актив удирдлагын компанийн үйл ажиллагааг дан ганц чанаргүй активыг төлүүлэх асуудал дээр төвлөрүүлэх нь илүү оновчтой хувилбар болохыг олон улсын туршлага харуулж байна.
- Үүнээс гадна Актив удирдлагын компанийг улс төр, бизнесийн нөлөөллөөс хараат бус удирдлагаар хангах, үйл ажиллагааг аж ахуйн тооцоон дээр нээлттэй ил тод байдлаар явуулах нь активын удирдлагын тогтолцооноос эерэг үр дүн гарахад чухал нөлөө үзүүлдэг байна. Түүнчлэн Актив удирдлагын компанийн үйл ажиллагааг дуусгавар болгох хугацааг нарийвчлан тогтоох нь (the sunset clause) хүрсэн үр дүнг бодитойгоор үнэлэхэд ач холбогдолтой байдаг байна.
- Актив удирдлагын компанийг санхүүжүүлэх 3 хэлбэр байдаг: төр дангаараа, хувийн хэвшил дангаараа, холимог хэлбэрийн санхүүжилт. Актив удирдлагын тогтолцоог гол төлөв эдийн засаг хүндрэлтэй, банк санхүүгийн байгууллагын төлбөрийн чадвар буурсан үед нэвтрүүлдэг тул төрийн оролцоотой байх хандлагатай байдаг. Эдийн засаг хүндрэлтэй байгаа үед төсвийн алдагдал харьцангуй өндөр байх магадлалтай тул төрөөс олгох санхүүжилт нь гол төлөв бонд болон баталгаа хэлбэртэй байдаг.
- Актив удирдлагын компанийн эрх үүргийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд тус компанид тусгай эрх (тухайлбал хөрөнгийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах эрх) олгох асуудал нэн чухал байдаг. Тусгай эрхийг хууль бусаар ашиглах эрсдэлийг бууруулах үүднээс урьдчилсан болон дараалсан хяналтыг тогтолцоог бүрдүүлсэн байх шаардлагатай.

Активын удирдлагын тогтолцооны үр ашигтай байдлаар зохион байгуулахын тулд хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага зайлшгүй үүснэ. Үүнд активын удирдлагын талаар тусгайлсан хууль батлан гаргахаас гадна банкны хяналт шалгалт, хадгаламжийн даатгал, аж ахуйн нэгжийн бүтцийн өөрчлөлт дампуурал, хөрөнгийн бүртгэл үнэлгээ, үүргийн гүйцэтгэл зэрэг асуудлыг зохицуулсан хууль эрхийн актыг боловсронгуй болгох нь зүйтэй.

Бусад орнуудад хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн Азийн хөгжлийн банк Актив удирдлагын үйл ажиллагаанд тусгай эрх зүйн орчин шаардлагатай гэж зөвлөдөг.

Актив удирдлагын компани үр ашигтай ажиллахын тулд тодорхой шаардлагуудыг хангасан байх шаардлагатай:

- тодорхой зорилго,
- оновчтой засаглалын бүтэц,

- хараат бус болон ил тод байдал,
- хангалттай хэмжээний санхүүжилт,
- тусгай эрх зүйн орчин, хяналт шалгалтын орчин бүрдүүлэх г.м.

Тусгай эрх зүйн зохицуулалт нь дээр дурдсан шаардлагыг хангахад болон Актив удирдлагын компани үйл ажиллагаа явуулах суурь нь болно.

Тусгай эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжид дараахь зохицуулалтыг тусгаж өгөх нь зүйтэй юм.

- Актив хөрөнгийг үнэлэх эрхтэй байх (актив хөрөнгийг хямдруулан худалдан авах),
- Онцгой нөхцөлд шүүхийн бус журмаар хөрөнгө худалдан борлуулах эрхтэй байх,
- Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх зүйн орчинг хурдан шуурхай болгох,
-Албан татвараас чөлөөлөх эрх зүйн зохицуулалт бий болгох /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн алба татварын хууль, Нэмэгдсэн өртөгийн албан татварын хууль, УТХТХууль/
- Хөрөнгийн үнэлгээ хийх эрхийг олгох. (Хөрөнгийн үнэлгээний тухай хууль).

____________oOo____________

# АКТИВ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

2019 он

# АКТИВЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ
# ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Актив удирдлагын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид "аргачлал" гэх/-ын дагуу тооцлоо.

Уг аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог болно.

Актив удирдлагын тухай хуулийн төслийн тухайд төрийн байгууллага болон төрөөс бусад хөрөнгө оруулагч (хуулийн этгээд)-д зардал үүсгэхээр зохицуулсан тул эдгээр субъектэд үүсэх зардлыг тооцоолон гаргав.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажиллалаа.

- Төрийн байгууллага, төрөөс бусад хөрөнгө оруулагчийн гүйцэтгэх үүргийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Энэхүү тооцоонд тусгагдсан зардал нь актив удирдлагын компанийг үүсгэн байгуулах, чанаргүй активыг шийдвэрлэхтэй холбогдон гарах зардал болно.

**Актив удирдлагын компанийг үүсгэн байгуулах, чанаргүй активыг шийдвэрлэхтэй холбогдон төрийн байгуулагад үүсэн бий болох зардал**

Актив удирдлагын компанийг үүсгэн байгуулах, чанаргүй активыг шийдвэрлэхтэй холбогдон төрийн байгууллага /улсын төсөв/-д үүсэх зардлыг тухайн үйл ажиллагааг явуулахад шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараахь үе шаттайгаар гаргалаа. Үүнд:

1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу үйл ажиллагааг тодорхойлох;
2. Үйл ажиллагааг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийг хэрэгцээг тогтоох;
3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Бусад зардал, материаллаг зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягтлах.

**Нэгдүгээр үе шатны хүрээнд:** Актив удирдлагын тухай хуулийн төсөлд Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 20 хувийг төрөөс бүрдүүлэхээр заасан бөгөөд тус хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллага /санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага/-ын гүйцэтгэх үүрэг буюу үйл ажиллагааг энд түүвэрлэн тодорхойлов.

Хуулийн төсөлд тусгагдсаны дагуу төрийн байгууллага /санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага/ нь Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 20 хувийг бүрдүүлэхээс гадна тус компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр байна. Үүнд:

1. Актив удирдлагын компани байгуулах зөвшөөрөл олгох шийдвэр гаргах,
2. Актив удирдлагын үйл ажиллагаанд холбогдох журам батлах.

**Хоёрдугаар үе шатны хүрээнд:** Үүрэг буюу үйл ажиллагааг гүйцэтгэх хүний нөөцийг дараах байдлаар тодорхойллоо.

1. Үйл ажиллагаа бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд задлан түүнд зарцуулах хугацааг тодорхойлов.
2. Тохиолдлын тоо буюу уг арга хэмжээг нэг жилд хэдэн удаа хийгддэг талаарх тоог гаргахдаа тухайн байгууллагын хувьд жилд нэг удаа хийгдэнэ гэж үзсэн.
3. Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг гаргалаа.

Хуулийн төсөлд тусгагдсан Актив удирдлагын компани байгуулж, чанаргүй активыг шийдвэрлэх харилцаа нь салбарын хэмжээнд шинээр бий болж байгаа харилцаа тул үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг тооцохдоо өмнө шинээр төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах шийдвэр гаргасан болон тэдгээрт холбогдох журам баталсан туршлагыг судалж, эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлсэн хугацаан дээр үндэслэн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцлоо.

Ийнхүү гаргасан нийт шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой буюу нэг өдөрт 8 цаг ажиллах цагтай харьцуулж уг ажлыг гүйцэтгэх шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсон болно.

| Төрийн байгууллага | Хэрэгжүүлэх чиг үүрэг | Хийгдэх ажиллагаа | Зарцуулах хугацаа |
|---|---|---|---|
| Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | Актив удирдлагын тухай хуулийн төслийн 4.3 дахь хэсэг | Актив удирдлагын компани байгуулах зөвшөөрөл олгох шийдвэрийн төсөл бэлтгэх | 1440 минут |
| | | Шийдвэрийн төслийг танилцуулах | 480 минут |
| | | Шийдвэрийн төслийг хянуулах | 240 минут |

| | | | |
|---|---|---|---|
| | | Шийдвэр гаргах | 60 минут |
| Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | Актив удирдлагын тухай хуулийн төслийн 30.2 дахь хэсэг | Актив удирдлагын үйл ажиллагаанд холбогдох журмын төсөл боловсруулах | 1440 минут |
| | | Журмын төсөлд санал авах | 480 минут |
| | | Журмын төслийг батлах | 960 минут |
| Нийт хугацаа 5100 минут | | | |

Одоогоор Актив удирдлагын компани байгуулах зөвшөөрөл олгох шийдвэр гаргах, тус компанийн үйл ажиллагаанд холбогдох журам батлахтай холбоотойгоор 5100 цагийн ачаалал үүсч байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ"-ний дундаж буюу ТЗ-7-ийн 3 дугаар шатлалд харгалзах цалингийн хэмжээ буюу 663,720 төгрөгөөр тооцож үзвэл тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 0.5 хүн шаардлагатай гэсэн тооцоолол гаргалаа. Тус үүргийг хариуцах төрийн байгууллага буюу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага одоо байгаа бүтцээр дээр дурдсан үүргийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

**Гуравдугаар үе шатны хүрээнд:** Зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн зардлын бүрэлдэхүүн хэсэгт хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тодорхойлно.

Дээр дурдсанчлан тус ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийг одоо ажиллаж байгаа нөөцөөр гүйцэтгэх боломжтой гэж үзсэн бөгөөд энэ тооцооллын дагуу орон тоо нэмэгдэх тохиолдолд 0.5 хүний дундаж цалин хөлсийг 663,720 төгрөгөөр тооцвол, жилд 3.98 сая төгрөгийн цалингийн зардал гарна. Бусад нэмэгдэл, урамшуулал хууль тогтоомжийн дагуу зохицуулагдах тул уг ажлыг төрийн байгууллага хариуцан гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг гаргаснаар тооцоолол дууслаа.

**Дөрөвдүгээр үе шатны хүрээнд:** Энд нийт дүнг тооцоолох бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргана.

Хуулийн төслийн 23.2 дахь хэсэгт "Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 20 хувийг төрөөс бүрдүүлнэ" гэж заасан. Иймд Актив удирдлагын компани байгуулах, активыг шийдвэрлэхтэй холбоотой зардлын 20 хувийг төрөөс, 80 хувийг хувийн хөрөнгө оруулалтаар бүрдүүлнэ.

Энд Актив удирдлагын компанийг байгуулж, чанаргүй активыг шийдвэрлэхэд шаардагдах нийт зардлыг тооцлоо.

***АУК байгуулах, чанаргүй зээлийг шийдвэрлэх зардал***

Актив удирдлагын компани үр дүнтэй үйл ажиллагаа явуулахын тулд банкны салбараас чанаргүй активыг шилжүүлэн авах хангалттай хөрөнгөтэй байх шаардлагатай. Иймд Актив удирдлагын компанийг үүсгэн байгуулж, чанаргүй активыг худалдан авахад шаардагдах эх үүсвэрийн хэмжээг дараах нөхцөл, хувилбараар гүйцэтгэлээ.

- Чанаргүй зээлийн хэмжээ 2018 оны 4 дүгээр сарын байдлаар 1.06 тэрбум төгрөг байгаагаас 50-иас 90 хувийг худалдаж авах *(5 хувилбар)*,

- Зээл худалдаж авахдаа дунджаар 50-иас 70 хувиар хямдруулах *(3 хувилбар)*,

Дээрх хувилбаруудад харгалзах зардлыг тооцож дараах хүснэгтэд тусгалаа.

Тэрбум төгрөг

| Чанаргүй зээл=1,060 тэрбум.төг<br>NPL ratio=7.4% | | Худалдан авах зээлийн хувь | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 50% | 60% | 70% | 80% | 90% |
| Худалдагдах зээл | | 530 | 636 | 742 | 848 | 954 |
| NPL ratio after sale | | 3.7% | 3.0% | 2.2% | 1.5% | 0.7% |
| Гарах зардал (тэр.төг) | | | | | | |
| Дундаж | *50%* | 265 | 318 | 371 | 424 | 477 |
| хямдруулалтын | *60%* | 212 | 254 | 297 | 339 | 382 |
| хувь | *70%* | 159 | 191 | 223 | 254 | 286 |

Дээрх хүснэгтээс харахад чанаргүй зээлийн 50 хувийг дунджаар 70 хувиар хямдруулахад хамгийн бага буюу 159 тэрбум төгрөгийн, чанаргүй зээлийн 90 хувийг 50 хувиар хямдруулахад хамгийн их буюу 477 тэрбум төгрөгийн зардал тус тус гарахаар байна. Актив удирдлагын компани нь банкны системийн бүх чанаргүй зээлийг худалдан авч шийдвэрлэх боломжгүй. Тухайлбал, зээлдэгч нь алга болсон, барьцаа хөрөнгөгүй, бичиг баримтын зөрчилтэй, олон жилийн өмнө муу ангилалд шилжсэн зэрэг төлөгдөх найдваргүй зээлүүдийг банкуудад үлдээх нь зүйтэй. Мөн одоогоор чанаргүй ангилалд байгаа боловч цаашид төлөгдөх магадлал өндөр зээлүүдийг Актив удирдлагын компани худалдан авахгүй байх нь оновчтой гэж үзэж байна. Харин чанаргүй зээлийн 50 орчим хувийг худалдан авахад системд үлдэх чанаргүй зээл нийт зээлийн 4 хувийг эзлэж байгаа тул энэ арга хэмжээ үр дүн багатай гэж үзэж байна. Иймд банкны системийн чанаргүй зээлийн 60-80 хувийг дунджаар 50-70 хувиар хямдруулан худалдан авахад ойролцоогоор 200-350 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардлагатай байна. Энэхүү зардлыг дараах хувилбараар санхүүжүүлэхээр тооцсон болно.

- Нийт зардлын 20 хувийг Төрөөс,
- Үлдэх 80 хувийг хувийн хөрөнгө оруулалтаар;

Дээрх нөхцөл, хувилбарын дагуу Актив удирдлагын компани байгуулж, чанаргүй зээлийг худалдан авахад шаардагдах санхүүжилтийг тооцоог дараах хүснэгтэд харуулав.

| | Нийт зардал *(Тэр.төг)* | | | |
|---|---|---|---|---|
| | 200 | 250 | 300 | 350 |
| Төрөөс (20%) | 40 | 50 | 60 | 70 |
| Хувийн хөрөнгө оруулалтаас (80%) | 160 | 200 | 240 | 280 |

Дээрх тооцооллын дагуу Актив удирдлагын компанийг байгуулж, банкны системийн чанаргүй зээлийн 60-80 хувийг дунджаар 50-70 хувиар хямдруулан худалдан авахад төрөөс 40-70 тэрбум төгрөгийн зардал гарахаар байна. Актив удирдлагын компаний үйл ажиллагаатай холбоотой хүний нөөцийн зардлыг дээр дурдсан бөгөөд тус чиг үүргийг төрийн байгууллага одоогийн бүтцээр гүйцэтгэх боломжтой гэж үзсэн тул төрд Актив удирдлагын компани байгуулах, чанаргүй зээлийг зээлийг шийдвэрлэхтэй холбоотой зардал үүснэ гэж үзлээ.

**Тавдугаар үе шатны хүрээнд:** Хувилбарыг нягтлан хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэнэ. Төрийн байгууллагын зардлыг багасгах боломж бий эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг тогтоохыг зорилоо.

Хуулийн төсөлд төрд үүсгэхээр заасан зардал нь үүсч байгаа асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой, үр өгөөжтэй эсэхийг чанаргүй зээлийн өсөлт, түүний нөлөөг Актив удирдлагын компанийг байгуулах, чанаргүй зээлийг шийдвэрлэхэд төрөөс гарах зардалтай харьцуулах байдлаар энд дүгнэлээ.

***Чанаргүй зээлийн өсөлт, түүний нөлөө***

Манай орны банкны системд хуримтлагдсан чанаргүй зээлийн үлдэгдэл 2018 оны 4 дүгээр сард системийн нийт зээлийн 7.4 хувь буюу 1.06 их наяд төгрөгт хүрлээ. Зээлдэгчийн төлбөрийн чадвараас шалтгаалан хугацаа сунгасан болон өнөөдөр хугацаа хэтэрч буй зээлээс шалтгаалан чанаргүй зээл цаашид буурах төлөвгүй байна.

Чанаргүй зээл нэмэгдэж, эрсдэл даах чадвар сулрахад банк зээл олголтоо хумьж, эрсдэл өндөртэй салбарт нэмэлт санхүүжилт олгохоос зайлсхийдэг. Манай орны банкны салбарт энэ хандлага мөн ажиглагдаж байгаа бөгөөд 2010 оны эцэст зээл банкны активын 66 хувийг бүрдүүлж байсан бол өнгөрсөн оны эцэст 46 хувьд хүрч 20 нэгжээр буурлаа. Хэрэв зөвхөн эрсдэл даах чадварын хүндрэлд орох 4 банк зээлийн эрсдэлээ бууруулах арга хэмжээ авахад цаашид эдийн засаг дахь зээлийн хэмжээ 3.6 их наяд төгрөгөөр буурах буюу одоогийн түвшнөөс 30 орчим хувиар агшихаар байна.

2016 онд эдийн засгийн голлох салбарууд болох уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл, худалдааны салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувь 6 нэгжээр буурч 40 хувьд хүрсэн бол эсрэгээрээ хэрэглээ, үндсэн хөрөнгө санхүүжүүлэх зорилготой иргэдийн зээлийн хувь 4 нэгжээр нэмэгдэн 46 хувьд хүрлээ. Ирээдүйд баялаг бүтээх, хөрөнгө оруулалтын зориулалтай бодит секторын зээл хумигдаж буй үндсэн шалтгаан нь аж ахуйн нэгжид олгосон зээлийн эрсдэл нь иргэдийн зээлийн эрсдэлээс харьцангуй өндөр байгаатай холбоотой. Тодруулбал, 2017 оны эцэст аж ахуйн нэгжийн зээлийн 11.4 хувь, иргэдийн зээлийн 3.1 хувь нь тус тус чанаргүй ангилалд байна.

Чанаргүй зээл өсч, бодит секторын зээл буурахад эдийн засгийн голлох үзүүлэлтүүд огцом буурдаг болох нь олон улсын туршлагаар батлагдсан. Жишээлбэл, Төв болон Зүүн

Европын орнуудын *(Central, Eastern, South-Eastern)* 1998-2011 оны[1] нөхцөлд байдалд хийсэн судалгаа, Нефть олборлогч орнуудын *(Gulf Cooperation Council)* 1995-2008 оны[2] эдийн засгийн хөгжилд хийсэн дүгнэлт, хөгжиж буй орнуудын *(Emerging market)* 1966-2010 онуудын туршлага[3] зэргээс харахад чанаргүй зээлийн өсөлт нь санхүүгийн зуучлалыг зогсонги байдал оруулж, эдийн засгийн идэвхижилтийг сулруулан, бодит секторын өсөлтийг хязгаарлаж, ажилгүйдлийг нэмэгдүүлэх нөлөөтэйг тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, чанаргүй зээлийн өсөлт нь зах зээлийн бүтэц, онцлог, газар зүйн байршлаас үл хамааран улс орны эдийн засгийн хөгжлийг сулруулах нөлөөтэй болно.

Мөн Зүүн өмнөд азийн орнуудын туршлагаас[4] судалгаагаар санхүүгийн салбарын чанаргүй зээлийн харьцаа 1 нэгжээр нэмэгдэхэд Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 12 сарын дараа 0.2 нэгжээр буурч байгаа тогтоогджээ. Хэрэв чанаргүй зээлийн хувь 2018 оны эцэст өссөөр байх тохиолдолд Монгол Улсын эдийн засагт 2018 оны эцэст өсөлт ажиглагдахгүй байж болзошгүй байна. Мөн, Мексик Улсын 2000-2010 онуудын дотоод нийт бүтээгдэхүүний өсөлтөөр илэрхийлэгдэх хөгжлийн 70 орчим хувийг зээл олголтоор тайлбарлаж болохоор байсан байна[5]. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн зах зээл сул хөгжсөн орнуудын эдийн засагт зээл олголт хамгийн чухал үзүүлэлт болж байна.

Товч дүгнэхэд чанаргүй зээл нэмэгдэх нь зээл олголтыг бууруулж хямралыг улам гүнзгийрүүлэх бөгөөд эргээд зээлийн чанарыг нэмж муутгах хандлагатай *(vicious cycle)* болно. Энэ нь төсөв, мөнгөний хатуу бодлого баримталж буй өнөөдрийн нөхцөлд эдийн засгийн сэргэлтийг удаашруулах, ажилгүйдлийг нэмэгдүүлэх, халамжийн зардлыг өсгөх нөлөөтэй. Мөн татварын орлогыг бууруулж, өрийн тэнцвэрт байдалд хүрэх зорилтыг хэрэгжүүлэхэд томоохон саад учруулна.

Мөн чанаргүй зээлийн өсөлт нэмэгдэх нь банкны төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх бөгөөд чанаргүй зээлийн өсөлт, эдийн засгийн сэргэлтийн удаашралтай холбоотойгоор банк дампуурах, татан буугдах тохиолдолд төрөөс харилцагч, хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгийг эргүүлэн олгоход зориулж их хэмжээний зардал гарч болзошгүй. Сүүлийн жишээ дурдахад Анод, Хадгаламж, Зоос банкны харилцах, хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хөрөнгийг эргүүлэн олгоход зориулж төрөөс /дийлэнх хэсэг нь Монголбанкнаас/ нийт 482 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байдаг. Өөрөөр хэлбэл 1 банк төлбөрийн чадваргүй болох тохиолдолд төрөөс дунджаар 160 орчим тэрбум төгрөгийн зардлыг тухайн үед гаргасан байна. Цаашид гарч болзошгүй эдгээр зардлыг хуулийн төсөлд заасан Актив удирдлагын компани байгуулж, чанаргүй зээлийг шийдвэрлэх замаар шийдвэрлэх нь төрд үүсч болох их хэмжээний алдагдал, зардал үүсэх эрсдлээс сэргийлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

---

[1] Nonperforming loans in CESEE: Determinants and Impact on Mactoeconomic performace, *Nir Klein*, 2013
[2] Nonperforming loans in the GCC Banking system and their macroeconomic effects, *Raphael Espinoza and Ananthakrishnan*, 2010
[3] Bank asset quality in Emerging markets: Determinants and Spillovers, *Reinout De Bock and Alexander Demyanets*, 2012
[4] PPT presentation, ADB-China Huarong jointly hosted the Financial Stability Seminar on Managing NPLs in Asia and Europe, Shanghai, PRC
[5] Spillovers and Long Run Difussion of Non-Performing Loans Risk, *Renata Herrerias and Jorge O. Moreno*, 2011

Иймд, санхүүгийн салбарт активын мэргэшсэн удирдлагын институцийг байгуулж, эрсдэлтэй зээлийг зохистой үнээр худалдаж авах замаар банкуудын чанаргүй зээлийг бууруулж, ирээдүйд учирч болох эрсдэлийг хязгаарлан, эдийн засгийн санхүүгийн зуучлал хэвийн үргэжлэх нөхцөлийг хадгалах шаардлагатай бөгөөд Актив удирдлагын тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад үүсч болох зардал нь хуулийн үр өгөөжтэй харьцуулахад үлэмж бага буюу хуулийн төсөл үр ашиг өндөр байна гэж үзлээ.

**2. Актив удирдлагын компанийг үүсгэн байгуулж, чанаргүй активыг шийдвэрлэхтэй холбогдуулан хуулийн этгээд /хөрөнгө оруулагч болон банк/-д үүсэх зардал**

Актив удирдлагын тухай хуулийн төсөлд Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг төр, бусад этгээдээс хувь нийлүүлсэн хөрөнгө, олон улсын санхүүгийн байгууллага зэрэг этгээдээс оруулсан хөрөнгөөр бүрдүүлэх бөгөөд тус компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 80 хувийг хувийн хөрөнгө оруулалтаар бүрдүүлэхээр заасан тул Актив удирдлагын компани байгуулж, чанаргүй активыг шийдвэрлэхтэй холбогдуулан хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцох ажлыг дараах үе шатаар хийлээ.

1. Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. Гүйцэтгэх үүрэг тус бүрийн зарцуулах хугацааг тодорхойлсны үндсэн дээр хуулийн этгээдэд үүсэх хүний нөөцийн хэрэгцээг тооцох;
3. Хүний нөөцтэй холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Нэмэлт зардлыг тооцох;
5. Хувилбарыг нягтлах.

**Нэгдүгээр үе шатны хүрээнд:** Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдийн хүлээх үүргийг энд тодорхойллоо. Хуулийн төслийн дагуу хуулийн этгээд /хөрөнгө оруулагч, банк/ дараахь үүргийг хүлээж байна.

1. Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлэх;
2. Актив удирдлагын компанид чанаргүй активыг шилжүүлэх.

**Хоёрдугаар үе шатны хүрээнд:** Гүйцэтгэх үүрэг тус бүрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааг тодорхойлсны үндсэн дээр нэг хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардлыг тооцов.

Энэхүү тайлангийн 1 дүгээр хэсэгт дурдсанчлан Актив удирдлагын компанийг байгуулж, чанаргүй активыг шийдвэрлэх арга хэмжээ нь салбарын хэмжээнд шинээр бий болж байгаа харилцаа тул банкнаас Актив удирдлагын компанид чанаргүй актив шилжүүлэх үйл ажиллагаанд холбогдуулан Банкны тухай хуулийн хүрээнд нэг банкнаас нөгөө банкинд актив шилжүүлж байсан туршлагыг судалж, тус үйл ажиллагааг жишиг болгон хугацааг баримжаалан тогтоолоо. Харин Актив удирдлагын компанийг байгуулах, чанаргүй активыг шийдвэрлэхтэй холбогдох зардлыг энэ хэсгийн 4 дүгээр үе шатанд тооцсон болно.

| Хуулийн этгээд | Хэрэгжүүлэх чиг үүрэг | Хийгдэх ажиллагаа | Зарцуулах хугацаа |
|---|---|---|---|
| Банк | Актив удирдлагын тухай хуулийн төслийн 8.1 дэх хэсэг | Монголбанкнаас тодорхойлсон нөхцөл, журмын дагуу чанаргүй активыг Актив удирдлагын компанид шилжүүлэх баримт бичгийн төсөл бэлтгэх, шилжүүлэх бэлтгэлийг хангах | 28800 минут |
| | | Баримт бичгийг батлах, активыг шилжүүлэх | 6720 минут |
| Нийт хугацаа 35520 минут | | | |

Хуулийн төсөлд заасан үүргийг гүйцэтгэхийн тулд хуулийн этгээд /банк/-ийн зүгээс 35520 минут зарцуулахаар байгаа бөгөөд банкны ажилтны сарын дундаж цалинг 1 сая төгрөгөөр тооцвол уг ажлыг хийж гүйцэтгэхэд 3.5 хүн шаардлагатай гэсэн тооцооллыг гаргалаа. Тус үүргийг хариуцах хуулийн этгээд буюу банк тус чиг үүргийг шинээр ажилтан авч ажиллуулах буюу одоо байгаа хүний нөөцийг ашиглан гүйцэтгэх эсэхийг шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

**Гуравдугаар үе шатны хүрээнд:** Зардлын тооцоог хүний нөөцийн, бусад гэсэн зардлын бүрэлдэхүүн хэсэгт хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тодорхойлов.

Дээр дурдсанчлан тус ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийг одоо ажиллаж байгаа нөөцөөр гүйцэтгэх эсэхийг хуулийн этгээд буюу банк шийдвэрлэх боломжтой бөгөөд энэ тооцооллын дагуу орон тоо нэмэгдэх тохиолдолд 3.5 хүний дундаж цалин хөлсийг 1,000,000 төгрөгөөр тооцвол, жилд 42 сая төгрөгийн цалингийн зардал гарна. Бусад нэмэгдэл, урамшуулал холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулагдах тул уг ажлыг хуулийн этгээд буюу банкнаас гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг гаргаснаар тооцооллыг мөн дуусгавар болгосон болно.

**Дөрөвдүгээр үе шатны хүрээнд:** Энд нийт дүнг тооцоолох бөгөөд хүний нөөцийн зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргалаа.

Энэхүү тайлангийн 1 дүгээр хэсэг буюу төрийн байгууллагад үүсэх зардлын 4 дүгээр үе шатны хүрээнд Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 80 хувийг хувийн хөрөнгө оруулалтаар бүрдүүлж, банкны системийн чанаргүй активын 60-80 хувийг дунджаар 50-70 хувиар хямдруулан шилжүүлж авахад хуулийн этгээд /хөрөнгө оруулагч/-д 160-280 тэрбум төгрөгийн зардал үүснэ гэж тооцсон болно. Харин Актив удирдлагын компани банкнаас чанаргүй активыг хэдэн хувиар хямдруулан авсанаас шалтгаалан банкинд зардал үүсэх бөгөөд банкинд үүсэх зардлын хэмжээ нь Актив удирдлагын компанид шилжүүлэх зээлийн үлдэгдэл, активыг шилжүүлэх үнийн зөрүүгээр

тодорхойлогдоно. 200-350 тэрбум төгрөгөөр банкны салбарын нийт чанаргүй зээлийн 60-80 хувийг 50-70% хямдруулалттай худалдан авахад банкинд 320-600 тэрбум төгрөгийн зардал гарахаар байна.

**Тавдугаар үе шатны хүрээнд:** Хувилбарыг нягтлан хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэлээ. Өөрөөр хэлбэл хуулийн этгээдийн зардлыг багасгах боломж бий эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг тогтоов.

Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдээс гарах зардал нь Актив удирдлагын компанийг байгуулж, банкны салбарын 1.06 их наяд төгрөгийн чанаргүй зээлийн 60-80 хувийг шийдвэрлэж, чанаргүй зээлийн өсөлтөөс үүдэх эдийн засгийн сэргэлт удаашрах, ажилгүйдэл нэмэгдэх, халамжийн зардал өсөх, банкны төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх, татварын орлогыг бууруулах, өрийн тэнцвэрт байдалд хүрэх зорилтыг хэрэгжүүлэхэд саад учрах эрсдэлийг бууруулах, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой харьцуулахад бага, хуулийн төслийг баталж хэрэгжүүлэх нь нийт эдийн засагт ач холбогдолтой, үр өгөөж өндөр байна гэж үзлээ.

__________oOo__________

# АКТИВ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

2019 он

## АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ ........ 3

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ ........ 3

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ ........ 5

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ ........ 9

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ ........ 21

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Актив удирдлагын тухай хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох, арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад тус үнэлгээний ажлын зорилго оршино.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуулийн төслийн анхны хувилбар байдлаар боловсруулагдсан болно

Актив удирдлагын тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал”[1]-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ үндсэн 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалт нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод нийцсэн эсэх, зорилгод хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэх, хуулийн төсөл нь ойлгомжтой, зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг дүгнэж, тэдгээрийн үр дүнд үндэслэн анхаарах асуудлын талаар хууль санаачлагчид зөвлөмж өгсөн.

Тус үнэлгээгээр Актив удирдлагын тухай хуулийн төсөл батлагдснаар банкны салбарт хуримтлагдсан чанаргүй активыг бууруулах, банк, санхүүгийн салбар, цаашлаад эдийн засгийг хямралаас сэргийлэх, тогтвортой байдлыг хангах үр нөлөөтэй эрх зүйн орчин бүрдүүлж чадах эсэхэд хариулт өглөө.

## ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

[1]Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

5. Харилцан уялдаа зэрэг болно.

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслийн үндсэн зорилго нь банкны салбарт хуримтлагдсан чанаргүй активыг бууруулах, банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, тус чиг үүргийг хэрэгжүүлэх Монгол Улсын Актив Удирдлагын Компанийн эрх зүйн байдлыг хуульчилах хэрэгцээ шаардлагыг бүрэн илэрхийлсэн эсэхийг дүгнэн, хуулийн төслийн зорилго тус зохицуулалтыг бий болгоход чиглэж буйг анхаарч. хуулийн төслийн зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байна уу гэдгийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

**“Практикт хэрэгжих боломж”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэх, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг 2015 оноос эхлэн Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгагдсан санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институтийг хөгжүүлж, эрх зүйн орчинг сайжруулах арга хэмжээний хүрээнд Монголбанк, холбогдох байгууллага, банкуудтай хамтран хийсэн ажил, түүний үр дүн, судалгаатай танилцан судлах, тэдгээрт дүн шинжилгээ хийх замаар тогтоох үүднээс сонгож авсан болно.

“Ойлгомжтой байдал”, “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл тул хуулийн төслийг бүхэлд нь шалгахаар тооцлоо.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь ойлгомжтой, логик дараалалтай томьёологдсон эсэх, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах үүднээс холбогдох этгээдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

**“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр үүрэг хүлээлгэсэн, шинэ бүтэц, чиг үүрэг нэмсэн зохицуулалтад шууд хамаарах этгээд хуулийн төслийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгахын тулд сонгосон болно.

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Олон улсын гэрээ, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг “Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан асуултад хариулах байдлаар үр нөлөөний үнэлгээг хийхээр сонгов.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

# ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

**"Зорилгод хүрэх байдал"**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод хуулийн төслийн зохицуулалт нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримталтай танилцаж, хуулийн төслийн зорилго нь хуулийн төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхийг шалгах, хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалтыг хуулийн төслийн зорилготой харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

Манай улсын эдийн засгийн таагүй байдал зээлдэгчийн чадвар, барьцаа хөрөнгийн үнэлгээнд нөлөөлөхийн зэрэгцээ чанаргүй зээл, актив нэмэгдэх нөхцөл болж байна.

Хэдийгээр чанаргүй актив болон зээл нь эдийн засаг тогтвортой, хэвийн үед ч тодорхой хэмжээгээр оршиж байдаг боловч энэ нь санхүүгийн салбарт эрсдэл хуримтлуулах, тогтвортой байдлыг алдагдуулах хэмжээнд хүрдэггүй. Харин эдийн засгийн хямралын үед чанаргүй зээл, активын хэмжээ нэмэгдэж, банк, санхүүгийн салбар, цаашлаад нийт эдийн засагт эрсдэл хуримтлуулж, тэдгээрийн тогтвортой байдлыг алдагдуулах сөрөг үр дагавартай болдог.

Эдийн засаг, банкны үйл ажиллагаа хэвийн, тогтвортой нөхцөлд банк өөрийн нөөц боломжийн хүрээнд чанаргүй зээл, активыг боломжит түвшинд, боломжит түргэн хугацаанд барагдуулах чадвартай байдаг бол эдийн засгийн байдал таагүй, хямралтай, гадаад хүчин зүйлийн эдийн засагт үзүүлэх нөлөөлөл их энэ цаг үед банкны салбарт хуримтлагдсан чанаргүй зээл, активыг барагдуулах нөөц, боломж буурдаг байна.

Чанаргүй зээл, актив банкинд дараах байдлаар нөлөөлдөг байна.

1. Банкны зээл олгох чадварыг багасгадаг.

2. Банкны ашиг, орлогыг бууруулдаг.

3. Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт сөргөөр нөлөөлдөг.

4. Банкны нөөц бололцоог бууруулдаг.

Чанаргүй зээл, актив банкинд дээрх байдлаар нөлөөлснөөр эдийн засагт дараах байдлаар сөрөг нөлөө үзүүлдэг байна.

1. Хөрөнгө оруулалтыг багасгадаг.

2. Эдийн засгийн хямралаас гарах боломж, нөхцөлийг удаашруулдаг.

3. Экспортыг багасгадаг.

4. Банкийг хямралд оруулж болзошгүй.

5. Санхүүгийн бусад салбарт нөлөөлж, санхүүгийн зах зээлийн өсөлтийг бууруулдаг.

Монгол Улсын санхүүгийн салбарт банкны салбар дийлэнх хувийг эзлэх бөгөөд нийт эдийн засагт түүний үзүүлэх нөлөөлөл хүчтэй. Иймд банк, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдах, тогтвортой байдалд нөлөөлөх боломжтой чанаргүй зээл, актив, түүнийг шийдвэрлэх асуудал нь Монгол Улсын хэмжээнд ач холбогдолтой байна.

Монгол Улсын банкны салбарт хуримтлагдсан чанаргүй зээл, активын хэмжээ хэвийн хэмжээнээс хэд дахин давсан үзүүлэлттэй байна.

Тухайлбал:

Банкны системд хуримтлагдсан чанаргүй зээлийн үлдэгдэл буюу 2016 оны 12 сарын байдлаар эргэн төлөлтийн доголдолтой зээл нийт зээлийн 14.2% буюу 1.7 их наяд төгрөгт хүрчээ. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2016 оны эцэст өнгөрсөн 6 жилийн хугацаан дахь хамгийн өндөр түвшинд хүрсэн байна.

Монгол Улсын ихэнх чухал ач холбогдол бүхий салбар төдийгүй нийгэм, эдийн засгийн бүхий л давхарга болох хувь хүн, хуулийн этгээд банкны салбараас ихээхэн хамааралтай байна.

Иймд банкны салбар хямрахаас сэргийлэх, тус салбар, цаашлаад эдийн засгийн тогтвортой байдлыг хангах шаардлага тулгарч байна. Банк, санхүүгийн салбарт хуримтлагдсан чанаргүй зээл, активыг шийдвэрлэх, тус салбарын тогтвортой байдлыг хангах хамгийн оновчтой шийдэл нь актив удирдлагын тогтолцоог бүрдүүлэх явдал юм.

Дэлхийн улс орнууд банкны чанаргүй зээлийн хувь хэмжээ эрс нэмэгдэж, санхүүгийн салбарын тогтвортой байдал алдагдах эрсдэл өндөр болсон, банкны чанаргүй зээлээс үүдэлтэй алдагдлыг нөхөх бололцоо эрс хумигдсан бөгөөд их хэмжээний чанаргүй зээлийг нэг дор шийдвэрлэх боломж хязгаарлагдмал нөхцөлд Актив удирдлагын тогтолцоог бий болгодог байна.

Дээр дурдсан тоо баримтаас үзэхэд Монгол Улсад Актив удирдлагын тогтолцоог бий болгох нөхцөл бүрдсэн гэж хууль санаачлагч үзэж, банкны чанаргүй актив, зээлийг шийдвэрлэх замаар банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлын хангах Актив удирдлагын компанийг үүсгэн байгуулж, түүний эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Иймд банк, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, тогтвортой байдлыг хангах зорилгоор, энэ хэрэгцээ шаардлагад үндэслэн дараах үндэслэлээр Актив удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

1. Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр"[2]-ийн 2.2 дахь заалтад "банкны салбарт эрсдэл хуримтлагдах, зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх арга хэмжээ авах"-аар тусгасан.

2. Улсын Их Хурлын 2015 оны 93 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл"-ийн 3.1-д "санхүүгийн тогтвортой

---

[2] Энэ тогтоолыг Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.

байдлыг хангах, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийг хөгжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх"-ийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан.

Эдгээр ажлын хүрээнд Актив удирдлагын тогтолцоог бүрдүүлэх талаарх судалгаа, ажлыг эхлүүлсэн. Тус ажилд эдгээр байгууллагаас гадна Монгол Улсын арилжааны банкууд оролцож, хамтран ажилласан.

3. Улсын Их Хурлын 2016 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл"-ийн 3.2-д "санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцын эрх зүйн орчныг бүрдүүлэх" арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан.

4. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр" батлах тухай 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Тэргүүн ээлжинд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн жагсаалтын 4 дэх хэсэгт "арилжааны банкуудын оролцоотойгоор активын удирдлагын институц байгуулж, банкны системийн чанаргүй зээлийн хэмжээг бууруулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Активын удирдлагын институцийн тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх"-ээр тусгасан байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан дээрх үндэслэл, хэрэгцээ шаардлагаас үзвэл Актив удирдлагын тухай хуулийн төслийн үндсэн зорилго нь "банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив удирдлагын тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлэх" бөгөөд дараах хэд хэдэн дэд зорилго байна гэж үзлээ.

1. Монгол Улсын Актив удирдлагын компани /Цаашид "Актив удирдлагын компани" гэх/-ийг үүсгэн байгуулах;
2. Актив удирдлагын компанийн ажиллах үндэслэл, хүрээг тогтоох;
3. Актив удирдлагын компанийн хараат бус байдлыг хангах;
4. Актив удирдлагын компанид хяналт тавих үндэслэлийг тогтоох;
5. Чанаргүй актив, зээлийг шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх;

Дээрх зорилгыг харгалзан Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс хуулийн төслийн зорилгод хүрэхэд чиглэсэн дараах зохицуулалтын үр нөлөөг үнэлэхээр сонголоо.

4.1.Актив удирдлагын компани нь банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкнаас энэ хуульд тодорхойлсон чанаргүй активыг шилжүүлэн авах, түүнтэй холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

**6 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн бие даасан байдал**

6.1.Актив удирдлагын компани, түүний төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтан энэ хуульд заасан эрх, албан үүргээ хэрэгжүүлэхдээ

аливаа этгээдээс хараат бус, бие даасан байна.

**7 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагаа**

7.1.Актив удирдлагын компани дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

7.1.1.энэ хуульд заасны дагуу чанаргүй активыг шилжүүлэн авах;

7.1.2.хөрөнгө, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг төлүүлэх, шаардлагатай тохиолдолд барьцаа, эрсдэлийн сангаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах зэргээр банкнаас шилжүүлэн авсан чанаргүй зээлийг өмчлөх, эзэмших, удирдах, захиран зарцуулах;

7.1.3.банкнаас шилжүүлэн авсан чанаргүй активыг сайжруулах эсхүл түүний үнэ цэнийг нэмэгдүүлэх, хамгаалах талаар дараах арга хэмжээг авах:

7.1.3.а.актив болон активын багцыг боломжит өндөр үнээр худалдан борлуулах, захиран зарцуулах;

7.1.3.б.чанаргүй активыг төлүүлэх, активт холбогдох этгээдийн актив хөрөнгийг шалгах, хамгаалах;

7.1.3.в.активын багцыг үнэт цаас гаргах болон бусад аргаар санхүүжүүлэх;

7.1.3.г.зээлийн барьцаа хөрөнгийг худалдан борлуулах, захиран зарцуулах, эзэмшилдээ авах, санхүүжүүлэх, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах;

7.1.3.д.Актив удирдлагын санг удирдах;

7.1.3.е.энэ хуулийн 35.5-д заасан журмаар тогтоосон бусад;

7.1.4.Банкны хүсэлтээр актив шийдвэрлэх үйл ажиллагаа.

**9 дүгээр зүйл.Банкны хүсэлтээр актив шийдвэрлэх үйл ажиллагаа**

9.1.Банк Актив удирдлагын компанид өөрийн чанаргүй активын төлбөрийг шаардах, төлүүлэх, хөрөнгө худалдан борлуулах зэргээр чанаргүй активыг шийдвэрлэх эрхийг олгож болно.

**35 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд хяналт тавих**

35.1.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.

**"Практикт хэрэгжих боломж"**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломж байна уу гэдгийг үнэлэх үүднээс хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах зохицуулалтыг сонгож авлаа.

| |
|---|
| 7.2.Энэ хуулийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө, өр төлбөрийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор Актив удирдлагын компани нь хуулиар хориглоогүй, энэ хуулийн 7.1-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхэлж болно. |

**"Ойлгомжтой байдал"**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 9 бүлэг, 37 зүйлтэй./

**"Хүлээн зөвшөөрөгдөх байдал"**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэх, байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлахаар хуулийн төслөөр үүрэг хүлээлгэсэн, шинэ бүтэц, чиг үүрэг нэмсэн дараах зүйл, хэсэг, заалтыг сонгож авав.

| |
|---|
| 4.1.Актив удирдлагын компани нь банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкнаас энэ хуульд тодорхойлсон чанаргүй активыг шилжүүлэн авах, түүнтэй холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани байна. |

**"Харилцан уялдаа"**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

## ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон бөгөөд урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон аргачлалд тодорхойлогдсон дараах шалгах хэрэгслүүд байна.

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Үр нөлөөг үнэлэх хэсэг | Тохирох шалгах хэрэгсэл |
|---|---|---|---|
| 1 | Зорилгод хүрэх байдал | 4 дугаар зүйлийн 4.1 дэх хэсэг- Актив удирдлагын компани,<br>6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг- Актив удирдлагын компанийн бие даасан байдал,<br>7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг- Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагаа,<br>9 дүгээр зүйлийн 9.1- Чанаргүй активыг | Зорилгод дүн шинжилгээ хийх |

| | | | |
|---|---|---|---|
| | | шийдвэрлэх, захиран зарцуулах, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг- Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд хяналт тавих. | |
| 2 | Практикт хэрэгжих боломж | 7 дугээр зүйлийн 7.2 дахь хэсэг | Практикт турших |
| 3 | Ойлгомжтой байдал | Хуулийн төсөл бүхэлдээ | Ойлгомжтой байдлыг судлах |
| 4 | Хүлээн зөвшөөрөгдөх байдал | 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг | Хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар өмнө хийгдсэн ажилд дүн шинжилгээ хийх |
| 5 | Харилцан уялдаа | Хуулийн төсөл бүхэлдээ | Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах |

Дээрх шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

**4.1 "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Эдийн засгийн таатай бус өнөөгийн нөхцөлд банкны салбарт хуримтлагдсан чанаргүй зээл, активыг шийдвэрлэх замаар банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах нь нэн чухал болохыг дээр дурдсан. Олон улсад их хэмжээний чанаргүй активыг шийдвэрлэх хамгийн үр дүнтэй аргад тооцогдсон Актив Удирдлагын тогтолцоог компани байгуулан, үйл ажиллагаа явуулах хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Актив удирдлагын компани нь банкнаас чанаргүй хөрөнгийг шилжүүлэн авч тэдгээр хөрөнгийн эргэн төлөгдөх дүнг нэмэгдүүлэх зорилгоор удирдан ажилладаг хувийн, төрийн эсвэл хамтарсан хэлбэрээр байгуулагддаг хуулийн этгээд юм.

Банкны балансаас чанаргүй зээлийг хассанаар Актив удирдлагын компани санхүүгийн хүндрэлд орсон банкуудын төлбөрийн болон хөрвөх чадварыг сэргээхэд тусалдаг бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг олгодог онцлогтой.

Хууль санаачлагчийн зүгээс Актив удирдлагын тогтолцоог бүрдүүлэх тус хуулийн төслийг банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Актив удирдлагын компанийг хувийн хөрөнгө оруулалт давамгайлсан төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд хэлбэрээр байгуулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг тогтоох зорилгоор боловсруулсан байх бөгөөд уг компани банкнаас тус төсөлд заасан чанаргүй зээл, активыг шилжүүлэн авах, түүнтэй холбогдох бусад үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар, тус компани банкнаас бусад санхүүгийн байгууллагаас чанаргүй актив шилжүүлэн авах үйл ажиллагааг хязгаарлахаар заасан байна.

Иймд хуулийн төслийн зорилго нь түүнийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байна.

Хуулийн төслийн зорилго, зорилтыг хуулийн төслийн зохицуулалт нь хангахад чиглэсэн, зорилгыг хангах боломжтой байдлаар томьёологдсон эсэхийг үнэлэхээр хуулийн

төслийн зорилго, зорилтыг сонгож авсан дараах зохицуулалтуудтай харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

**Актив удирдлагын тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал:**

| |
|---|
| 4.1.Актив удирдлагын компани нь банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкнаас энэ хуульд тодорхойлсон чанаргүй активыг шилжүүлэн авах, түүнтэй холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани байна. |

Актив удирдлагын компанийг хуульд заасны дагуу үүсгэн байгуулсанаар чанаргүй зээл, активтай холбоотойгоор эдийн засагт тулгараад буй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хангах, хяналт, үр дүнг сайжруулах зэрэг цогц асуудлыг шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ. Гэхдээ түүний үйл ажиллагааны хүрээ, засаглалын тогтолцоо, бүрэн эрхийг хуульчлан зааж өгөх нь чанаргүй зээл, активыг боломжит хэмжээгээр барагдуулах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ чанаргүй активыг шийдвэрлэх бүх шатанд нэгдсэн нэг ойлголттой болж, үр дүн сайжрах ач холбогдолтой. Иймд тус зохицуулалт нь банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор актив удирдлагын компанийг үүсгэн байгуулах хуулийн зорилгод нийцсэн гэж үзэж байна.

**Актив удирдлагын тухай хуулийн төслийн 6 дугаар 6.1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал:**

| |
|---|
| 6.1.Актив удирдлагын компани, түүний төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтан энэ хуульд заасан эрх, албан үүргээ хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус, бие даасан байна. |

Чанаргүй зээл, активыг боломжит хэмжээгээр барагдуулж, банк, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх үйл ажиллагаанд Актив удирдлагын компанийн хараат бус байдал чухал нөлөөтэй болохыг Базелийн хороо, IAIS, IOSCO зэрэг олон улсын байгууллагууд зөвлөдөг. Дараах тохиолдолд Актив удирдлагын компанийн хараат бус байдал хангагдсан гэж үзнэ.

1. Актив удирдлагын компанийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль тогтоомжид түүний хараат бус байдлыг баталгаажуулж, тус компанийг үйл ажиллагаа, санхүүгийн тайлангаа ил тод тайлагнахыг шаардах;

2. Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг зөвхөн тодорхой шалтгааны улмаас эргүүлэн татдаг байхаар хуульд тусгах;

3. Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон ажилтнуудыг хуулиар хамгаалах.

Актив удирдлагын тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлээр Актив удирдлагын компанийн болон түүний ажилтан, албан тушаалтнуудын хараат бус байдлыг баталгаажуулсан байх бөгөөд бусад этгээдийн зүгээс тэдгээрийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглосон. Түүнчлэн тус хуулийн төслийн 21 дүгээр зүйлээр Актив удирдлагын компани болон ажилтан, албан тушаалтны баталгааг хуульчилж, 15 дугаар зүйлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх

үндэслэлийг нарийвчлан зааж, 32, 33 дугаар зүйлээр тус компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны ил тод байдлын тайлагналыг баталгаажуулсан байна.

Иймд Актив удирдлагын тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн зохицуулалт нь Актив удирдлагын компанийн хараат бус байдлыг бэхжүүлэх хуулийн зорилтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна гэж үзэж байна.

**Актив удирдлагын тухай хуулийн төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал:**

| |
|---|
| 35.1.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина. |

Чанаргүй зээл, активыг түргэн, шуурхай шийдвэрлэхэд Актив удирдлагын компанийн засаглал, хяналт үр нөлөөтэй байх шаардлагатай.

Олон улсын жишгээр Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд дараах этгээд хяналт тавьж байна.

1. Санхүүгийн хяналт шалгалт явуулдаг байгууллага,
2. Сангийн яам,
3. Төв банк

Актив удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлд Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хүлээхээр заасан байна.

Иймд тус зохицуулалт нь Актив удирдлагын компанид тавих хяналтын эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх зорилгыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, тус зорилгод нийцэж байна.

**Актив удирдлагын тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал:**

| |
|---|
| **7 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагаа**<br><br>7.1.Актив удирдлагын компани дараах үйл ажиллагааг эрхэлнэ:<br><br>7.1.1.энэ хуульд заасны дагуу чанаргүй активыг шилжүүлэн авах;<br><br>7.1.2.хөрөнгө, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг төлүүлэх, шаардлагатай тохиолдолд барьцаа, эрсдэлийн сангаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах зэргээр банкнаас шилжүүлэн авсан чанаргүй зээлийг өмчлөх, эзэмших, удирдах, захиран зарцуулах;<br><br>7.1.3.банкнаас шилжүүлэн авсан чанаргүй активыг сайжруулах эсхүл түүний үнэ цэнийг нэмэгдүүлэх, хамгаалах талаар дараах арга хэмжээг авах:<br><br>7.1.3.а.актив болон активын багцыг боломжит өндөр үнээр худалдан борлуулах, захиран зарцуулах;<br><br>7.1.3.б.чанаргүй активыг төлүүлэх, активт холбогдох этгээдийн актив |

хөрөнгийг шалгах, хамгаалах;

7.1.3.в.активын багцыг үнэт цаас гаргах болон бусад аргаар санхүүжүүлэх;

7.1.3.г.зээлийн барьцаа хөрөнгийг худалдан борлуулах, захиран зарцуулах, эзэмшилдээ авах, санхүүжүүлэх, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах;

7.1.3.д.Актив удирдлагын санг удирдах;

7.1.3.е.энэ хуулийн 35.5-д заасан журмаар тогтоосон бусад;

7.1.4.Банкны хүсэлтээр актив шийдвэрлэх үйл ажиллагаа.

Олон улсын жишгээр Актив удирдлагын компани дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

1.эргэн төлөлтийг хамгийн өндөр байх зорилгоор хүндрэлд орсон санхүүгийн байгууллагын чанаргүй зээлийг өөртөө шилжүүлэн авах, удирдах,

2.хүндрэлд орсон банкны үйл ажиллагааг сайжруулахад оролцох,

3.банкны зээлээ эргэн төлөх чадварыг сайжруулах зорилгоор зээлдэгч этгээдэд бүтцийн өөрчлөлт хийх.

Эдгээр үйл ажиллагаа тус бүртээ ихээхэн цаг хугацаа, хөрөнгө, хүч шаарддаг учраас Монгол Улсын Актив удирдлагын компани эдгээр үйл ажиллагааны нэг болох чанаргүй зээл, активыг шилжүүлэн авч, шийдвэрлэх үйл ажиллагааг дагнан эрхлэх нь үр дүнтэй гэж хууль тогтоогч үзсэн байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлд Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагааг заасан байх бөгөөд Монгол Улсын Актив удирдлагын компани чанаргүй зээл, активыг шилжүүлэн авах замаар шийдвэрлэх, түүнд холбогдох үйл ажиллагааг эрхлэхээр заасан нь Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоох хуулийн зорилгод нийцэж, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

**Актив удирдлагын тухай хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал:**

**9 дүгээр зүйл.Банкны хүсэлтээр актив шийдвэрлэх үйл ажиллагаа**

9.1.Банк Актив удирдлагын компанид өөрийн чанаргүй активын төлбөрийг шаардах, төлүүлэх, хөрөнгө худалдан борлуулах зэргээр чанаргүй активыг шийдвэрлэх эрхийг олгож болно.

Солонгос, Хятад, Тайланд, Индонези зэрэг дэлхийн улс орнууд Активын удирдлагын компанийг байгуулсан нь чанаргүй зээл, активыг үр ашигтай аргаар шийдвэрлэхэд чухал түлхэц болсон байна.

Чанаргүй зээл, активыг Актив удирдлагын компани дараах 2 арга замаар шилжүүлэн авдаг байна.

1. Банк Актив удирдлагын компанид өөрийн чанаргүй активыг шийдвэрлэх эрхийг олгох,

2. Банк Актив удирдлагын компанид өөрийн чанаргүй зээл, активыг шууд захиран зарцуулах эрхийг олгох хүсэлт гаргах.

Актив удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт Актив удирдлагын компани дээр дурдсан 2 арга замаар банкны чанаргүй зээл, активыг шилжүүлэн авах тухай зааж өгсөн байна. Энэ нь хуулийн төсөлд Актив удирдлагын компанийн чанаргүй зээл, активыг шилжүүлэн авах хүрээг тогтоох зорилгод нийцсэн гэж үзэж байна.

**4.2 "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэхээр хуулийн төслөөс сонгож авсан дараах зохицуулалтын талаар туршсан байдалд дүн шинжилгээ хийх, санал авч дүгнэлт гаргах замаар үр нөлөөг судаллаа.

**Актив удирдлагын тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал:**

| |
|---|
| 7.2.Энэ хуулийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө, өр төлбөрийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор Актив удирдлагын компани нь хуулиар хориглоогүй, энэ хуулийн 7.1-д зааснаас бусад үйл ажиллагааг эрхэлж болно. |

Дэлхийн банкнаас гаргасан "Төрийн актив удирдлагын компани" сэдэвт судалгаанаас үзэхэд дэлхийн улс орнууд чанаргүй зээл активыг үр дүнтэй түргэн шуурхай шийдвэрлэж, банк, санхүүгийн салбарыг хямралаас сэргийлэх, тогтвортой байдлыг хангах зорилгоор Актив удирдлагын компанийг байгуулсан байна[3].

Монгол улсын хувьд Актив удирдлагын компанийг байгуулах талаар 2015 оноос эхлэн төрөөс анхаарч ажилласан бөгөөд санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, тогтвортой байдлыг хангах зорилгоор Актив удирдлагын компанийг байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэхийг Улсын Их Хурлаас Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгаж ирсэн бөгөөд тус ажлын хүрээнд эдгээр байгууллагын зүгээс банкуудтай Актив удирдлагын компани байгуулах талаар хамтран ажиллаж ирсэн. Харин тус компанийг байгуулан үр дүнтэй ажиллуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

Иймд Актив удирдлагын тухай хуулийн төсөл батлагдсан тохиолдолд Актив удирдлагын компани байгуулагдан хуульд заасан үйл ажиллагаа эрхлэх замаар үр дүнтэй ажиллах боломжтой эсэх талаар дүн шинжилгээ хийлээ.

Чанаргүй зээл, актив нэмэгдэж, эрсдэл даах чадвар сулрахад банк зээл олголтоо хумьж, эрсдэл өндөртэй салбарт нэмэлт санхүүжилт олгохоос зайлсхийдэг байна.

Монгол Улсын банкны салбарт дээр дурдсан нөхцөл байдал бий болоод байна. 2010 оны эцэст зээл банкны активын 66 хувийг бүрдүүлж байсан бол өнгөрсөн оны эцэст 46 хувьд хүрч 20 нэгжээр буурчээ.

---

[3] A world bank study, Public asset management companies, 2016, p71

Хэрэв зөвхөн эрсдэл даах чадварын хүндрэлд орох 4 банк зээлийн эрсдэлээ бууруулах арга хэмжээ авахад цаашид эдийн засаг дахь зээлийн хэмжээ одоогийн түвшнөөс 30 орчим хувиар агших төлөвтэй байна.

Уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл, худалдаа зэрэг эдийн засгийн голлох салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувь буурч, хэрэглээ, үндсэн хөрөнгө санхүүжүүлэх зорилготой иргэдийн зээлийн хэмжээ 2016 онд нэмэгдсэн. Баялаг бүтээх, хөрөнгө оруулалтын зориулалтай бодит секторын зээл хумигдаж байгаа нь аж ахуйн нэгжид олгосон зээлийн эрсдэл нь иргэдийн зээлийн эрсдэлээс харьцангуй өндөр байгаатай холбоотой.

Төв болон Зүүн Европын оруудын *(Central, Eastern, South-Eastern)* 1998-2011 оны[4] нөхцөлд байдалд хийсэн судалгаа, Нефть олборлогч орнуудын *(Gulf Cooperation Council)* 1995-2008 оны[5] эдийн засгийн хөгжилд хийсэн дүгнэгт, хөгжиж буй орнуудын *(Emerging market)* 1966-2010 онуудын туршлага[6] зэргээс харахад чанаргүй зээлийн өсөлт нь санхүүгийн зуучлалыг зогсонги байдал оруулж, эдийн засгийн идэвхжилтийг сулруулан, бодит секторын өсөлтийг хязгаарлаж, ажилгүйдлийг нэмэгдүүлэх нөлөөтэй байна.

Чанаргүй зээл өсч, бодит секторын зээл буурахад эдийн засгийн голлох үзүүлэлтүүд огцом буурдаг бөгөөд улс орны эдийн засгийн хөгжлийг сулруулах нөлөөтэй[7]. Түүнчлэн чанаргүй зээл нэмэгдэх нь зээл олголтыг бууруулж хямралыг улам гүнзгийрүүлэх бөгөөд эргээд зээлийн чанарыг нэмж муутгах хандлагатай болно.

Энэ нь төсөв, мөнгөний хатуу бодлого баримталж буй өнөөдрийн нөхцөлд эдийн засгийн сэргэлтийг удаашруулах, ажилгүйдлийг нэмэгдүүлэх, халамжийн зардлыг өсгөх нөлөөтэй. Мөн татварын орлогыг бууруулж, өрийн тэнцвэрт байдалд хүрэх зорилтыг хэрэгжүүлэхэд томоохон саад учруулна. Банкны салбарт тогтворгүй байдал үүсч, зах зээлд агшилт гүнзгийрэх нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийг өсгөж, санхүүжилтийг зардлыг бууруулах тулгамдсан арга хэмжээнд сөргөөр нөлөөлж, банкны салбараас эх үүсвэр гадагшлах нөхцөлийг бүрдүүлнэ.

Эдгээр асуудлыг актив удирдлагын мэргэшсэн институцийг байгуулж, эрсдэлтэй зээлийг зохистой үнээр шилжүүлэн авах замаар банкны чанаргүй зээлийг бууруулж, ирээдүйд учирч болох эрсдэлээс сэргийлэх, банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах шаардлагатай байна.

Актив удирдлагын тухай хуулийн төслийн дагуу Актив удирдлагын компанийг байгуулах болон ийнхүү байгуулах нь дээр дурдсан Монгол Улсын банк, санхүүгийн салбарт үүсч болох асуудлаас сэргийлэх, шийдвэрлэх эсэх, тус компанийн эрхлэх үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаар Сангийн яам, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл буюу хуулийн төслийг боловсруулахад оролцсон гишүүдээс ажлын хэсгийн хурал дээр болон цахим хэлбэрээр санал авсан.

---

[4] Nonperforming loans in CESEE: Determinants and Impact on Mactoeconomic performace, *Nir Klein*, 2013
[5] Nonperforming loans in the GCC Banking system and their macroeconomic effects, *Raphael Espinoza and Ananthakrishnan*, 2010
[6] Bank asset quality in Emerging markets: Determinants and Spillovers, *Reinout De Bock and Alexander Demyanets*, 2012
[7] PPT presentation, ADB-China Huarong jointly hosted the Financial Stability Seminar on Managing NPLs in Asia and Europe, Shanghai, PRC

Дээрх санал асуулгад Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл хуулийн төсөл болон Актив удирдлагын компани байгуулахыг дэмжиж байгаа, тус компани байгуулагдсанаар банк, санхүүгийн салбарт үүсч болох дээр дурдсан эрсдэлээс сэргийлнэ гэж үзэж байгаагаа илэрхийлсэн. Мөн Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаар тодорхой санал өгсөн.

Олон улсын туршлага, дээр дурдсан саналаас үзэхэд Актив удирдлагын компани нь чанаргүй зээл, активыг шийдвэрлэх замаар банк, санхүүгийн салбарыг эрсдэлээс сэргийлэх зорилгоор байгуулагдаж, чанаргүй зээл, активт холбогдох хөрөнгө, өр төлбөрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлдэг байна.

Иймд хуулийн төслийн 7.2 дахь хэсэг нь Актив удирдлагын компани үйл ажиллагаа явуулах үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд учрах саад бэрхшээл байхгүй буюу практикт шууд хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

**“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг тогтоох зорилгоор Сангийн яам, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл буюу хуулийн төслийг боловсруулахад оролцсон Ажлын хэсгийн гишүүдээс санал авахад хуулийн төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд ойлгомжгүй байгаа зохицуулалт байхгүй тухай дараах саналаа ирүүлсэн байна.

| № | Санал ирүүлсэн байгууллагын нэр | Саналын агуулга | Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт |
|---|---|---|---|
| 1 | Сангийн яам,<br>Монголбанк,<br>Санхүүгийн зохицуулах хороо | Актив удирдлагын тухай хуулийн төсөл нь зөв ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан байна. | - |

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

| **Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага** | |
|---|---|
| **Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт** | **Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал** |

| | |
|---|---|
| 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх; | 1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн хуульчилсан. Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлд төрд эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах үүргийг хүлээлгэсэн бөгөөд энэ талаар хуульчлан баталгаажуулсантай хуулийн төсөл нийцэж байна.<br><br>Мөн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” батлах тухай 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Тэргүүн ээлжинд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн жагсаалтын 4 дэх хэсэгт “арилжааны банкуудын оролцоотойгоор активын удирдлагын институц байгуулж, банкны системийн чанаргүй зээлийн хэмжээг бууруулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Активын удирдлагын институцийн тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх”-ээр тусгасан байна.<br><br>2. Хуулийн төслийн зохицуулалтууд нь Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжтой зөрчилдөх зохицуулалт агуулаагүй байна.<br><br>Иймд уг шаардлагыг хангасан байна. |
| 29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа | Уг шаардлагыг хангасан байна. |

| | |
|---|---|
| хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх; | |
| 29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана. | Уг шаардлагыг хангасан байна. Хуулийн төслийн зорилт нь банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив Удирдлагын Компанийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож, зохицуулахад оршино гэж тус төсөлд заасан. |
| **Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага** | |
| 30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол | Уг шаардлагыг хангасан байна. |

| | |
|---|---|
| утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих; | |
| 30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх. | Уг шаардлагыг хангасан байна. |

**"Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг хэрэглэх байгууллага хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх боломжтой эсэх тухай хуулийн төслийн зохицуулалтын нөлөөлөхүйц байдал, хэрэгжих боломжийн судалгааг хуулийн дараах зүйл, хэсэг, заалтын хүрээнд Сангийн яам, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл буюу уг хуулийн төслийг боловсруулахад оролцсон Ажлын хэсгийн гишүүд болох эдгээр байгууллагын төлөөллөөс санал авах байдлаар судалж, дүн шинжилгээ хийлээ.

**Актив удирдлагын тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал:**

| |
|---|
| 4.1.Актив удирдлагын компани нь банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкнаас энэ хуульд тодорхойлсон чанаргүй активыг шилжүүлэн авах, түүнтэй холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани байна. |

Сангийн яам, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл буюу тус хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийн гишүүд болох эдгээр байгууллагын төлөөлөл "банк, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, тогтвортой байдлыг хангах зорилго бүхий, чанаргүй зээл, активыг шийдвэрлэх үйл ажиллагаа явуулах Актив удирдлагын компани байгуулах"-ыг дэмжсэн байна.

Хуулийн төслийн дагуу Актив удирдлагын компани байгуулахад Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо чухал үүрэгтэй оролцох бөгөөд түүний үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах тул эдгээр байгууллагын төлөөллөөс санал авсан болно.

Эдгээр байгууллага Актив удирдлагын компани байгуулагдан үйл ажиллагаа явуулахыг дэмжиж байгаа тул хуулийн төслийн Актив удирдлагын компани байгуулан үйл ажиллагаа явуулах тухай зохицуулалт хэрэгжих боломжтой гэсэн дүгнэлтэд хүрлээ.

**"Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

| д/д | Асуулт | Хариулт буюу дүн шинжилгээ |
|---|---|---|
| 1 | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх; | Хуулийн төслийн зохицуулалт нь Актив удирдлагын тухай хуулийн төслийн зорилтод нийцэж байна. |
| 2 | Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх; | Хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль[8], Банкны тухай хууль[9] нь тус хуулийн төсөлд болон төслөөр зохицуулах харилцаанд хамаарна. |
| 3 | Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх; | Хуулийн төслийн 3 дугаар зүйлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа болно. |
| 4 | Хуулийн төслийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгатай нийцэж байгаа эсэх; | Хуулийн төслийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгатай нийцэж байгаа болно. |
| 5 | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх; | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байна. |
| 6 | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх; | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардаагүй. |
| 7 | Хуулийн төсөлд тухайн хуулийн төсөл болон бусад хуулиас авсан эшлэлийг зөв хийсэн эсэх; | Хуулийн төсөлд тухайн хуулийн төслөөс болон бусад хуулиас эшлэл авсан зохицуулалтууд нь зөв хийгдсэн байна. |
| 8 | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх; | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зохицуулалт байхгүй байна. |
| 9 | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх; | Хуулийн төслийн 35.1-д "Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина." Гэх зэргээр тодорхой тусгаж өгсөн байна. |
| 10 | Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх; | Албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зохицуулалт тусгагдаагүй байна. |
| 11 | Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл | Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт |

[8] Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2005 оны 46 дугаарт нийтлэгдсэн

[9]Банкны тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

| | | |
|---|---|---|
| | ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх; | тусгагдаагүй байна. |
| 12 | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх; | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй байна. |
| 13 | Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх; | Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдалд нөлөөлөх, холбогдох зохицуулалт агуулаагүй байна. |
| 14 | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна. |
| 15 | Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна. |
| 16 | Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх. | Хуулийн төслийн 36 дугаар зүйлийн 36.1-д "Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж зааж зохицуулсан. Гэвч хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан тодорхой заагаагүй байна. Хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төслийн Зөрчлийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд нарийвчлан тусгах шаардлагатай гэж үзэж байна. |

## ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

### 5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1. Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр” -ийн 2.2 дахь хэсэг,
2. Улсын Их Хурлын 2015 оны 93 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл"-ийн 3.1 дахь хэсэг;
3. Улсын Их Хурлын 2016 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл"-ийн 3.2 дахь хэсэг;
4. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” батлах тухай 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Тэргүүн ээлжинд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн жагсаалтын 4 дэх хэсэг;
5. Актив удирдлагын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл;
6. Актив удирдлагын тухай хуулийн төслийн талаарх танилцуулга;

7. A world bank study, Public asset management companies, 2016, холбогдох хэсэг;
8. Nonperforming loans in CESEE: Determinants and Impact on Macroeconomic performace, Nir Klein, 2013;
9. Nonperforming loans in the GCC Banking system and their macroeconomic effects, Raphael Espinoza and Ananthakrishnan, 2010;
10. Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийн талаар санал авсан саналын хуудас;
11. Хуулийн төслийн ойлгомжтой байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар авсан саналын хуудас.

### 5.2. Үнэлэлт дүгнэлт

Энэхүү үнэлгээний ажлын явцад албан бичгээр санал авах, олон улсын туршлага болон эрдэмтдийн хийсэн судалгаа, улс орнуудын сайн туршлага бүхий хуультай харьцуулах, давхардал хийдлийг илрүүлэхээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж болон олон улсын сайн туршлагатай харьцуулсан дүн шинжилгээ хийх зэрэг аргыг хэрэглэснээс гадна энэ асуудлын хүрээнд хийгдсэн албан ёсны судалгааг ашигласан болно.

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлт тус бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

**“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр:**

Хуулийн төслийн зорилго нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэх эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн төслийн зохицуулалт хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томьёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд хуулийн төслийн зорилго үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага, үндэслэлийг бүрэн илэрхийлж чадсан байна.

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөлд тодорхойлсон зорилго, зорилтыг бүрэн илэрхийлж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж чадсан эсэх талаар хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг сонгон үнэлгээг хийлээ.
Хуулийн төслийн эдгээр зохицуулалтыг дараах байдлаар хуулийн төслийн зорилгод нийцсэн байна гэж дүгнэв. Үүнд :

- 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг – Актив удирдлагын компанийг хуульд заасны дагуу үүсгэн байгуулсанаар чанаргүй зээл, активтай холбоотойгоор эдийн засагт тулгараад буй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хангах, тэдгээрт тавих хяналт, үр дүнг сайжруулах зэрэг асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэх бөгөөд энэ нь хуулийн төслийн зорилгод нийцсэн, уг зорилгыг хангах боломжтой байдлаар томьёологдсон байна.
- 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг – Актив удирдлагын компани, түүний ажилтан, албан тушаалтан аливаа этгээдээс хараат бус, бие даасан байх зохицуулалт нь тус компани хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хуулийн төслийн зорилгод нийцэж байна.

- 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт –Банкнаас Актив удирдлагын компанид чанаргүй зээл. актив шилжүүлэх нөхцөл болон захиран зарцуулах эрх олгох нөхцөлийг заасан нь эдгээр хөрөнгийг Актив удирдлагын компаниас үр ашигтай, түргэн шуурхай удирдах нөхцөлийг бүрдүүлсэн байх тул энэ нь хуулийн төслийн зорилгод нийцтэй, түүнийг хэрэгжүүлэх боломжтой байдлаар тусгагдсан байна гэж дүгнэсэн болно.
- 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг –Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагааг нарийвчлан тусгасан нь чанаргүй зээл, активыг шилжүүлэн авах, түүнийг шийдвэрлэх үйл ажиллагааг тодорхой болгохын зэрэгцээ тус компанийн үйл ажиллагааны үндэслэл, хүрээг тогтоож байх тул хуулийн төслийн зорилгод нийцсэн байна.
- 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг – Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавихаар заасан байгаа нь тус компанийн үйл ажиллагаанд хяналт тавих үндэслэлийг тогтоох зорилгод нийцсэн зохицуулалт болсон.

**“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр:**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн Актив удирдлагын компанийг байгуулах, үйл ажиллагаа явуулах үндэслэлийг бүрдүүлсэн зохицуулалтын үр нөлөөг банк, санхүүгийн салбарт одоо үүсч буй асуудал болон түүнийг шийдвэрлэх боломж, уг хуулийг хэрэгжүүлэх байгууллага болох Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос авсан саналд үндэслэн дүн шинжилгээ хийсэн болно.

Чанаргүй зээл, активаас үүдэн банк, санхүүгийн салбарт хямрал үүсэхээс сэргийлэх, тус салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор дэлхийн улс орнууд Актив удирдлагын компанийг байгуулан, үр дүнтэй ажиллуулж байгаа бөгөөд цаашид хуулийн төсөлд тусгагдсаны дагуу Актив удирдлагын компанийг байгуулан, тус компани хуульд заасан чанаргүй зээл, активыг шийдвэрлэх үйл ажиллагаа явуулахад учрах хүндрэл, саад бэрхшээл байхгүй байна.

Түүнчлэн Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл “чанаргүй зээл, активыг шийдвэрлэх замаар банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий Актив удирдлагын компани байгуулах”-ыг дэмжиж байгаа тухай санал өгсөн байх тул уг зохицуулалтыг практикт шууд хэрэгжих боломжтой гэж дүгнэсэн.

**Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд холбогдох байгууллага болох Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллөөс тусгайлсан санал ирүүлээгүй тул хуулийн төслийг ойлгож хэрэгжүүлэх боломжтой байна гэж үзсэн.

Түүнчлэн хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөлд тавигдах шаардлагад нийцсэн байна.

**“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр:**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлахаар хуулийн төслөөр үүрэг хүлээлгэсэн, шинэ бүтэц, чиг үүрэг нэмсэн хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг сонгон авч үр нөлөөг нь үнэллээ.

Хуулийн төслөөр Актив удирдлагын компанийг шинээр байгуулах зохицуулалт оруулсан байх тул Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллөөс дээрх зохицуулалтын талаар санал авахад дэмжиж байгаа тухай санал өгсөн.

Иймд дээрх зохицуулалт нь хэрэгжих боломжтой байдлаар хуулийн төсөлд тусгагдсан төдийгүй хуулийн төслийн зорилгод нийцсэн үр ашигтай зохицуулалт болсон байх тул уг шалгуур үзүүлэлтийг хангасан байна гэж үзсэн болно.

**Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-д тусгагдсан асуултад хариулах замаар хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд хуулийн төслийн зохицуулалтууд нь өөр хоорондоо болон бусад холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоотой байдлаар тусгагдсан байна.

Харин хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой, нарийвчлан тусгаж өгөөгүй байна гэж үзэж болохоор байна. Тодруулбал:

- Хуулийн төслийн 36 дугаар зүйлийн 36.1-д "Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж зааж зохицуулсан. Иймд хуулийн төслийг дагалдан гарах Зөрчлийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Актив удирдлагын тухай хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан тусгах шаардлагатай гэж үзэж байна.

**5.3.Зөвлөмж**

Актив удирдлагын тухай хуулийн төслийг банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив удирдлагын тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилготойгоор боловсруулсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөг "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу үнэлэхэд Актив удирдлагын тухай хуулийн төсөл нь хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

Харин үр нөлөөг тооцох ажиллагааны явцад гарсан дараах асуудлын талаар дахин анхаарах шаардлагатай байна гэсэн зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна.

1. Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг хуулийн төслийг дагалдан гарах Зөрчлийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Актив удирдлагын тухай хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан тусгах,

2. Актив удирдлагын компанийг үүсгэн байгуулах бэлтгэл ажил хангахтай холбогдуулан хууль хүчин төгөлдөр болох хугацааг хуулийн төсөлд заах,

________o0o________

# АКТИВ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

2019.04.15

Актив удирдлагын тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг Монголбанкны өргөтгөлийн 2 давхарын хурлын зааланд 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 14:00-16:00 цагийн зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.5, 38.1 дэх хэсэгт заасны дагуу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл болох Монголын банкны холбоо, банкуудын төлөөлөл оролцлоо.

Хэлэлцүүлгийг нээж хууль санаачлагч, УИХ-ын гишүүн Б.Баттөмөр хэлсэн үгэндээ зээлийн хүүг бууруулах, түүнийг үүсгэхэд нөлөөлж байгаа чанаргүй зээлийг шийдвэрлэх асуудал нь олон нийтийн эрх ашгийг хөндсөн тул нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудлуудын нэг болоод байгаа бөгөөд улс орнуудад банк, санхүүгийн салбарт хуримтлагдсан чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж, цаашид өсөх хандлагатай болсон нь банкнаас олгох зээлийн хэмжээг бууруулж, санхүүгийн зуучлалыг зогсонги байдалд оруулан, эдийн засгийн идэвхжилийг сулруулах, бодит секторын өсөлтийг хязгаарлах, ажилгүйдлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг удаашруулах сөрөг нөлөөтэй болохыг онцлон тэмдэглэлээ. Тиймээс эдгээр асуудлаас сэргийлэх, чанаргүй зээл, активыг шийдвэрлэх замаар банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор Актив удирдлагын компанийг байгуулах, үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх Актив удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулсан болохоо танилцууллаа. Хуулийн төслийг 6 дугаар сарын сүүлээр өргөн барих бодолтой байгаагаа хэлэлцүүлэгт оролцогчдод илэрхийлэв. Мөн хуулийн төслийн давхардсан зохицуулалтыг анхаарах, нэмэлт судалгаа хийх шаардлагатай байгааг тэмдэглээд хэлэлцүүлэгт оролцогчдыг тус хуулийн төслийн алдаа, оноо, давуу, сул талыг харамгүй хэлэхийг хүслээ.

Хуулийн төслийг танилцуулсаны дараа хэлэлцүүлэгт оролцогчдоос хэлсэн саналыг дор жагсаалаа.

Монголын банкны холбооны Хууль, эрх зүй хамтын ажиллагаа хариуцсан зөвлөх Зоригтбаатар: Банкуудаас ирсэн төлөөллийн нэрсийг танилцуулж, хуулийн төсөлд холбогдуулан дараах саналыг хэлэв.

1. Хуулийн төслийн зорилт болон хувь нийлүүлсэн хөрөнгөтэй холбоотой зарчмын хэдэн асуудал байна. Хуулийн зорилт дээр “Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах..” гэж томъёолсон боловч зөвхөн банкны салбарын чанаргүй активыг актив удирдлагын компани авахаар тусгагдсан байна. Банк санхүүгийн салбар гэдэг чинь зөвхөн банк биш тул үүн дээр анхаарна уу.
2. Актив удирдлагын тухай хуулийн төслийн 2-р зүйлд нэгэнт төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулахаар тусгасан учраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай холбоотой асуудлыг энд анхаарах хэрэгтэй. Мөн төслийн 23.1.2 дахь заалт дээр гадаад улсын төрийн актив удирдлагын компанийн оруулсан хөрөнгө хувь нийлүүлсэн хөрөнгөд байж болно гэсэн байна. Заавал төрийн өмчлөлтэй актив удирдлагын компани

байх уу? Эсвэл хувийн өмчийн актив удирдлагын компанибайх уу? Үүн дээр анхаарна уу.
3. Утга агуулгын шинжтэй ганц нэг заалт байна. Жишээ нь: 7.1.2, төслийн олон заалт дээр зөвхөн чанаргүй активтай холбоотой барьцаа хөрөнгийг зохицуулсан заалт мөн зөвхөн зээлдэгч гэсэн нэр томъёо орсон байна. Зээлдэгч болон өртэй этгээд гэсэн нэр томъёо зайлшгүй хэрэгтэй. Мөн зөвхөн авлага биш өөр төрлийн төлбөрүүд байж болно. Эдгээр дээр анхаарна уу.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлагыг тодорхой болгомоор байна.
5. Актив удирдлагын компанийг богино хугацаанд байгуулж байгаа тул тухайн хугацаанд Аж ахуй нэгжийн орлогын албан татвар зэрэг бусад татвараас чөлөөлөх талаар Улсын Их Хурлын гишүүдэд сайн ойлгуулж өгөх хэрэгтэй байна. Учир нь актив удирдлагын компани байгуулагдаад амжилттай яваа улсын жишээнээс харахад татвараас чөлөөлж байсан байна.
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог 9 болгох, гишүүн тус бүр мэргэшсэн байх шаардлага тавих,
7. Аж ахуй нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх зохицуулалт дагалдах хуульд тусгах.

Худалдаа хөгжлийн банкны эрсдэлийн удирдлагын газар, Дэлгэрмаа:

1. Чанаргүй зээлийг шилжүүлэх банкийг Монголбанк тодорхойлно гэж төсөлд заасан байна. Чанаргүй зээлийн шилжүүлэх банкинд чанаргүй активын түвшин өндөр байх гэсэн шаардлага тавих уу?
2. Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулахад актив удирдлагын компанид ямар давуу тал байх вэ? Удаан үргэлжилдэг, сунжирсан шүүхийн процессыг багасгах хэрэгтэй.

Хаан банкны Хууль эрх зүйн газрын захирал:

1. Төсөлд актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 80 хувь нь хувийн, 20 хувь нь төрийн хөрөнгө оруулалтаас бүрдэж байгаа боловч шийдвэр гаргалтад төрийн өмчийн оролцоо өндөр байна. Компанийн хуулийн зохицуулалтыг харахад засаглалын хувь нь тэнцвэргүй байна. Зарчмын хувьд буруу тогтолцоо гэж харагдаж байна. Төрийн оролцоо бага байвал зүгээр биш үү?
2. Мөн төслийг дагаж Үл хөдлөх хөрөнгийн харилцааг зохицуулсан хуульд ганц нэмэлт, өөрчлөлт орохоор байна. 10 хоногийн дотор дуудлага худалдаа явуулна гэдэг бодит байдалтай нийцэхгүй байна. Хөрөнгө хураан авсаны дараа 10 хоног гэвэл илүү бодит зохицуулалт болно.
3. Банкны бусад авлагыг хэрхэн барагдуулах вэ? Активын хувьд барьцаа хөрөнгөө хязгаарлагдахгүйгээр банкны авлага гэх зэрэг бусад зүйлсийг хаана тусгах вэ? Чанаргүй банкны авлагаа яаж барагдуулах нь тодорхой бус байна. Үүнийг хаана оруулах вэ?

Хэлэлцүүлэгт оролцогчдын асуулт, саналд хууль санаачлагч болон Монголбанкны Хууль, эрх зүйн газрын төлөөллөөс хариулт өгсөн бөгөөд хууль

санаачлагч оролцогчдын санадыг судалж, төсөлд тусгана гэснээр хэлэлцүүлэг өндөрлөлөө.

Хэлэлцүүлэгт ирсэн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл:

| № | Банк | Нэр |
|---|---|---|
| | УИХ-ын гишүүн | Б. Баттөмөр |
| 1 | Худалдаа хөгжлийн банк: | Ц.Ганбаяр |
| 2 | | Дэлгэрмаа |
| 3 | | Тунгалаг |
| 4 | Хаан банк | М.Мөнхбаатар |
| 5 | | Э.Нанзаддорж |
| 6 | | Ц.Доржнамжим |
| 7 | | Н.Энхбат |
| 8 | Голомт банк | А. Энхбаяр |
| 9 | | Хүрэлхуяг |
| 10 | | Батбилгүүн |
| 11 | | Одгариг |
| 12 | Хас банк | Мөнх-Эрдэнэ |
| 13 | | Н. Цэгц |
| 14 | Төрийн банк | Х. Лхагвасүрэн |
| 15 | | Б. Амарсанаа |
| 16 | | Н. Батгэрэл |
| 17 | | Б. Ганнасан |
| 18 | Улаанбаатар хотын банк | Т. Батжаргал |
| 19 | | Төгөлдөр |
| 20 | Чингисхаан банк | Б. Төрбадрах |
| 21 | Богд банк | М. Бямбацэрэн |
| 22 | | Г. Төгөлдөр |
| 23 | Ариг банк | Н. Хэрлэн |
| 24 | Хөгжлийн банк | Ц. Булганхишиг |

_________oOo_________

# АКТИВ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН ТОВЪЁОГ

2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр

| № | Хаанаас | Саналын утга | Саналыг тусгасан байдал | Хуулийн төслийн зүйл, заалт |
|---|---|---|---|---|
| 1 | Монголын банкны холбоо | Хуулийн зорилт дээр “Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах..” гэж томъёолсон боловч зөвхөн банкны салбарын чанаргүй активыг актив удирдлагын компани авахаар тусгагдсан байгаа тул хуулийн зорилтыг нийцүүлэх. | **Саналыг хүлээн авсан.** | 1.1.Энэ хуулийн зорилт нь банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив Удирдлагын Компани /цаашид “Актив удирдлагын компани” гэх/-ийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, хяналтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож, зохицуулахад оршино. |
| | | Актив удирдлагын тухай хуулийн төслийн 2-р зүйлд нэгэнт төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулахаар тусгасан учраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай холбоотой асуудлыг энд анхаарах хэрэгтэй. | **Саналыг тусгаагүй.** | |
| | | Мөн төслийн 23.1.2 дахь заалт дээр гадаад улсын төрийн актив удирдлагын компанийн оруулсан хөрөнгө хувь нийлүүлсэн хөрөнгөд байж болно гэсэн байна. Заавал төрийн өмчлөлтэй актив | **Саналыг хүлээн авсан.** | 27.1.2.олон улсын санхүүгийн байгууллага, гадаад улсын актив удирдлагын компанийн оруулсан хөрөнгө; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | удирдлагын компани байх уу? Эсвэл хувийн өмчийн актив удирдлагын компани байх уу? | | |
| | | Төслийн 7.1.2 дэх заалт дээр зөвхөн чанаргүй активтай холбоотой барьцаа хөрөнгийг зохицуулсан заалт, мөн зөвхөн зээлдэгч гэсэн нэр томъёо орсон байна. Зээлдэгч болон өртэй этгээд гэсэн нэр томъёо зайлшгүй хэрэгтэй. Мөн зөвхөн авлага биш өөр төрлийн төлбөрүүд байж болно | **Саналыг тусгасан.**<br><br>Актив удирдлагын компани банкны чанаргүй зээлийг шилжүүлэн авах зохицуулалтыг тусгаж, тодорхойлолтод оруулсан. | 10.1.Актив удирдлагын компани дараах үйл ажиллагаа эрхэлнэ:<br>10.1.1.энэ хуульд заасны дагуу чанаргүй зээлийг банкнаас шилжүүлэн авах;<br>10.1.2.хөрөнгө, зээл, зээлийн үндсэн хүү, гэрээнд заасан бол хэтэрсэн хугацааны хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг төлүүлэх, шаардлагатай тохиолдолд барьцаа, батлан даалт, баталгаа, фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах зэргээр банкнаас шилжүүлэн авсан чанаргүй зээлийг өмчлөх, эзэмших, удирдах, захиран зарцуулах;<br>10.1.3.банкнаас шилжүүлэн авсан чанаргүй зээлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хамгаалах талаар дараах арга хэмжээг авах: |
| | | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлагыг тодорхой болгох | **Саналыг тусгасан.** | 17.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн дараах шалгуурыг хангасан байна: |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | 17.4.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өрийн үлдэгдэлгүй байх;<br>17.4.2 эдийн засагч, эрх зүйч мэргэжилтэй;<br>17.4.3.банк, санхүү, эрх зүй, эдийн засгийн чиглэлээр тав буюу түүнээс дээш жил, удирдах албан тушаалтнаар хоёр буюу түүнээс дээш жил ажилласан байх;<br>17.4.4. гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй байх;<br>17.4.5.тохиромжтой этгээд байх. |
| | | Актив удирдлагын компанийг богино хугацаанд байгуулж байгаа тул тухайн хугацаанд Аж ахуй нэгжийн орлогын албан татвар зэрэг бусад татвараас чөлөөлөх хэрэгтэй байна. Учир нь актив удирдлагын компани байгуулагдаад амжилттай яваа улсын жишээнээс харахад татвараас чөлөөлж байсан байна. | **Саналыг тусгасан.**<br><br>Дагалдах хуулийн төсөл болон хуулийн төсөлд тусгасан. | 41.1. Актив удирдлагын компани нь хуульд заасны дагуу албан татвар, хураамж, шимтгэлээс чөлөөлөгдөнө. |
| | | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог 9 болгох, гишүүн тус бүр мэргэшсэн байх шаардлага тавих, | **Саналыг тусгаагүй.** | 17.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь долоон гишүүнтэй байх ба гурван гишүүн нь хараат бус гишүүн байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | 17.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг Монголбанк, Олон улсын санхүүгийн байгууллагаас тус тус нэр дэвшүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурал сонгоно. |
| | | Аж ахуй нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх зохицуулалт дагалдах хуульд тусгах. | **Саналыг тусгасан.**<br><br>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдах хуулийн төслийн хүрээнд боловсруулсан бөгөөд хуулийн төсөлд тусгасан. | 41.1. Актив удирдлагын компани нь хуульд заасны дагуу албан татвар, хураамж, шимтгэлээс чөлөөлөгдөнө. |
| | | Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулахад актив удирдлагын компанид ямар давуу тал байх вэ? Удаан үргэлжилдэг, сунжирсан шүүхийн процессыг багасгахгүй бол компанийн үйл ажиллагаа үр нөлөөгүй болно. | **Саналыг тусгасан.**<br><br>Актив удирдлагын компанийн нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааг хуулийн төсөлд эгүүлэн тусгасан. Уг бүлгээр компанийн нэхэмжлэлийн үнийг тодорхойлох, нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх | ДОЛДУГААР БҮЛЭГ<br><br>АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН НЭХЭМЖЛЭЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ОНЦГОЙ АЖИЛЛАГАА |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | ажиллагаа болон дуудлага худалдаатай холбоотой онцгой журмын зохицуулалтыг тусгасан. | |
| | Хаан банк | Мөн төслийг дагаж Үл хөдлөх хөрөнгийн харилцааг зохицуулсан хуульд ганц нэмэлт, өөрчлөлт орохоор байна. 10 хоногийн дотор дуудлага худалдаа явуулна гэдэг бодит байдалтай нийцэхгүй байна. Хөрөнгө хураан авсаны дараа 10 хоног гэвэл илүү бодит зохицуулалт болно. | **Саналыг тусгасан.** | 37.1.Актив удирдлагын компани энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан онцгой ажиллагааны журмаар эцэслэн гарсан шүүхийн шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор дуудлага худалдааг зохион байгуулна. |
| | | Төсөлд актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 80 хувь нь хувийн, 20 хувь нь төрийн хөрөнгө оруулалтаас бүрдэж байгаа боловч шийдвэр гаргалтад төрийн өмчийн оролцоо өндөр байна. Компанийн хуулийн зохицуулалтыг харахад засаглалын хувь нь тэнцвэргүй байна. Зарчмын хувьд буруу тогтолцоо гэж харагдаж байна. Төрийн оролцоо бага байвал зүгээр биш үү? | | |
| | | Банкны бусад авлагыг хэрхэн барагдуулах вэ? Активын хувьд барьцаа хөрөнгөө хязгаарлагдахгүйгээр банкны авлага гэх зэрэг бусад зүйлсийг хаана тусгах вэ? Чанаргүй банкны | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | авлагаа яаж барагдуулах нь тодорхой бус байна. Үүнийг хаана оруулах вэ? | | |
| | Худалдаа хөгжлийн банк | Чанаргүй зээлийг шилжүүлэх банкийг Монголбанк тодорхойлно гэж төсөлд заасан байна. Чанаргүй зээлийн шилжүүлэх банкинд чанаргүй активын түвшин өндөр байх гэсэн шаардлага тавих уу? | | |

---o0o---

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.БАТТӨМӨРИЙН САНААЧЛАН БОЛОВСРУУЛСАН АКТИВ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ЯАМДУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЪЁОГ

| № | Хаанаас | Саналын утга | Саналыг тусгасан байдал | Хуулийн төслийн зүйл, заалт |
|---|---|---|---|---|
| 1. | Монгол Улсын Шадар сайд<br><br>2019.04.16<br><br>3Г-2/281 | Таны 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 1-1/1472 дугаар албан бичгээр санал авахаар ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төсөл болон холбогдох материалыг судлан үзээд дараах саналыг хүргүүлж байна:<br><br>1.Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1-ийн "...Банкны тухай хууль," гэсний дараа "Өрийн удирдлагын тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлын тухай хууль" гэж нэмэх;<br><br>Тайлбар: Өрийн удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т "Засгийн газрын өрийн баталгаа", 3.4-т "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах, түүнийг | - Өрийн удирдлагын тухай хуулийг нэмж тусгав.<br>- Банкны салбарын тогтвортой байдлын тухай хуулийн зохицуулах харилцаанд хамаарахгүй тул уг хуулийг нэмэх шаардлагагүй. | 2.1.Актив удирдлагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Иргэний хууль[2], Төв банк /Монголбанк/-ны тухай хууль[3], Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль[4], Компанийн тухай хууль[5], Банкны тухай хууль[6], **Өрийн удирдлагын тухай хууль**[7] энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. |

---

[1]Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.
[2]Иргэний хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
[3]Төв банк /Монголбанк/-ны тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.
[4]Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2005 оны 46 дугаарт нийтлэгдсэн
[5]Компанийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.
[6]Банкны тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
[7]Өрийн удирдлагын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 9 дүгээрт нийтлэгдсэн.

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | бүртгэх" харилцааг уг хуулиар зохицуулахаар хуульчилсан. | | |
| | | 2.Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 13.5.4, 20.2.1-ийн "тохиромжтой этгээд байх" гэснийг хасч, мэргэжил, мэргэшил, ур чадвар, дадлага туршлагатай холбоотой тодорхой шаардлага, шалгуурыг зааж өгөх; | **Саналыг тусгаагүй.**<br><br>Банкны хяналт шалгалтын Базелын хороо нь төв банк, банк болон санхүүгийн нэгдлийн удирдлагад тавигдах шалгуурыг тодорхойлсон бөгөөд уг шалгуурыг тусгаснаар ТУЗ, болон гүйцэтгэх удирдлагад тавих шалгуурыг өндөрсгөх ач холбогдолтой.<br><br>"Fit and Proper Principles paper", February1999, http://www.bis.org/publ/bcbs47c4.pdf | |
| | | 3.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1-ийн "Банк Актив удирдлагын компанид өөрийн чанаргүй активын төлбөрийг шаардах, төлүүлэх, хөрөнгө худалдан борлуулах зэргээр активыг шийдвэрлэх эрхийг олгож болно." гэснийг "Банк өөрийн чанаргүй активын төлбөрийг шаардах, төлүүлэх, хөрөнгө худалдан борлуулах зэрэг активыг шийдвэрлэх эрхийг Актив удирдлагын компанид олгож болно." гэж өөрчлөн | **Саналыг тусгасан.** | 12.1.Банк нь өөрийн чанаргүй зээлийн төлбөрийг төлүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах эрхийг Актив удирдлагын компанид шилжүүлж болно. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | найруулах; | | |
| | | 4.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3-т "...зөвлөлийн хараат бус гишүүнд.., Азийн хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпорац тус тус нэр дэвшүүлэх"-ээр заасныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нягтлах; | **Саналыг тусгасан.**<br>Олон улсын байгууллагын оролцоог судлах. | 17.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг Монголбанк, Олон улсын санхүүгийн байгууллагаас тус тус нэр дэвшүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурал сонгоно. |
| | | 5.Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 20 хувийг төрөөс бүрдүүлэх"-ээр заасантай холбогдуулан эрсдэлээс хамгаалах үүднээс Компанийн хөрөнгийн үнийн дүнгийн доод хязгаарыг зааж өгөх; Тайлбар: Актив удирдлагын компани нь үндсэн үйл ажиллагаанаас гадна өрийн хэрэгсэл гаргах, зээл авах, хөрөнгө оруулалт хийх, бусад эх үүсвэрээс санхүүжилт авах эрхтэй байхаар хуулийн төсөлд тусгасан байх тул учирч болох аливаа эрсдэлийг даах чадвартай байх шалгуур буюу ББСБ /2.0 тэрбум төгрөг/, Арилжааны банк /50.0 тэрбум төгрөг/-ны дүрмийн сантай уялдуулан компанийн хөрөнгийн үнийн доод үнийн хязгаарыг 10.0-20.0 тэрбум | **Саналыг тусгаагүй.**<br>Монголбанк, Сангийн яам хамтран өөрийн хөрөнгийн доод хэмжээг тогтооно. Уг хэмжээг хуульчлах тохиолдолд өөрчлөх шаардлага үүсэх бүр хуульд өөрчлөлт оруулах, цаг хугацаа алдах эрсдэл үүснэ. | 27.3.Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь энэ хуулийн 27.1-д заасан эх үүсвэрээс оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээг эдийн засгийн байдал, мөнгөний ханшны өөрчлөлт, Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | төгрөгөөр тогтоож болох зэргийг судалж шийдэх. | | |
| | | 6.Хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Актив удирдлагын компани нь... өрийн хэрэгсэл гаргаж болно.”, 25.2-т “...өрийн хэрэгсэлд Засгийн газар баталгаа гаргаж болно.”, 27 дугаар зүйлийн 27.1.2-т “Засгийн газрын үнэт цаас болон Засгийн газрын баталгаа гаргасан бусад үнэт цаас” гэж тус тус заасныг Өрийн удирдлагын тухай хуультай уялдуулах.<br>Тайлбар: Өрийн удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “бүх төрлийн зээл, үнэт цаас болон өр үүсгэх аливаа гэрээ, хэлцлийг өрийн хэрэгсэл”-д хамааруулсан бөгөөд Засгийн газар баталгаа гаргасан тохиолдолд Өрийн удирдлагын тухай | **Саналыг тусгасан.** | 31.1.2.Засгийн газрын үнэт цаас болон Засгийн газрын өрийн баталгаа гаргасан бусад үнэт цаас; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хуулийн үйлчлэлд хамаарахаар заасныг харгалзан үзэх шаардлагатай байгаа зэрэг болно. | | |
| 2. | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд<br><br>2019.04.10-01/2242 | Таны 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1-1/1472 дугаартай "Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төсөлд санал ирүүлэх тухай" албан бичигтэй танилцлаа.<br><br>Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан "Актив удирдлагын тухай" хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно. | Тусгайлан өгөх саналгүй | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3. | Батлан хамгаалахын сайд<br><br>2019.04.16-1а/1382 | Актив удирдлагын тухай хуулийн төсөлтэй танилцаад дараахь саналыг хүргүүлж байна.Үүнд:<br><br>1.Хуулийн төслийн 3 дугаар зүйлд "Активын удирдлага" гэсэн нэр томьёог тодорхойлж, нэмж тусгах; | **Саналыг тусгасан.**<br><br>Уг хуулиар зөвхөн нэг хуулийн этгээд буюу Актив удидлагын компанийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд үйл ажиллагааны хүрээг илүү тодорхой болгосон. | 1.1.Энэ хуулийн зорилт нь банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив Удирдлагын Компани /цаашид "Актив удирдлагын компани" гэх/-ийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, хяналтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож, зохицуулахад оршино. |
| | | 2.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.8, 8.12 дахь хэсгүүд нь агуулга зарчмын хувьд ижил байх тул хуулийн төсөлд нэгтгэн тусгах. | **Саналыг тусгасан.** | 11.7.Актив удирдлагын компани нь банкнаас чанаргүй зээлийг шилжүүлэхэд, эсхүл тус компани чанаргүй зээлийг бусад этгээдэд шилжүүлэхэд зээлдэгч болон барьцаа, батлан даалт, фидуцийн зүйлийн өмчлөгч, эзэмшигчээс зөвшөөрөл авахгүй. |
| 4. | Гадаад харилцааны сайд<br><br>2019.04.24-09/2363 | Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төслийг дэмжиж байна. | Тусгайлсан санал ирүүлээгүй. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5. | Сангийн сайд<br><br>2019.04.22-6/2423 | Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төсөл, холбогдох бусад баримт бичигтэй танилцаад дараах саналтай байна.<br><br>**Хоёр. Хуулийн төслийн талаар**<br>2.1 Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгээс "Монгол Улсын" гэснийг хасах; | **Саналыг тусгаагүй.**<br><br>УИХ-ын 2015 оны 93 дугаар тогтоол, 2016 оны 68 болон 71 дүгээр тогтоолуудаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд актив удирдлагын мэргэшсэн институцыг байгуулахыг Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан байдаг. Уг хуулийн дагуу байгуулагдах Актив удирдлагын компани нь хуулийн дагуу тусгайлсан чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлэх, тодорхой хугацаанд үйл ажиллагаагаа явуулах /байгуулагдсан цагаасаа хойш 10 жил/ зорилго бүхий Монгол Улсын хэмжээнд зөвхөн нэг байгуулагдах мэргэшсэн хуулийн этгээд байх учраас Монгол Улсын | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | гэсэн тодотголтой Актив удирдлагын компани байна гэж үзэж байна. | |
| | | 2.2 Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "...төрийн өмчийн оролцоотой..." гэж заасныг "...төрийн өмчийн оролцоогүй..." гэж өөрчлөх; | **Саналыг тусгаагүй.**<br>Уг компанийг улсын төсөвт нэмэлт дарамт үзүүлэхгүйгээр төрийн өмчийн оролцоог хангах боломжтой. | |
| | | 2.3 Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг хасах; | **Саналыг тусгасан.** | |
| | | 2.4 Төслийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгээс "...санхүү, төсвийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн..." гэснийг хасах; | **Саналыг тусгасан.** | 5.7. Актив удирдлагын компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвшөөрснөөр хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана. |
| | | 2.5 Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.5 хэсгээс "...санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага..." гэснийг хасах; | **Саналыг тусгасан.** | 5.8.Актив удирдлагын компанийг өөрчлөн байгуулах, Дампуурлын тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр татан буулгах, тус компани татан буугдах үед актив удирдлагын компанийн хөрөнгийг шийдвэрлэхтэй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | холбогдох харилцааг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан журмаар зохицуулна.<br><br>30.2 хасагдсан.<br><br>40.4.Актив удирдлагын компани, түүний үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө, санхүүжилт, хяналт шалгалт, түүний үйл ажиллагаанд холбогдох журмыг Санхүүгийн зохицуулах хороо дангаар буюу Монголбанктай хамтран батална. |
| | | 2.6 Төслийн 4 дүгээр зүйлийн 4.6-г "Актив удирдлагын компани дүрэмтэй байх бөгөөд дүрмийг Монголбанкны Ерөнхийлөгч зөвшөөрсөнөөр хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж холбогдох байгууллагад бүртгүүлэх." гэж өөрчлөх; | **Саналыг тусгасан.** | 7.1. Актив удирдлагын компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг батлах шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвшөөрснөөр хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана. |
| | | 2.7 Төслийн 4 дүгээр зүйлийн 4.7.8 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.5.5 дахь | **Зарим саналыг тусгасан.** | Хуучин 4.7.8 дахь заалт 7.2.7 болсон бөгөөд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | заалт, 23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалтад тус тус заасан "бусад" гэсний оронд нарийвчилсан зохицуулалтыг тусгах; | Тухайлбал нарийвчилсан бүхий л зохицуулалтыг хуульд тусгах боломжгүй бөгөөд хуульд нийцсэн буюу илүү өндөр шаардлага бүхий бусад зохицуулалтыг тусгах боломжтой байхаар зохицуулсан. | Компанийн тухай хуульд нийцсэн.<br><br>Хуучин 8.5.5 дахь заалт 11.4.7.Энэ хуулийн дагуу Монголбанк шаардлагатай гэж үзсэн бусад.<br><br>Хуучин 8.5.5 дахь заалт 27.1.3 тус тус болж өөрчлөгдсөн. |
| | | 2.8 Төслийн 6 дугаар зүйлийг бүхэлд нь хасах; | **Саналыг тусгасан.** | Актив удирдлагын сангийн тухай бүлгийг хассан |
| | | 2.9 Төслийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг буюу "Актив удирдлагын компани энэ хуульд заасан үйл ажиллагаа эрхлэх хүрээнд чанаргүй активт холбогдох тайлан, мэдээг уг активыг шилжүүлсэн банкнаас, баримт бичгийг холбогдох иргэн, хуулийн этгээд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргуулан авах эрхтэй." гэснийг хасах; | **Саналыг тусгасан.**<br><br>Өөрчлөн найруулсан | 10.3.Актив удирдлагын компани энэ хуульд заасан үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ чанаргүй зээлд холбогдох тайлан, баримт мэдээллийг холбогдох банк, иргэн, хуулийн этгээд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргуулан авах эрхтэй. |
| | | 2.10 Хуулийн төсөлд эсвэл хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан "Актив удирдлагын компанид чанаргүй активыг шилжүүлэх банкийг тодорхойлох журам"-д чанаргүй активыг шилжүүлэх үйл ажиллагааны зардал болон зардлыг хариуцах | **Журмаар зохицуулах.** | 11.10.Монголбанк энэ хуулийн 11.2-т заасныг үндэслэн Актив удирдлагын компанид шилжүүлэх чанаргүй зээл, шилжүүлэх банкыг тодорхойлохтой |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | этгээдийг тодорхойлох зохицуулалтыг тусгах; | | холбоотой журмыг батална. |
| | | 2.11 Хуулийн төсөлд Актив удирдлагын компани банкнаас чанаргүй активыг шилжүүлэн авах зарчмыг тодорхойлоогүй тул Актив удирдлагын компани чанаргүй активыг банкнаас шууд төлбөртэйгөөр худалдан авахгүй байх нарийвчилсан зохицуулалтыг хуулийн төсөлд эсвэл "Актив удирдлагын компанид чанаргүй активыг шилжүүлэх банкийг тодорхойлох журам"-д тусгах; | **Журмаар зохицуулах.** | 11.10.Монголбанк энэ хуулийн 11.2-т заасныг үндэслэн Актив удирдлагын компанид шилжүүлэх чанаргүй зээл, шилжүүлэх банкыг тодорхойлохтой холбоотой журмыг батална. |
| | | 2.12 Төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй байх нь актив хөрөнгийг шилжүүлж авахаас татгалзах үндэслэл болох агуулга бүхий зохицуулалтыг шинээр нэмэх; | **Саналыг тусгасан.** | 11.11. Актив удирдлагын компани нь энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр банкны чанаргүй зээлийг шилжүүлэн авахыг хориглоно. |
| | | 2.13 Төслийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэг буюу "Актив удирдлагын компани чанаргүй активын зах зээлийн бодит үнийг тогтоох, уг үнийг хямдруулах бодлого, журам тогтоон мөрдөж болно." гэснийг хасах; | **Саналыг тусгаагүй.**<br><br>Чанаргүй зээлийн үнийг үр дүнтэй тогтоох, чанаргүй зээлийг хямдруулахад мөрдөх аргачлал, журмыг тогтоон мөрдөх нь Компанийн үйл ажиллагааг ашигтай ажиллах зарчимд | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | нийцүүлэхэд ач холбогдолтой. | |
| | | 2.14 Төслийн 8 дугаар зүйлийн 8.12-т "Актив удирдлагын компани банкнаас чанаргүй актив шилжүүлэн авахад эсхүл тус компани чанаргүй активыг бусад этгээдэд худалдахад зээлдэгчийн зөвшөөрлийг авахгүй." гэсэн хэсгийг хасах; | **Саналыг тусгаагүй.**<br>Зээлдэгч зөвшөөрөл өгөхгүй тохиолдолд тухайн чанаргүй зээлийг банк, компани аль аль нь шийдвэрлэх боломжгүйгээр үлдэх, улмаар чанаргүй зээл нэмэгдэх эрсдэлтэй. | |
| | | 2.15 Төслийн 11 дүгээр зүйлд "татварын байгууллага татварын хяналт, шалгалт хийх зорилгоор, эсхүл Монгол Улсын Засгийн газар гадаад улс орнуудтай татварын зорилгоор мэдээлэл харилцан солилцох зорилгоор мэдээлэл авах хүсэлт гаргасан бол" гэсэн 11.1.5 дахь заалт нэмэх; | **Саналыг тусгасан.** | 14.2.5. Татварын байгууллага татварын хяналт, шалгалт хийх зорилгоор, эсхүл Монгол Улсын Засгийн газар гадаад улс орнуудтай татварын зорилгоор мэдээлэл харилцан солилцох зорилгоор мэдээлэл авах хүсэлт гаргасан. |
| | | 2.16 Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "Актив удирдлагын компани Засгийн газрын баталгаа гаргасан эх үүсвэрийг бүрэн төлж барагдуулахаас өмнө аливаа хэлбэрээр ногдол ашиг хуваарилахыг хориглоно." гэсэн хэсгийг хасах; | **Саналыг тусгаагүй.** | Өрийн удирдлагын тухай хуулийн 33.4 дэх хэсэгт заасны дагуу АУК-ийн хүсэлтийн дагуу Засгийн газрын өрийн баталгаа гаргасан тохиолдолд тухайн баталгаа гаргасан эх үүсвэрийг бүрэн төлж |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | барагдуулах хүртэл ногдол ашиг хуваарилахыг хориглосон зохицуулалт юм. |
| | | 2.17 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг тус тус хасах; | **Саналын зарим хэсгийг тусгасан.**<br><br>12.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж 27.1.1-т оруулсан.<br><br>13.3 дахь хэсгийг мөн өөрчлөн найруулж 17.2 дахь хэсэгт оруулсан. | 27.1.1.Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын иргэн, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө,<br><br>17.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг Монголбанк, Олон улсын санхүүгийн байгууллагаас тус тус нэр дэвшүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурал сонгоно. |
| | | 2.18 Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх хэсэгт заасан "төр, бусад этгээдээс хувь нийлүүлсэн хөрөнгө" гэснийг "хувь нийлүүлсэн хөрөнгө" гэж өөрчлөх; | **Саналыг тусгаагүй.**<br><br>Заалтыг өөрчлөн найруулсан | 27.1.1.Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын иргэн, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, |
| | | 2.19 Төслийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн | **Саналыг тусгаагүй.** | Өрийн удирдлагын тухай хуулийн 33.4 дэх хэсэгт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 25.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийг тус тус хасах; | | заасны дагуу АУК-ийн хүсэлтийн дагуу Засгийн газрын өрийн баталгаа гаргасан тохиолдолд тухайн баталгаа гаргасан эх үүсвэрийг бүрэн төлж барагдуулах хүртэл ногдол ашиг хуваарилахыг хориглосон зохицуулалт юм.<br><br>29.3.Энэ хуулийн 29.1-д заасан өрийн хэрэгсэлд Засгийн газар баталгаа гаргаж болно.<br><br>29.4.Энэ хуулийн 29.3-т заасны дагуу Актив удирдлагын компанийн өрийн хэрэгсэлд Засгийн газар баталгаа гаргахад энэ хуулийн 29.2-д заасан хязгаарлалт хамаарахгүй. |
| | | 2.20 Төслийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтад заасан "Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл авсан, зээлжих зэрэглэл тогтоодог олон улсын **болон дотоодын байгууллагаар** үнэлгээ хийлгэсэн банк, хөрөнгө оруулалтын санд байршуулах" гэж өөрчлөх; | **Саналыг тусгаагүй.** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 2.21 Төслийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтад "Төв банкны үнэт цаас" гэж нэмэх; | **Саналыг тусгасан.** | 31.1.3. Монголбанкны үнэт цаас; |
| | | 2.22 Төслийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийг хасах; | **Саналыг тусгасан.**<br>6 дугаар бүлгийг бүхэлд нь хассан. | |
| | | 2.23 Төслийн 32 дугаар зүйлийн 32.2, 32.3 дахь хэсэгт тус тус заасан санхүүгийн тайлан гаргах болон хөндлөнгийн аудит хийлгэх хугацааг Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай хуульд нийцүүлэн өөрчлөн найруулах; | **Саналыг тусгасан.**<br>Аудитын тухай хууль<br>10.2.3.банк жилийн эцсийн санхүүгийн тайланг дараагийн санхүүгийн жилийн 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор; | 32.3.Актив удирдлагын компанийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу гарган аудит хийлгэж, үр дүнг өөрийн цахим хуудсанд байршуулж, нийтэд ил тод мэдээлнэ. |
| | | 2.24 Актив удирдлагын компанийн санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд төрийн аудит хийх тухай төслийн 34 дүгээр зүйлийг бүхэлд нь төслөөс хасах; | **Саналыг тусгаагүй.**<br>Төрийн аудитын тухай хуульд зааснаар төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны гүйцэтгэлд төрийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах зохицуулалттай байна. | |
| | | 2.25 Төслийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн Актив удирдлагын компанийн нягтлан бодох бүртгэлийн | **Саналыг тусгасан.** | 32.2.Актив удирдлагын компанийн нягтлан бодох бүртгэлийн тусгай журам, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | тусгай журам, санхүүгийн тайланд тавих шаардлагыг хамтран батлах этгээдэд “санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж нэмэх; | | тус компанийн санхүүгийн тайланд тавих шаардлагыг Монголбанк, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална. |
| | | 2.26 Төслийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийг “Актив удирдлагын компани, түүний үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө, санхүүжилт, хяналт шалгалт, актив удирдлагын сан, түүний үйл ажиллагаанд холбогдох журмыг Санхүүгийн зохицуулах хороо дангаар буюу Монголбанк, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.” гэж өөрчлөн найруулах. | **Саналыг тусгасан.** | 40.4.Актив удирдлагын компани, түүний үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө, санхүүжилт, хяналт шалгалт, түүний үйл ажиллагаанд холбогдох журмыг Санхүүгийн зохицуулах хороо дангаар буюу Монголбанк, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална. |
| 6. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд<br>2019.04.15-1/1127 | Актив удирдлагын тухай хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно. | **Тусгайлан санал өгөөгүй.** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7. | Барилга, хот байгуулалтын сайд | | | |
| 8. | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд<br><br>2019.04.15-1а/2977 | Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан “Актив удирдлагын тухай” хуулийн төсөлтэй танилцлаа.<br><br>Тусгайлан өгөх саналгүй болно. | **Тусгайлан санал өгөөгүй.** | |
| 9. | Зам, тээврийн хөгжлийн яам<br><br>2019.04.24-01/2014 | Хууль зүй, дотоод хэргийн сайд Таны 1-1/1472 тоот албан бичгээр ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан “Актив удирдлагын тухай” хуулийн төсөлд дараах саналтай байна.Үүнд:<br><br>1. Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.2-д “Хөрөнгө, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг төлүүлэх, шаардлагатай тохиолдолд барьцаа, эрсдэлийн сангаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах зэргээр банкнаас шилжүүлэн авсан чанаргүй зээлийг өмчлөх, эзэмших, удирдах, захиран зарцуулах” гэсэн нь мөн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3-д “Зээлийн барьцаа хөрөнгийг худалдан борлуулах, захиран зарцуулах эзэмшилдээ авах, санхүүжүүлэх барьцаа хөрөнгөөр үүргийн | **Саналыг тусгасан.**<br><br>7.1.3.г-д заасан заалтыг хасаж, 7.1.2 дахь заалтыг өөрчлөн найруулсан. | 10.1.2.хөрөнгө, зээл, зээлийн үндсэн хүү, гэрээнд заасан бол хэтэрсэн хугацааны хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг төлүүлэх, шаардлагатай тохиолдолд барьцаа, батлан даалт, баталгаа, фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах зэргээр банкнаас шилжүүлэн авсан чанаргүй зээлийг өмчлөх, эзэмших, удирдах, захиран зарцуулах; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | гүйцэтгэлийг хангуулах" гэж заасантай агуулгын хувьд нэг утга санаа илэрхийлэн давхцаж байгааг анхаарах; | | |
| | | 2. Хуулийн төслийн 3 дугаар зүйл "Хуулийн нэр томьёоны тодорхойлолт"-д "Актив" гэсэн нэр томьёог нэмж тусгах; | **Саналыг тусгаагүй.**<br><br>Чанаргүй зээлийн талаарх тодорхойлолтыг тусгасан. | 4.1.3."чанаргүй зээл" гэж Монголбанк, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан журмаар тодорхойлсныг. |
| | | 3. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.7-д "Актив удирдлагын компанийн дүрэмд дараах зүйлийг тусгана" гэж заасан нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан "Компанийн дүрэм" гэсэн заалттай давхцаж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор өөр хуульд байгаа, эсхүл тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ" гэж заасантай нийцүүлэн эшлэл хийх зэрэг болно. | **Саналыг тусгаагүй.**<br><br>Уг хууль нь тусгайлсан чиг үүрэг гүйцэтгэх, давуу эрх бүхий, хуульд заасан тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулж дуусгах хуулийн этгээдтэй холбогдох харилцааг зохицуулсан тул бусад хууль тогтоомж буюу бусад нийтлэг харилцааг зохицуулсан суурь хуультай шууд холбоогүй, "бие даасан" хууль юм. | |
| 10. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд<br><br>2019.04.05- 01/1216 | Монгол Улсын Их хурлын гишүүн Б.Бөттөмөрийн санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төсөл, холбогдох | **Тусгайлан санал өгөөгүй.** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | материалтай танилцлаа.<br>Тогтоолын төсөлд тусгайлан өгөх саналгүй, зарчмын хувьд дэмжиж байна. | | |
| 11. | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд<br><br>2019.04.23-01/1608 | Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан "Актив удирдлагын тухай" хуулийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br><br>1. Тус хуулийн төслийн 4 дүгээр бүлэг "Активын удирдлагын компани"-ийн эрх зүйн зохицуулалтууд нь Компанийн тухай хуульд заасан компанийн дүрэм, төлөөлөн удирдах зөвлөл, бусад хороодын үйл ажиллагааг хуультай давхцуулан заасан заалтууд байх бөгөөд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлтэй зөрчилдөж байна. | **Саналыг тусгаагүй.**<br><br>Уг хууль нь тусгайлсан чиг үүрэг гүйцэтгэх, давуу эрх бүхий, хуульд заасан тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулж дуусгах хуулийн этгээдтэй холбогдох харилцааг зохицуулсан тул бусад хууль тогтоомж буюу бусад нийтлэг харилцааг зохицуулсан суурь хуультай шууд холбоогүй, "бие даасан" хууль юм. | |
| | | 2. Хуулийн төслийн 4.1-д Активын удирдлагын компанийг "хязгаарлагдмал хариуцлагатай компани" байхаар, хуулийн төслийн 12.2-д "хувьцаа эзэмшигч нь Монгол улсын Засгийн газар болон бусад этгээд байна" гэж тус тус заасан нь Компанийн тухай хуулийн 5.1-д заасан "Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн байгуулах үеийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50- | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | аас дээшгүй байна" гэсэн заалтыг хангахгүй байна. | | |
| | | 3. Мөн хуулийн төслийн 4.3-д "Актив удирдлагын компанийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрснөөр хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана" гэж заасан нь шууд хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд нөлөөлж, тус хуулийн төслийн 12.2 –д заасан компанийн удирдах эрх бүхий дээд байгууллага "хувьцаа эзэмшигчдийн хурал байна" гэсэн, мөн тус хуулийн төслийн 5.1.2-д заасан компанийн "хараат бус байх" зарчим, 6 дугаар зүйлийн" компанийн бие даасан байдал" гэсэн тус тус заалттай зөрчилдөж байна. | | |
| | | 4. Хуулийн төслийн 4.5-д компанийн үйл ажиллагаа явуулах хугацааг "10 жил" гэж заасан нь Компанийн тухай хуулийн 8.5 дахь заалттай зөрчилдөж байна. | | |
| | | 5. Хуулийн төслийн 7.1-д заасан компанийн үйл ажиллагаа нь зөвхөн дан ганц банкны чанаргүй активыг шилжүүлэн авахаар заасан нь хэт | Монгол Улсын санхүүгийн салбарын 95 хувийг банкны салбар дангаараа эзэлдэг бөгөөд банкны | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хязгаарлагдмал байна. Бусад банк бус санхүүгийн байгууллага, зээлийн үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудын "чанаргүй актив"-ууд хэрхэн зохицуулах талаар зохицуулалтын заалт байхгүй байна. | салбарт хуримтлагдаад байгаа чанаргүй зээлийг богино хугацаанд, үр нөлөөтэйгээр шийдвэрлэх нь энэхүү хуулийн зорилгод нийцэж байгаа тул санхүүгийн бусад салбарт байгаа чанаргүй зээлийг энэ хуулийн хүрээнд зохицуулахгүй юм. | |
| | | 6. Хуулийн төслийн 8.4, 8.5-д заасан чанаргүй активыг шилжүүлэн авах нөхцөл, шаардлага хэт өндөр байгаа нь цаашид банкууд зээлийн барьцаа хөрөнгийг зах зээлийн үнээс доогуур үнэлэх нөхцөлийг бүрдүүлж, зээлдэгч нарт дарамт учруулахаар байна. | Актив удирдлагын компанийн үйл ажиллагааг үр нөлөөтэй, ашигтай байх зарчимд нийцүүлэх үүднээс чанаргүй активыг шилжүүлэн авах нөхцөл шаардлагыг тодорхой болгох үүднээс тусгасан зохицуулалт бөгөөд зээлдэгч нарт нэмэлт дарамт учруулахгүй. Харин чанаргүй зээлийн хэмжээ буурснаар зээлтэй холбоотой банкны зардал буурч хүртээмж өргөсөх үр дагавартай. | 11.2.Актив удирдлагын компанийн банкнаас шилжүүлэн авах чанаргүй зээлд дараах шаардлага тавигдана: |
| | | 7. Хуулийн төслийн 8.12 дахь заалт нь Үндсэн хууль, Иргэний тухай хуультай зөрчилдөж байна. | Үндсэн хууль, Иргэний хууль зөрчихгүй. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 8. Хуулийн төслийн 5 дугаар бүлгийг бусад холбогдох хуулиудтай нийцүүлэх нь зүйтэй байна.<br><br>Мөн Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2018 онд “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-ийг баталсан. Тус стартегид “Монголд чанаргүй активын зах зээл хөгжөөгүй гол шалтгаан нь зээлийн өр төлбөр барагдуулах ажиллагааны үр ашиггүй байдал юм. Тус ажиллагаа нь сунжирсан, таамаглах аргагүй, өрийн бүтцийн өөрчлөлт бараг байхгүй. Монголын нөхцөлд хөрөнгө оруулагчид чанаргүй зээлийн багцад доогуур үнэ санал болгох юмуу арилжаанд оролцохоос бүүр татгалзана. Чанаргүй зээлийг шийдвэрлэх илүү олон сонголт бий болгох нь зах зээлийг дэмжих ач холбогдолтой. Чанаргүй активыг худалдах арга хэрэгсэл нь бусад арга хэрэгсэл болох өр төлбөрийг албадан барагдуулах болон дампуурлын ажиллагаа үр ашигтай ажиллаж байгаа үед үр дүнтэй байдаг. Чанаргүй активыг худалдах арга хэмжээ нь бусад бүх аргын хамгийн сүүлчийнх байх бөгөөд банк тухайн активыг тэнцлээсээ бүрэн салгаж байгаа боловч банкны | Бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | системийн хувьд сөрөг нөлөөтэй асуудал нь хэвээр үлдэж, бодит эдийн засагт шийдэгдээгүй асуудал хэвээр хоцорно. Иймд хууль, эрх зүй, шүүх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, дуудлага худалдаа, дампуурал зэрэг бусад арга хэрэгсэл бүрэн шинэчлэгдээгүй тохиолдолд активыг худалдах, Актив удирдлагын компанид шилжүүлэх нь бүрэн шийдэл биш болохыг анхаарах шаардлагатай. Актив удирдлагын компанийг байгуулах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхдээ банк, Актив удирдлагын компани аль аль нь эдийн засгийн утга учиртай харилцаатай байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал. Актив удирдлагын компанийг байгуулж, банкны системийн чанаргүй активын зогсоол бус, хамгийн сүүлийн буюу банк алдагдлаа хүлээсний дараах шийдлийн сүүлийн сонголт хэлбэрээр байгуулах нь зүйтэй. Чанаргүй зээлийг Актив удирдлагын компанид шилжүүлэх нь "төвлөрсөн" шийдэл бөгөөд банкнууд болон захын бусад оролцогчийн хоорондын арилжаанд тулгуурласан зах зээлийн шийдлээс ялгаатай юм. Чанаргүй зээлийг борлуулахад тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, зах зээл бүх хөрөнгө оруулагчдад (тухайлбал, гадаадын) нээлттэй байх, зээлдэгчдийг хамгаалсан үйлчилгээний үүрэг | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хариуцлага, нөхцөлийг зохицуулах шаардлагатай" гэж тусгасан байна. | | |
| | | 9. Хуулийн төсөл нь зөвхөн нэг компанийн үйл ажиллагааг зохицуулсан, хэт давуу талыг бий болгосон, тусгайлсан хуулийн төсөл болсон байх бөгөөд хуулийн нэртэйгээ зохицохгүй байгаа тул хуулийн төслийг сайтар судалж, боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна. | **Саналыг тусгасан.**<br><br>Уг хууль нь банкны чанаргүй зээлийн удирдлагын тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх нэг хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулж байгаа тул хуулийн нэрийг өөрчилсөн. | АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН ТУХАЙ<br><br>1.1.Энэ хуулийн зорилт нь банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив Удирдлагын Компани /цаашид "Актив удирдлагын компани" гэх/-ийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, хяналтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож, зохицуулахад оршино. |
| 12. | Эрүүл мэндийн сайд | - | | |
| 13. | Эрчим хүчний сайд<br><br>2019.04.16-1а/1456 | Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төсөлд санал авахаар ирүүлсэнтэй танилцлаа.<br><br>Хуулийн төслийг дэмжиж байна. Тусгайлан өгөх саналгүй болно. | **Тусгайлан санал өгөөгүй.** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 14. | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга | - | | |

---o0o---

WWW.PARLIAMENT.MN

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хэлэлцүүлэг | Тусламж

# Актив удирдлагын тухай хуулийн төсөл

Байнгын хороогоор төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх > Нэгдсэн хуралдаанаар төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх > Байнгын хорооны анхны хэлэлцүүлэг > Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэг > Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлэг > Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэг

Төслийн файлыг татах

Share 10 | Tweet

ТӨСЛИЙН ХАВСРАЛТУУД

1. Үзэл баримтлал
2. Танилцуулга
3. Судалгаа, лавлагаа, тооцоо, бусад мэдээлэл
4. Дагалдах хууль, тогтоолын төсөл

САНАЛ АСУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөлд санал өгнө үү?

| | |
|---|---|
| ДЭМЖИНЭ | 68% |
| ДЭМЖИХГҮЙ | 22% |
| МЭДЭХГҮЙ | 8% |

Санал өгөх

ИДЭВХИТЭЙ

› Үсчы тухай хуульд нэмэлт оруулах тухай

› Экспортын ээлийн ерөнхий хэлэлцээрийн төсөл соёрхон батлах тухай

Мессеж үлдээх